Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 9 САР. №14 (072)

ЭДИЙН ЗАСАГ
МОДОО БАРЬСАН ЗУУН ЖИЛ

ЭДИЙН ЗАСАГ
ХӨГЖИЛ ӨӨД ХҮЧИРХЭГ ХӨРШИЙН ХАМТ

ЭДИЙН ЗАСАГ
ГЭРЭЛ АСНА, ГЭХДЭЭ...

WWW.MONGOLIANECONOMY.MN











ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСГИЙН ГАЗАР ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

TDB ONLINE

Үргэлж нээлттэй



ШИНЭ ХАРИЛЦАГЧИД ЭХНИЙ ЖИЛ ХУРААМЖГҮЙ

2014.09.30-ныг дуустал

Та УТАСГҮЙ ИНТЕРНЭТ КЕВИКО сүлжээнд үнэгүй нэвтрэн
TDB Online үйлчилгээгээ ашиглаарай.

Утас: 1900-1977 | Мессеж: 133133 | И-мэйл: info@tdbm.mn | Веб хаяг: www.tdbm.mn | Facebook: www.tdbm.mn/facebook
Twitter: www.tdbm.mn/twitter | Viber: +976 99001977 | Skype: tdb_info | Yahoo: info_tdb@yahoo.com

PRO one SMART OFFICE

DEVELOPMENT BY MASTER PROPERTIES LLC

ХОТЫН ТӨВД

ТҮРЭЭСИЙН ҮНЭЭР ОФФИС-ТОЙ БОЛОХ ШААНС ХӨТӨЛБӨР



Бизнес эрхлэгчдэд зориулан түрээсийн үнэтэй дүйцэх төлбөр төлөөд өөрийн оффистой болох боломжийг санал болгож байна

Зөвхөн 15 байгууллагад

БОДИТ СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН БҮТЭЭВ

Нийт 150 машины зогсоолтой

Ашиглалтанд: 2016 оны | улирал

Чингисийн талбайгаас чанх хойшоо 1 км зайд бизнесийн шинэ төв цэгт байршилтай

4 минут 15 минутын зайтай

Төсөл хөгжүүлэгч: MASTER DEVELOPER

Төсөл борлуулагч: MASTER PROPERTIES

24/7 9990-0181, 9990-0184

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр / 9999-4248
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал / 8800-6228
АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Теренс Эдвардс
ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:
Лиззи Хүү
ОРЧУУЛАГЧ:
Р.Гантулга
ВЭБ РЕДАКТОР:
Б.Энхцэцэг
СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Э.Зоригт
Б.Үүрийнтуяа
С.Батзаяа
ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь
МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Барианжав / 9409-2904

“ECONOMY” ТВ СТУДИ
СЭТГҮҮЛЧ:
Ц.Соёлмаа
ЗУРАГЛААЧ:
Ш.Гантуул
КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:
Т.Баярсайхан

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.
VI хороо, Их сургуулийн гудамж.
AB center. 503 тоот
15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn
Утас/Факс: 976 - 7011 5476
“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Сайн байцгаана уу. Сэтгүүлийнхээ захиалагч, уншигчидтайгаа мэндчилж байгаадаа баяртай байна. Намрын шар нар хэдийнэ ээж эхэлсэн ч монголчууд бид налгар намарт налайн суухгүйгээр их ажлыг амжуулах цаг иржээ.

Төр, засгаас эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдэх, үүссэн нөхцөл байдлыг богино хугацаанд сайжруулахад түлхүү анхаарч хурдацтай ажиллах шаардлага байгаа бол хувийн хэвшлийнхэнд улам их тэсвэр тэвчээртэй, бэрхшээлийг даван туулахын төлөө явах, иргэдийн хувьд намар, өвлийн бэлтгэлээ хангах зэрэг дор бүрнээ идэвхтэй, эрчимтэй, ажил амьдралаа сайжруулах, дээшлүүлэхийн төлөө ажиллах болж байна. Өөрөөр хэлбэл, зуны аялал зугаалгын улиралд эдийн засгийн хүндрэлийг умартан амарсан бол одоо ирэх цагийн аяс өмнөхөөс илүү ажиллаж, мэрийх, хамтаараа асуудлыг шийдэх, даван туулах нөхцөлийг бий болгож байна.

Улс төрийн шийдвэрүүд эдийн засагт шууд нөлөөлж, өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй байдлыг дээрдүүлж чадахгүй байгаад арга зам, гарц шийдэл хайж шинэхэн дугаарынхаа онцлох нийтлэлүүдээр хөндлөө. Эдийн засгийн өдгөөгийн хүндрэлтэй байдал нь гадаад зах зээл гэхээсээ илүү улс төрийн дотоод хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байгаа тул дотоод, гадаадын улс төр, эдийн засаг, бизнесийн нэр нөлөөтэй хүмүүс манай сэтгүүлд ярилцлага өгөхдөө эдийн засгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх, зөв хөгжлийг бий болгох талаар нэлээд сургамжтай зүйлүүд хэлж ирсэн билээ. Тиймээс бид бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдыг ухаарал, сургамж аваасай гэдэг үүднээс өнгөрсөн хугацаанд манай сэтгүүлд зочилсон хүмүүсийн онцолж хэлсэн үгнүүдээс ишлэн хүргэж байна.

Мөн өнөөгийн улс төрийн намуудын хөгжил улс орны эдийн засгийг хөгжүүлэх биш, чөдөр тушаа болж байгаа учраас энэ чиглэлээр нийтлэл, ярилцлага оруулаа. Намуудын хөгжил, төлөвшил зэрэг сэдвээр сэтгүүлийн байнгын булан нээлээ.

Эцэст нь сэтгүүлийнхээ бүх захиалагчдад маш их баярлаж, талархаж буйгаа илэрхийлье. Эдийн засгийн хүндрэлтэй үед манай сэтгүүлийн III дугаар улирлын сэтгүүлийн захиалга өмнөх оныхоос өсөлттэй гарсанд бид талархалтай байна. Та бүхний итгэлээр жигүүрлэн бид илүү чармайн ажиллаж, улам чанартай сэтгүүл гаргахын төлөө мэрийх болно.

Ерөнхий эрхлэгч Д.Бэхбаяр

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

8 Хариуцлагатай Засгийн газар үгүйлэгдэж байна

“ Р12



Р.Амаржаргал: Авралын Засгийн газрыг байгуулах ёстой

20 “Mongolianeconomy” сэтгүүлийн асуулт

21 Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн хандлага

24 “MONGOLIAN ECONOMY” ишлэл

26 Эдийн засгийн “хязгаар”

28 Бухимдуулсан параллель

30 “Бүү зээл, харин хадгал”

32 Модоо барьсан зуун жил

34 Өчигдөр Грек, өнөөдөр Аргентин, маргааш Монгол

38 Хөгжил өөд хүчирхэг хөршийн хамт

41 Монголын эдийн засгийн төлөв 2014 оны эцэст

44 “Чингис бонд”-ын зарцуулалт

46 Гэрэл асна, гэхдээ...

48 Эрээний уурхайн нөхөн сэргээлтийн жишиг

“ Р50



Алан хараацайн үлгэр

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажилллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МІН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

Борлуулах цэгүүд:
“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетийн бүх салбар
“Макс” супермаркетийн бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дэх салбарууд

facebook.com/Mongolian.Economy

twitter.com/EconomyMongolia

youtube.com/user/MongolianEconomy

МОНГОЛД

ГАЗРЫН ТОС

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарснаар тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж хайгуул, олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлэхээр болсон. Энэ ажлын хүрээнд “М Си Эс Петро Лимитед” ХХК нь Монгол-Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай “Импайргаз монголиа” ХХК-тай “Борзон-VII” талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхэлд нь шилжүүлэх тухай гэрээ байгуулсан байна. Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд шаардагдах техник-технологи, санхүүжилтийг БНХАУ-ын талын хувь эзэмшигч “Өвөрмонголын Чинхуа Групп” ХХК хариуцах, Австралийн “ЖОРК” стандартын дагуу нөөцийг тогтоох, эдийн засгийн хувьд үр ашигтай нөөц тогтоогдсон тохиолдолд хувь нийлүүлэгчид Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулах үйлдвэр барихаар нэгдсэн шийдвэрт хүрчээ.

ОРОН СУУЦ

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газар хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангахаар ажиллаж буй. Гэсэн ч бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөсөн хугацаанд гэрээний дагуу санхүүжүүлж чадахгүй нөхцөл үүсээд байгаа аж. Иймд энэ онд орон нутгийн бүтээн байгуулалтад зарцуулаагүй 50 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг “Буянт-Ухаа 2” хорооллын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх саналаа ТОСК Засгийн газарт илэрхийлсэн байна.

КОНЦЕСС

Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад байгаа концессын төслүүдийн уралдаант шалгаруулалт болон концессын гэрээ байгуулах ажлыг эрчимжүүлэхээр болжээ. Засгийн газрын “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоолоор нийт 51 төсөл хөтөлбөрийг баталсан. Үүнээс Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн, Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд хурдны автозам, Дулааны V, Тэлмэний дулааны цахилгаан станц, Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор гэсэн нийт зургаан төслийн концессын гэрээг байгуулаад байна. Тиймээс үлдсэн төслүүдийг шалгаруулах ажлыг түргэтгэхээр ажиллах аж.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

“Дорнын цас” ХХК-ийн хийт, хөнгөн бетоны үйлдвэрийн нээлт боллоо. Манай улс жилд 2-3 мянган вагон ачаа бүхий бетоныг гаднаас авдаг байна.Тус компани жилд 200 мянган шоо метр хийт, хөнгөн бетон үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Тэгэхээр монголчууд ийм хэмжээний бетоныг гаднаас зөөвөрлөх шаардлагагүй болж байна. Энэ нь нийт зах зээлийн 30 хувийг хангах боломжтой аж. Манай улс жилд 600 мянган шоо метр хөнгөн бетоны хэрэгцээтэй. Тус үйлдвэр байгаль орчинд ээлтэй, ямар нэгэн хаягдал гаргахгүй, утаагүй, усаа дахин ашигладаг, шинэ технологитой аж.

ЭРЧИМ ХҮЧ

Монгол Улсын Засгийн газар “Оюу толгой” ХХК-тай “Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ”-нд гарын үсэг зурлаа. Тус гэрээ нь өмнөд бүсийг цахилгаан эрчим хүчээр тогтвортой хангах цогц төлөвлөгөөг ажил хэрэг болгох. Урт хугацааны стратегийн хамтын ажиллагааны үндэс суурь тавих алхам болох юм. Энэ хүрээнд “Тавантолгой цахилгаан станц төсөл”-ийн санхүүжилтийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас босгоход шаардагдах “Оюу толгой” ХХК-ийн толгой компанийн дэмжлэг зэрэг бусад холбогдох асуудлыг зохицуулсан аж. Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр дотоодын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой аж.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Экспортыг дэмжиж, импортыг орлох зорилгоор “Самурай” бондын хөрөнгөнөөс хувийн хэвшлийнхэнд зээл олгохоор болсон. Гэвч зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгжүүдийн заримынх нь барьцаа хөрөнгө хүрэхгүйгээс зээлээ авч чадахгүй байгаа аж. Зээлдэгчдэд Зээлийн батлан даалтын сангаас дэмжлэг үзүүлэхээр болжээ. Өөрөөр хэлбэл, олгох зээлийн 60 хүртэлх хувьд буюу 250 сая төгрөгт багтаан тус сангаас батлан даалт гаргах юм байна. Зээлийн батлан даалтын сангаас дэмжлэг хэрхэн авах талаар **www.lgf.mn** хаягаар орж, дэлгэрэнгүй мэдээлэл авч болох аж. Зээл олголтыг хөнгөвчилсөн энэ шийдвэрийн дагуу одоогоор 37 аж ахуйн нэгжид 19.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоход бэлэн болсон байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ энэ оны эхний хагас жилийн байдлаар ДНБ-тэй харьцуулахад дөнгөж долоон хувийг эзэлж байгаа аж. Өөрөөр хэлбэл, он гарсаар эхний зургаан сард Монгол Улсад нийтдээ 370 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирсэн байна. Үүнийг 2011 оны мөн үетэй харьцуулахад бараг найм дахин буурсан үзүүлэлт аж. Тодруулбал, 2011 онд манайд нийтдээ 4620 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж байсан нь тухайн үеийн ДНБ-ий 53 хувьтай тэнцэж байжээ.

ДЭЛХИЙ ДАХИНД

ОХУ, УКРАЙН

Украйны нийслэл Беларус хотноо ОХУ болон Украйны Ерөхийлөгч нар уулзав. Уг уулзалтын үеэр Украйны Ерөнхийлөгч Петро Порошенко тус улсын зүүн хэсэгт Украйны цэргүүд болон салан тусгаарлагч нарын хооронд үүсээд буй мөргөлдөөнийг эцэслэх төлөвлөгөө боловсруулах гэж байгаа талаар дурджээ. Путин Оросын тал уг хэлэлцээрт дэмжлэг үзүүлж чадах боловч мөргөлдөөнийг зогсоох нь Украйны асуудал гэв. Украйн болон барууны орнууд босогчдыг зэвсгээр хангаж буй хэмээн Оросыг буруутгаад буй. Харин Кремлийн зүгээс үүнийг удаа дараалан эрс няцааж буйг BBC-д мэдээлжээ.

ЯПОН ТАТВАРАА ДАХИН НЭМЭХ ҮҮ

Энэ оны эцсээр Японы Ерөнхий сайд Шинзо Абэ саяхан нэмсэн татвараа ирэх онд арван хувь болгон нэмэгдүүлэх эсэхээ шийднэ хэмээн “Ройтерс”-т бичжээ. Өнгөрсөн дөрөвдүгээр сард тус улс борлуулалтын орлогын албан татвараа таван хувь байсныг найман хувь болгон нэмэгдүүлсэн билээ. Энэ нь улсын өрөө хязгаарлах зорилготой байв. Татварыг ийнхүү нэмэгдүүлсэн нь эдийн засгийг гэнэт уналтад оруулсан хэрэг. Энэ нь 2011 оны гуравдугаар сард тус улсад тохиосон газар хөдлөлт, цунамигаас хойш байгаагүй томоохон уналт болжээ.

БНХАУ-ЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


БНХАУ-ын гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ оны эхний долоон сарын байдлаар нэлээд буурсан талаар “Ройтерс”-т бичжээ. Энэ нь сүүлийн хоёр жилийн хамгийн доод үзүүлэлтэд тооцогдох аж. Ингэснээр бизнесийн зардал нэмэгдэж, гаднын компаниудад монополийн эсрэг шалгалт явуулж, шийдвэртэй арга хэмжээ авах болсон байна. Санхүүгийн бус хэлбэрээр хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн долоодугаар сард 7.81 тэрбум ам.доллар байсан нь сүүлийн хоёр жилийн хамгийн доод хэмжээ байв. Хөрөнгө оруулалт буурсан шалтгаан нь Японоос хийх хөрөнгө оруулалт 45, Европоос хийх хөрөнгө оруулалт 17.5, АНУ-аас хийх хөрөнгө оруулалт 17.4 хувь тус тус буурсантай холбоотой гэжээ.

УХААЛАГ ГАР УТАС 33 АМ.ДОЛЛАР

Firefox browser нэрээрээ танигдсан Mozilla компани нь Энэтхэгт шинэ ухаалаг гар утас гаргаад байна. Жижиглэнгийн үнэ нь ердөө 33 ам.долларын үнэтэй уг утсыг Snapdeal гэх Энэтхэгийн онлайн худалдаагаар борлуулж буй. Уг загварын нэр нь Intex Cloud FX бөгөөд Mozilla-гийн Firefox үйлдлийн системтэй. Азид ийм үйлдлийн системтэй ухаалаг гар утас гаргаж буй анхны тохиолдол аж. Mozilla-ийн ерөнхийлөгч Ли Гонг “Энэхүү ухаалаг гар утас нь хямдхан гар утасны байр суурийг шинээр тодорхойлж, Азид томоохон эргэлтийг бий болгох хүлээлттэй байгаа” гэжээ. ■



Шог зургийг А.Амарсайхан



УЛС ТӨР

ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСГИЙН ГАЗАР ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

Д.БЭХБАЯР /Mongolian Economy сэтгүүлийн Эрхлэгч/

Улс орны хөгжил дээшилж, доошилж буйг иргэдийнх нь амьдралаас шууд хардаг. Ялангуяа төрийн эрх баригчдын хэрхэн ажиллаж байгааг иргэдээс нь асуу гэдэг. Иргэд бидний амьдрал сайн байна гэвэл төр сайн ажиллаж байна. Дуу нь сулхан, амьдрал тиймхэн байна гэвэл төр муу л байна гэсэн үг. Тэгвэл манай эрх баригч нам, одоогийн Засгийн газар ямар ажиллаж байна вэ?

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд унаж, хувийн хэвшлийнхэн хаалгаа барьж, ажилгүйчүүдийн эгнээ нэмэгдэж, иргэд бэлэн мөнгөгүй болжээ. Валютын ханш 1800 давж, гадаад худалдааны эргэлт буурав. Гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг аюултай орон хэмээн үзэж, зугатан одсон. Өрийн сүлжээ өсч, өрийн менежмент харанга дэлдэж байна. Хамгийн өсөлттэй байсан ▸▸

барилгын салбар уналтад автаж, хурдацтай уруудсаар. Барилгын ажил нь явж буй барилга ховор, барьсан барилгыг худалдаж авдаг хүн байхгүй байна. Улс мөнгөгүй учраас тендерийн ажил зогссон гэсэн бизнесмэнүүд олон. Иргэдээс таны амьдрал ямар байна хэмээн асуухад сайхан байна гэж хариулах хүн үл олдоно. Тэгэхээр Н.Алтанхуягийн Засгийн газарт ямар дүн тавих нь ойлгомжтой. Тэгээд одоо яах вэ. Бүх зүйл ойлгомжтой байхад дахин дахин эдийн засаг унасан талаар ярилаа, бичлээ гээд яваад байх уу. Эсвэл Алтанхуягийн Засгийн газрыг унагах уу, өөр шинэ засаг, удирдлага гаргаж ирэх үү. Оновчтой гарц шийдэл юу байна вэ?

Алтанхуягийн Засгийн газар алдаагаа ухамсарлаж, дутагдлаа ойлгож, өнгөрснөөс сургамж аваад хариуцлагатай сайн ажиллаж байна шүү гэсэн мэссэжийг олон нийтээс автал ажиллах ёстой. Тэгж чадахгүй бол эртхэн хурдан огцрох хэрэгтэй.

Алтанхуягийн Засгийн газар

Бусад улс оронд бол эдийн засгийг ингэж доройтуулсан “гавьяатай” засгийг хэдийнэ огцруулчихсан байгаа. Засгийн удирдлага огцруулах хүртэл явах бус өөрөө огцрох саналаа гаргаад ажлаа өгөөд явдаг туршлагыг бид телевизээр олонтаа харсан. Иргэдийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэрийн эсрэг ард түмэн нь зохион байгуулалттай жагсаал хийгээд Засгийн газраа унагадаг, огцруулдаг эсвэл бурууг нь хүлээн зөвшөөрүүлээд ажиллуулдаг олон үйл явдлыг бид ертөнцийн мэдээллээр сонсдог, үздэг. Харин Монголд байдал эсрэгээр. Засгийн газар нь ямар ч дутагдалгүй, алдаагүй юм шиг аашилж байна. Бид сайн ажиллаж байгаа, эдийн засаг хүндэрсэн нь дэлхийн эдийн засгийн хямралтай холбоотой хэмээсэн аргацаасан тайлбар хэлэх. Дэлхийн хямралаас илүүтэй дотоодын асуудлууд эдийн засаг хүндрэхэд нөлөөлсөн тухай хүмүүс байнга ярьж буй. Намуудын, нам доторх фракцуудын зөрчил, албан тушаалын төлөөх улайрал, мөнгөөр бүхнийг шийднэ гэсэн үзэл, намын, өөрийн эрх ашгийг эх орны эрх ашгаас түрүүлж тавьдаг арчаагүй бодлого, улс төрийн намын төлөвшил, улстөрчдийн соёл, ёс суртахуунгүй байдал, авлига хүнд суртал, мэдлэг, туршлагаггүй нь сөргөөр нөлөөлсөн.

Өнгөрсөн зургадугаар сард Олон улсын валютын сангийн /ОУВС/ Удирдах захирлын орлогч Наоюуки Шинохара тэргүүтэй төлөөлөгчид манай улсад ирж, төрийн удирдлагуудтай уулзаад эдийн засгийн бодлогоо эргэж харахыг зөвлөөд буцсан. Тухайлбал,богино хугацаанд тулгамдаж буй эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд мөнгөний болон төсвийн тэлэх бодлогоо хумих шаардлагатай. Мөнгөний бодлогын хүүг өсгөх замаар мөнгөний нийлүүлэлт, нийт зээлийн хэмжээг бууруулж, мөнгөний бодлогыг төсвийн бодлогоороо дэмжих. Ялангуяа төсвийн бус хөрөнгө оруулалт нь нийт зээл нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа нь төсвийн тэлэлтэд шууд нөлөө үзүүлж байгааг онцгой анхааруулж, Хөгжлийн банкийг хяналттай ажиллахын зэрэгцээ гадаад орнуудаас авч буй зээл, нийлүүлэлтийг төсөвтэй хамт тооцож явах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн төсвийн зардлаа бууруулах хэрэгтэй хэмээн хэлсэн байгаа.

Наоюуки Шинохараг Монголд зочилж, удирдлагуудад дээрх зөвлөгөөг өгч явахад сэтгүүлч миний бие АНУ-ын Вашингтон хотноо Олон улсын валютын сан, Дэлхийн банкны төв оффист Монголоос ажиллаж буй хүмүүстэй уулзаж, эдийн засгийн талаар ярилцаж байсан юм. Тэгэхэд тэнд ажилладаг монголчууд хоёр дахь Аргентин Монгол хэмээн ярьдаг болсныг хэлж, эдийн засгийн шинэ бодлого, хариуцлагын системийг хэрэгжүүлэх шаардлагатай тухай ярьж байлаа.

Германы нэртэй эдийн засагч Ханс-Вернер Зинн манай улсад ирээд зээлээ багасгаж өөрсдийнхөө хүчээр улсаа хөгжүүлэх талаар зөвөлгөө өгөөд явсан. Эрх баригч намын гишүүн Р.Амаржаргал үнэн бодитой шүүмжлэл, эдийн засгийн хувьд ямар бодлого арга хэмжээ авах талаар олонтаа дуугарсан. Тэрбээр ялангуяа хариуцлагын систем, төсвийн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх тухайд багагүй ярьсан. Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Д.Содном, ДБямбасүрэн, Ш.Гунгаадорж нар манай сэтгүүлийн редакцийн уулзалтад орж, эдийн засгийн бодлогын, даван туулах арга замын талаар олон сайхан зүйл ярьсан. Сөрөг хүчний зүгээс ч бас баримттай асуудлууд гарган тавьж, шүүмжлэл, гарцын талаар дуугарсан. Товчхоноор дүгнэхэд одоогийн засаг хүмүүсийн үгийг авсангүй, бас сонсохыг хүссэнгүй.

Тэгэхээр Ерөнхий сайд Н.Алтанхуягт улс орны эдийн засагт үүссэн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийгээд алдаа дутагдлаа ойлгож, хүлээн зөвшөөрөөд цааш явах нэг гарц байна. Зарим хүмүүс таньдаггүй бурхнаас таньдаг чөтгөр нь дээр хэмээн үзэх. Хамгийн гол нь тэд өнгөрснөөс сургамж авч, алдаагаа засч ажиллах боломж байна гэж үзэж байгаа юм. Хариуцлагын системийг жинхэнэ утгаар нь нэвтрүүлж, сайдуудаа хариуцлага тооцож ажиллавал иргэдийн итгэлийг эргэн авч чадна. Өөрөөр хэлбэл, Алтанхуягийн Засгийн газар алдаагаа ухамсарлаж, дутагдлаа ойлгож, өнгөрснөөс сургамж аваад хариуцлагатай сайн ажиллаж байна шүү гэсэн мэссэжийг олон нийтээс автал ажиллах ёстой. Тэгж чадахгүй бол эртхэн хурдан огцрох хэрэгтэй. Өөрийн саналаараа огцорч, өөр хүмүүст боломж олгох нь улстөрчийн, эрх барих нам удирдаж буй лидер хүний том соёл байх ёстой. Монгол оронд улс төрийн ийм соёл, төлөвшлийг бий болгох цаг ирсэн.

Үүнийг эхлүүлэх, цаашлаад хөгжүүлэх нөхцөл нь Н.Алтанхуяг сайдад бүрдээд байна гэж үзэж байна.

Шинэ засаг

Н.Алтанхуягийн Засгийн газар огцрох ёстой хэмээн үзэх нөгөө хэсэг байна. Энэ нь хоёр жилийн дотор эдийн засгийг унагасан засагтай дахин хоёр жилийг хамт туулна гэж байхгүй гэсэн утгыг илэрхийлнэ. Тэгвэл шинэ засаг гарч ирснээр асуудал шийдэгдэх үү, байдал өөрчлөгдөх үү?

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Улс төрийн лидерүүд манлайлан бамбай болж, мэргэжлийн шалгуурыг голчилж сонгосон, голдуу намын бус төлөөллөөс бүрдсэн чадварлаг Засгийн газар байх ёстой. Энэ засаг эдийн засгийг сэргээх, уналтаас аврах, эдийн засгийн зөв чиглэлийг бий болгох зорилготой үндэсний эдийн засгийг аврах Засгийн газар байх ёстой. Үүний тулд улс төрийн намууд нөхцөлийг бүрдүүлж өгөх нь чухал” хэмээн ярилцлагадаа дурдсан. Сангийн дэд сайд асан Ч.Ганхуяг “Эдийн засгийн энэ хүндрэлийг давах хамгийн зөв гарц бол улстөрийн зөвшилцөл” гэж ярьсан нь бий.

Шинэ Засгийн газрыг үнэхээр улстөрийн зөвшилцлөөр, эх орон, ард иргэдээ гэсэн чин сэтгэлээр хандах гишүүдээр бүрдүүлвэл хүндрэлийг богино хугацаанд туулах, зөв зүг чигийг бий болгох гарц, хугацаа бий. Хамгийн гол үүрэг нь эдийн засгийг сэргээх, бодлогыг зөв голдиролд оруулж, хариуцлагын системийг нэвтрүүлэх, хариуцлагатай ажиллах. Ард түмэн үнэндээ хариуцлагатай засгийг үгүйлж байна. Түүнчлэн улс орны хөгжлийн стратегийн бодлогыг тодорхойлж, ямар ч нам засаг гарч ирсэн тэрхүү бодлогод захирагдаж ажилладаг системийг бүрдүүлэх. Стратегийн тогтвортой бодлогогүй учраас аль нэг нам нь ялангуут өмнөх засгийн хийсэн бүхнийг үгүйсгэн хаяж, өөр шинийг хэрэгжүүлэх замаар явсаар өнөөдөр улсын хөгжил ул суурьгүй, тогтворгүй, улстөрийн давалгаагаар унаж, иргэд хямарч, итгэл алдрахад хүрсэн нь туйлын үнэн болой.

Японы Засгийн газар ойр ойрхон огцордог жишээг бид мэднэ. Ерөнхий сайд, Засгийн газар унах, солигдох асуудлыг арлын энэ оронд тийм ч сүртэй хүлээн авдаггүй. Учир нь өөр хэн нэгэн тухайн суудалд суухад доод албан тушаалын хүмүүс гарын үсэг зурах албан бичгийг шууд л оруулдаг систем үйлчилдэг тухай Японд сурвалжлагаар явах үед сонсож байлаа. Манайхаар бол Төрийн нарийн бичгийн даргаас доош албан тушаал, мэргэжилтнүүд тогтвортой ажилладаг. Хэдэн сайд солигдсон ч тэд ажлаа л хийх үүрэгтэй. Шинэ сайд тэднийг халах солих эрхгүй. Хуулиар бататгаад өгсөн хэрэг. Осака хотын иргэн 60 настай Шизүка гуай Монголд тун элэгтэй нэгэн. Тэрбээр “Японд төр засаг, удирдлагууд солигдож л байдаг юм. Жирийн иргэн бидэнд хамаагүй. Сонирхдог ч үгүй. Ер нь ямар сайд нар байдгийг ч бид мэддэггүй” хэмээн ярьж билээ.

Тэгвэл ямар сайд, ямар удирдлагатай байх нь монголчууд бидэнд хамгийн их хамаатай. Хэн, ямар нам байхаас амьдрал ямар болох нь шалтгаалаад байгаа учраас тэр. Цаашид улс төрийн намуудын төлөвшил, улстөрчдийн соёл, ёс суртахуун, төрийн түшээдийн шалгуурыг тогтоож хөгжүүлэх, бэхжүүлэх, мэдлэгжүүлэх, соёлжуулах зайлшгүй шаардлага урган гарч ирж байна. Монголын хоёр том АН, МАН-ын бодлого чиглэл барууны, зүүний гэх боловч бодит амьдрал дээр ялгагдахааргүй л бодлоготой гэдэг. Эдгээр намын вэб дээрх мэдээллээр намуудын эрхэм зорилго, чиглэл их адилхан. Ялгагдах зүйлгүй. Чухам эх орныхоо язгуур эрх ашиг, ард түмнийхээ төлөө зүтгэнээ л гэх. Яг амьдрал дээр төрийн эрх бариад ирэхээрээ өөрсдийнхөө, намынхаа төлөө яваад байдаг нь бас л үнэн ажгуу. Намуудын хөгжил, төлөвшлөөс эдийн засаг, иргэдийн амьдрал хамаараад байгаа учраас цаашид намыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, эрхэм зорилго, үзэл баримтлалыг нь ягштал мөрдүүлж ажиллуулдаг болгох хэрэгтэй байна.

Ардчилсан нам

АРДЧИЛСАН НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: Ардчилсан нам нь Монгол Улсын язгуур эрх ашгийг дээдлэн улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх.

Эрх зүйт төр, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хувийн өмч, үндэсний хөгжлийг эрхэмлэж,

Монгол хүний бүтээлч чадавхид тулгуурлан нийгмийн дэвшлийг хангах зорилго бүхий, иргэн төвтэй чөлөөт ардчилсан үзэл баримтлал бүхий баруун төвийн улстөрийн нам юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Монголын үндэсний эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх .

МОНГОЛ АРДЫН НАМ

Ардын нам

Монгол ардын нам нь МАХН-ын зүй ёсны эхлэл ба үргэлжлэл бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн нийгмийн ардчиллын /социал-демократ/ үзэл баримтлал бүхий зүүн төвийн нам мөн.

ЭРХЭМ ЗОРИЛГО: эх орноо хөгжил дэвшилд хүргэж, ард түмнээ сэтгэл хангалуун, тайван аюулгүй, эрх чөлөөт амьдралтай болгоход оршино.

Монгол ардын нам нь төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах сонгуульд ялалт байгуулах буюу олонхи болж бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

Шинэчлэлийн Засгийн газарт та ямар дүн тавих вэ?

ИРГЭН Ц.ТОГООНТӨМӨР



Манай Засгийн газрын бодлого хууль дүрэм нь хоорондоо авцалдаж өгөхгүй байх шиг санагддаг. Шинэ хууль санаачлаад тэр нь мөн л учир дутагдалтай. Олон улсаас хөрөнгө оруулалт татахаас нааш дээрдэхгүй болов уу. Юмны үнэ өсч хүмүүсийн амьдрал хэцүүдэхээс өмнө Засгийн газар бодлогын өөрчлөлт хийх хэрэгтэй байсан. Энэ байдлаараа байдал цааш үргэлжилбэл нийгмийн амьдрал улам бүр хэцүүднэ. Өр зээл нь ч дийлдэхээргүй болж байх шиг байна.

ИРГЭН Г. АЛТАНГЭРЭЛ

Засгийн газарт бодлогын болон хувь хүний доголдол их байх шиг. Улс орны хөгжилд бол хийж бүтээж байгаа зүйл багагүй байна гэж хэлнэ. Харин чанарын болон бодлогын хувьд нэлээд алдаж байгаа юм болов уу гэж иргэн хүнийхээ хувьд хардаг. Зам тавилаа дараа жил нь дахиад л засах шаардлага гардаг. Халамжийн мөнгө өглөө дараа жил нь больчихдог. Бодлого боловсруулж хууль дүрэм гаргахдаа ихээхэн туршлага дутдаг. Бүхэл бүтэн улс орны хувь заяаг шийдвэрлэж байгаа хүмүүс нь эх орноо гэсэн өөриймсөг үзэлтэй байх нь чухал.

Н.ЛХАГВАСҮРЭН



Тэд хийх гэж л гарч ирсэн гэдгээ санаасай л гэж боддог. Хийж байгаа нь их цөөхөн хэлдэг нь олон байгаа юм уу даа. Хийж чадахгүй, чадал хүрэхгүй байгаа бол суудлаа чаддагт нь тавьж өгөөсэй. Залуу хүний хувьд эх орон маань хөгжинө гэж итгэдэг. Улс орон гэж хэсэг бүлэг улстөрч эрх мэдэлтэн биш ард түмэн, атга шороо юм шүү гэж хэлмээр байна.

ИРГЭН Г.ИШ



Засгийн газрын хийж буй их зүйл бий. Муу дүн тавихгүй. Гэхдээ Засгийн газар гэхээсээ илүү Хотын даргын хийж буй ажил хотын хөгжилд өнгө нэмж байна. Давж гарах ёстой хүндрэлүүд их бий. Энэ бүхэнд ухаалаг шийдвэр гаргаж ирээдүйтэй үр дүнтэй шийдвэрт хүрэх нь чухал. Хөгжил рүү яарах нь чухал биш гэж боддог.

ИРГЭН Э.ОДОНЧИМЭГ

Засгийн газар гэлтгүй удирдах бүхий л шатны албан тушаалтанд буруу байх шиг. Улс орны хөгжилд оруулж буй бүтээн байгуулалтад С үнэлгээ өгмөөр байна. Зам, тээвэр дэд бүтцийн хувьд шинэчлэл хийгдэж байна гэж харж байна. Гэхдээ удаан байна. Маргаантай асуудлаа шийдэж чадахгүй юм. Эдийн засгийн хүнд байдалд оруулсан засагтай хариуцлага тооцдог систем манайд байна уу. Ер нь хариуцлага, хариуцлага тооцдог байдал манай улсад их дутагдаж байна гэж иргэн хүний хувьд хардаг.

ИРГЭН Ц.ОТГОНЦЭРЭН



Дандаа хоёр үзүүртэй хууль гаргана. Тэр нь иргэдэд ерөөсөө хүрч үйлчлэхгүй. Бодлого нь ямар ч эмх цэгцгүй. Мөн аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлж буй дунд шатны хүмүүс нь мэргэжлийн биш юм болов уу гэж боддог. Шинэ засгийн газар гарсан цагаасаа хойш олон санал санаачлага гаргаж байна. Үүнийг дооро хэрэгжүүлж буй хүмүүсийн сэтгэл их дутдаг юм болов уу даа гэж бодогддог.



Д.БЭХЭЭ

УИХ-ын гишүүн Р.Амаржаргалтай ярилцлаа.

-Та уналтад ороод буй эдийн засгийг аврах хамгийн зөв гарц бол өнөөгийн Засгийн газар даруй огцрох хэмээн үзэж байгаа. Өөр гарц шийдэл байхгүй гэж үү?

-Хагас дутуу шийдлүүд байж болно. Гэхдээ асудлууд бүрэн шийдэгдэхгүй. Өнгө зассан, эмэгтэйчүүдийн хэллэгээр косметик засварын өнгөлөн далдалсан арга хэмжээнүүд байх болно.

-Өнөөдрийн Засгийн газрыг өөрчлөөд ч нэмэргүй. Ялгаа байхгүй. Оронд нь адилхан л

ЗОЧИН

Р.АМАРЖАРГАЛ: АВРАЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ БАЙГУУЛАХ ЁСТОЙ

хүмүүс гарч ирээд суучихна гэж зарим хүмүүс үзэж байна.

-Credibility гэсэн ойлголт байдаг. Энэ ойлголт эдийн засагт их чухал үүрэг гүйцэтгэдэг. Шинээр гарч ирэх засгийн бүтэц үнэхээрийн нүдээ олбол credibility буюу иргэдийн итгэлийг олж болно. Эдийн засгийн зүг чигийг тодорхойлох, зөв голдиролд оруулахад их зүйл хийж болно. Бусад улс орны туршлага, Засгийн газрууд үе үе бүтэц бүрэлдэхүүн, нүүр царайгаа өөрчилдөг. Итгэл найдвар хүлээлгэж, эрх мэдлийг өгөөд байхад ажил унагааж, асуудлыг хүндрүүлсэн бол тэр хүмүүстэй зууралдаад байх шаардлагагүй гэж үздэг. Эцсийн эцэст энэ нь бид хоёрын хоорондын асуудал биш учраас улс орны хөгжлийг аваад явах, чадвартай хүнийг сонгоод өөрчлөөд явдаг практик олон улсад бий. Харин энэ практик манайд хэрэгжихгүй өнөөг хүрсэн нь хувь хүмүүсийн хоорондын харилцаатай холбоотой. Нөгөө талдаа улс төрийн орчиндоо барьцаалагдчихсан байдаг гэх үү дээ. Өөрөөр хэлбэл, лидер байх чадваргүй, мэдлэггүй, сулхан улстөрч бусдыг аялдан дагах шаардлага гарч ирдэг. Тэр үүднээс асуудалд ханддаг. Гэх мэтчилэн олон зүйл ярьж болно. Гэхдээ зөв хүнээ зөв байранд тавиад явбал асуудлууд шийдэгдэх бүрэн боломжтой. Мөн ард иргэд, бизнесмэнүүдийн зүгээс ч асар их итгэл найдвар төрж, дэмжлэг ирнэ. Алив зүйл итгэл найдвар, дэмжлэг дээр тулгуурлаж явна шүү дээ. Өнөөдөр миний харж буйгаар энэ асуудал хамгийн чухал нь байна.

-Яг өнөөдрийн түвшинд иргэдийн, хувийн хэвшлийнхний итгэл Одоо яах вэ?

-2012 оны сонгуулийн дүн иргэдийн зүгээс бидэнд хүлээлгэсэн асар том дэмжлэг байсан. Урд нь болохгүй бүтэхгүй байсан зүйлсийг шинэчлээч, өөрчлөөч гэсэн мэссэж өгсөн. Ард түмний хүлээлт дээр тоглосон хэрэг болсон л доо. Шинэчилье үг ч гарч ирсэн биз дээ. Тэгээд юу болов. Их санасан газар есөн шөнө хоосон хононо гэдэгтэй адилхан болов. Иргэд хоёр жил дэмжлээ, итгэлээ, найдлаа, харлаа, хүлээлээ, тэвчээр алдлаа, одоо арга тасарсан байна. Улстөрийн нам, улстөрч хүн улс орон, эдийн засаг, ард түмэн, бизнесийн итгэлийг алдана гэдэг бол үнэндээ том нүгэл гэж би ойлгодог. Энэ тохиолдолд тухайн улстөрч алдаа дутагдлаа ойлгоод явах ёстой. Ийм зан чанар манай улстөрчдөд байх ёстой шүү дээ. Би буруу шийдвэрүүд гаргаж, алдаа ››



Фотог Б.Бямба-Очир

Р.Амаржаргал: Алив зүйл итгэл найдвар, дэмжлэг дээр тулгуурлаж явдаг

Улс төрийн нам, улстөрч хүн улс орон, эдийн засаг, ард түмэн, бизнесийн итгэлийг алдана гэдэг бол үнэндээ том нүгэл гэж би ойлгодог.

гаргалаа, надад итгэл хүлээлгэсэн, надад улстөрийн, санхүүгийн эрх мэдэл өгсөн, надад цаг хугацаа орон зайн боломж олгосон. Гэтэл би зөв бодлогоор улс орныг зөв удирдаад явж чадсангүй, тиймээс цаашид эх орноо, ард иргэдээ улам хохироохгүй гэзэд өөрөө асуудлаа ойлгоод бууж өгдөг ёс суртахуун улс төрийн намуудад, улстөрчдөд байх ёстой юм аа. Эргээд нь энэ нь хариуцлагын тогтолцоотой холбоотой. Хариуцлагын системгүй учраас хугацаагаа дуустал гүрийдэг,суудалдаа үлдэхийн төлөө юу ч хийхээс буцахгүй байхыг бодож байна.

-Шинэ засаг гарч ирлээ гэхэд тэд юунаас ажлаа эхэлж, яаж ажиллах нь зөв бол?

-Шинэ засаг бол үндэсний эдийн засгийн авралын Засгийн газар байх ёстой. Өвөрмөц бүтэцтэй байх хэрэгтэй. Мэдээж лидер, хүчтэй улстөрчид манлайлж, бамбай болж явах нь зөв. Харин салбар салбарын удирдах түвшний хүмүүс нь өндөр мэргэжлийн, мэдлэг боловсролтой, ёс суртахууны хувьд цэвэр ариун, шударга, чигч шулуун зан чанартай байх ёстой. Ийм бүрэлдэхүүнтэй шинэ Засгийн газрыг байгуулах боломжийг улстөрийн намууд олгох хэрэгтэй. Намууд, улстөрчид өнөө маргаашаа бодоод улс төр хийгээд явж болох байх, гэхдээ дараа нь юун дээр улстөр хийх вэ гэдгээ бодох нь чухал.Тэр утгаар үндэсний хэмжээний эдийн засгийг аврах засгийг бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Хоёрдугаарт, шинэ Засгийн газрын бүтцийг улстөрийн намуудаас гэж бүү голчлоосой. Улс төрийн намуудын чадвартай төлөөлөл байж болно. Нам бус хүмүүсийг томилох хэрэгтэй. Мэргэжлийн гэдэг рүү гол шалгуурыг авч үзэх ёстой. Гуравдугаарт, хариуцлагын тогтолцоог гол чигээ болгох. Чи энэ албан тушаал дээр ажиллаад цалин авч л байгаа бол ажлаа сайн хийнэ шүү гэдгийг хатуу ойлгуулах. Ийм энгийн зүйлээс ажлаа эхэлбэл бизнесийнхэн, иргэд маш хурдан эерэг дохио авна.Дэмжинэ. Ажлаа саадгүй төлөвлөөд явна.

-Тэгвэл одоогийн Засгийн газар өөрчлөгдөхгүй бол яах вэ? Амьдрал цааш хэрхэн үргэлжлэх бол?

-Бүх зүйл бахь байдгаараа л баяр ёслолын байдалтай үргэлжилсээр 2016 оныг хүргэнэ. Хүрэхгүй, наана нь асуудал дуусч ч магад. Эдийн засаг тартагтаа тулна. Өөрөөр хэлбэл, дэндүү өндөр үнээр л эрх мэдэлтэй зууралдах нь байна шүү дээ. Улс орныхоо эдийн засгаар тоглож байж л эрх мэдлээ авч үлдэнэ гэсэн үг. Одоо ч ингэж л хандаад байна шүү дээ.

Засаг шинэчлэгдээд гараад ирвэл иргэдэд итгэл төрнө гэдэгт эргэлзэхгүй байна. Юу хийх, яах ёстой вэ гэдэг дээр үнэндээ бол хүн төөрч, гайхаад байх зүйлгүй юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр яах ёстой, ямар шийдвэрүүд хэрэгжүүлбэл эдийн засаг сэргэх, улс орон хөгжих талаар бичээд яриад байгаа. Энэ бүгдийг нэг бодлогоор зангидаж, эмх цэгцэнд оруулах л асуудал. Тодорхой зөв зүйтэй зүйлийг дэмжиж, тодорхой зарим зүйл дээр үгүй гэж хэлж, хязгаарлалт тавих хэрэгтэй. Өнөөгийн засгийн хамгийн том дутагдал бол тодорхой нэг гол зүйлийг барьж авахын оронд бүгдийнх нь аманд жаахан жаахан юм зуулгаад оршин тогтнох байдалтай явуулаад байна гэж би хараад байгаа. Шийдвэртай зарим нэг асуудлыг ярих ёстой.

-Тухайлбал?

-Улсын төсвийн бүрдүүлэлт. Орлого, зарлагын асуудлыг тодорхой ярих цаг болсон. Олон жил хий хоосон ярилаа. Санаа нь оноо нь байгаа. Өмч хувьчлалын асуудал явахгүй байна. Хааяа ярих ч амьдрал дээр хэрэгжүүлсэн зүйлгүй л сууж байна. Санхүү, санхүүгийн зах зээл, даатгалын тогтолцоог сайтар бүрдүүлж хөгжүүлээгүй тохиолдолд эрчимтэй хөгжлийн тухай ярихад учир дутагдалтай. Ер нь бид хүй нэгдлийн үед л амьдарч байгаа юм шиг л байна.

-Хоёр дахь Аргентин Монгол гэж олон улсад ярьж байна. Та хүлээн зөвшөөрөх үү?

-Ер нь манай өрийн менежментийн асуудал түгшүүртэй байгаа. Улстөрөөс гадна эдийн засгийн шийдэл дээр тулгуурлах ёстой. Тэр шалгуур алга болчихсон. Наад захын жишээ нь Чингис бондыг ямар нөхцөл шалгууруар авч, юунд зарсан нь учир нь олдохгүй баахан маргасан. Энэ өрийн өгөөж, үр ашиг, хэзээ яаж юугаар төлөх нь тодорхойгүй. Дээр нь Самуурай бондыг ямар зорилгоор яах гэж авсан, хаашаа орсныг мэдэхгүй. Дараа нь сонсоход Чингис бондынхоо хүүг төлөхөөр авсан сурагтай. Бид сар, жил бүр мөнгө төлж байна. Энэ бүхэн эцэстээ Монгол Улсын өрийн менежментийг тодорхойгүй, учрыг олохгүй болгоод тавьчихлаа. Эрүүл саруул ухаанаар ярьж, хэлэлцэх шаардлагатай.

Монгол Улс дахин зээл авах нөхцөл нэн тааламжгүй болсон. Үндсэндээ арван хэдэн хувиас доошоо буух санхүүгийн эх үүсвэр манайд олдохгүй. Санхүүгийн институциуд манай улсын рейтингийг нэлээд буулгалаа.Тэгэхээр өнөөдөр арав гаруй хувийн хүүтэй зээл авах гэж байгаа, ийм шийдвэр гаргах гэж буй хүн бол Монгол Улсын эсрэг гэмт хэрэг хийж байна гэж ойлгох хэрэгтэй. Ийм шийдвэр гаргаж буй улстөрийн намыг зайлуулж, улстөрийн тавцангаас арчиж хаях хэрэгтэй. Засгийн газрыг нь өчиггүй зайлуулах хэрэгтэй. Энэ бол хоноцийн сэтгэлгээ. Миний дараа юу ч болсон яадаг юм, ялангуяа 2016 оны сонгуулийн дараа ямар үр дүн гарах нь хамаагүй гэсэн муухай сэтгэлгээнээс хандаж байна.

Одоо Монгол Улсын өр, зээлийг нэмж авахгүйгээр явахад 2016, 2017 оноос хөрөнгө оруулалтын асуудал маш хүнд болохоор байна. Наана нь тодорхой арга хэмжээ авах байх гэж горьдож сууна. Харин ийм нөхцөлд нэмээд зээл авбал үнэхээр хачин юм болно. Босохоос өөр аргагүй.

-Төрөөс өр зээлийн талаар ил тод, тодорхой танилцуулдаггүй нь юутай холбоотой вэ?

-Танилцуулдаг л юм. Гэхдээ асуудлыг гаргаж танилцуулахдаа өөрт ашигтайгаар өөрчлөлт хийчихдэг. Тухайн асуудлыг ухаж, эрж, хайгаад анализ хийгээд Засгийн газрын танилцуулснаар эдийн засаг, өр зээл ийм байна, бидний авсан мэдээллээр



Өнөөдөр арав гаруй хувийн хүүтэй зээл авах гэж байгаа, ийм шийдвэр гаргах гэж буй хүн бол Монгол Улсын эсрэг гэмт хэрэг хийж байна гэж ойлгох хэрэгтэй. Ийм шийдвэр гаргаж буй улстөрийн намыг зайлуулж, улстөрийн тавцангаас арчиж хаях хэрэгтэй. Засгийн газрыг нь өчиггүй зайлуулах хэрэгтэй.

тийм байна гэж ярих хүмүүс ховор байна л даа. Ер нь эдийн засгийг яриад буй улсыг харахад асуудлын гүн рүү орж, анализ судалгаатай ухаж төнхөчсөн нарийн тайлбартай хэлж шүүмжилж буй хүн ховор.

-Эдийн засаг нь өөрөө улстөртэй холбогдох юм. Улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн харалган бодлого, шийдвэрийн сөрөг нөлөө эдийн засагт муугаар тусч байна. Улс төрийн залгамж халаа, бодлого, төрийн хүнийг гаргаж ирдэг систем зэрэг асуудал манайд ор тас хаягдсан. Энэ бүхэн улсын хөгжилтэй холбогдож ирж буйг бид сүүлийн үед тод томруун харж байна. Яаж өөрчлөх вэ?

-Тухайн үеийнхээ нийгмийн мөн чанарт нийцсэн боловсон хүчний бодлого гэж айхавтар зүйл манайд хуучин байсан. Социализмын, төвлөрсөн төлөвлөгөөт нийгэмд зориулагдсан гээд шүүмжилдэг л дээ. Гэхдээ Монгол төрийн боловсон хүчний бодлого гэж бичигдсэн, бичигдээгүй хууль байсан юм аа. Удам угсаа, нутаг ус, эрхэлж буй ажил төрөл, нэр хүнд, зан чанар, мэргэжил боловсрол, сэтгэлийн хат тэнхээ, хорио цээрийг мэддэг мэддэггүй, уян зөөлөн зан чанар, мөнгөний шунал гэх мэт олон шүүлтүүр механизм байсан. Хуульд яг ийм тийм гэж бичээгүй ч боловсон хүчний бодлого хэрэгжүүлэх явцдаа эдгээр механизмыг голчилдог байсан. Энэ нь Монголын төрт ёсны олон жилийн түүх уламжлалтай уялдаатай. Энэ системийг

21-р зуунд улам боловсронгуй болгоод ноён нуруу нь аваад явах байсан. Гэтэл ор тас хаясан. Өнөөдөр төрийн боловсон хүчнийг бэлтгэдэг, дэвшүүлдэг шүүлтүүр алга. Дарга нарыг дагалдан гүйдэг, мөнгөөр асуудлыг шийддэг, эсвэл улс төрийн намуудад элсэж орилж, хашгирч, гүйж дэвшдэг механизм өнөөдөр үйлчилж байна. Тиймээс мэдлэг боловсролтой, шулуун шударга зантай, чадалтай, жинхэнэ төрийн ажил хийх хүмүүс гарч ирэхгүй, гарч ирэх ч нөхцөлгүй байна шүү дээ. Арга ядаад UBS телевизээр "Улстөрийн шинэ од төрүүлэх" төслийг хэрэгжүүлэх санаа төрсөн болов уу.

Цаашид Монгол төрт ёсны тогтолцоо, залгамж халаа, боловсон хүчний бодлогыг өнөөгийн нийгмийн онцлогтой уялдуулан холбож авч явах нь зөв байх. Англи, Америк, Японы тогтолцоог шууд хуул гэдэг. Хүчээр оруулж ирээд шууд хуулж болохгүй. Би энд шүүмжлэлтэй ханддаг. Нэн шинэ үеийн түүхэнд ийм зүйл тохиолдож байсан. Тод жишээ гэвэл дэлхийн хоёрдугаар дайны дараа 1950 оны сүүлээр манайх хоёр хөрштэйгээ эв найрамдалтай сайхан байна гээд армиа татан буулгасан. Гэтэл Зөвлөлт, Хятадын харилцаа муудаад ирэнгүүт армийг шинээр дахин босгох шаардлагатай болж, олон асуудал тулгарсан. Хамгийн гол зүйл нь бүхэл бүтэн үе тасарсан. Хурандаа, Хурандаагийн дэргэд бага дэслэгч байх. Энэ хоёрыг холбох ахмад, хошууч, дэд хурандаа нарын үе тасарсан хэрэг. Армийг шинэчлэн зохион байгуулах, боловсон хүчнийг бэлтгэхэд их хүч хөрөнгө, цаг хугацаа шаардлагатай болсон.

Өнөөдөр бас иймэрхүү зүйл тохиож байна. Нийгэм, үе хоорондын залгамж бодлого тасарсан. Социализмын нэрээр бүх зүйлийг үгүйсгэсэн. Шинээр гарч ирсэн зүйлс нь нийгэмд төлөвшиж амжаагүй байтал одоогийн төрийн тогтолцоо нь өөр үнэлэмжүүд рүү явж байна. Тийм учраас үүх түүхээ сайн мэдэж, ойлгож, авах, гээхийн ухаанаар асуудалд хандах шаардлагатай байна.

-Дэлхийн улс төрийн чиг хандлага хаашаа явж байна вэ?

-Өнөөгийн намуудын тогтолцоо зөвхөн Монголд бус дэлхийн хэмжээнд явахааргүй харагдаад байгаа юм.

Төрийн боловсон хүчнийг бэлтгэдэг, дэвшүүлдэг шүүлтүүр алга. Дарга нарыг дагалдан гүйдэг, мөнгөөр асуудлыг шийддэг, эсвэл улс төрийн намуудад элсэж орилж, хашгирч, гүйж дэвшдэг механизм өнөөдөр үйлчилж байна.

Өөрөөр хэлбэл, тодорхой асуудал тойрсон, дэвшүүлсэн нийгмийн хамтлаг, хөдөлгөөн, холбоод цаашид улс төрд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, нэлээд хүчирхэгжиж хөгжихөөр байна. Энэ утгаар ард иргэд өөрсдөө хөдөлгөөнт субьект болж хувирна. Тухайлбал, би байгаль орчныг хамгаалах хөдөлгөөнтэй хамтарч байгаль орчны асуудлаар тэмцэх, маргааш нь унадаг дугуйчдын хөдөлгөөнд элсээд нийслэлд унадаг дугуйны зам гаргах талд хүчтэй дуугардаг болох жишээтэй. Ирээдүй рүү чиглэсэн шинэ цагийн энэ бодлого хүчтэй хэрэгжээд ирвэл улс төрийн намуудын бүтэц бүрэлдэхүүн, зорилгод өөрчлөлт орно. Хатуу гишүүнчлэлтэй байх уу, үгүй юу гэх мэтээр улстөрийн намуудыг төлөвшүүлэхэд ирээдүйн энэ чиг хандлага ихээхэн нөлөөлнө.

-Өнөөдрийн улс төрийн байдал хүмүүсийг Ерөнхийлөгчийн засаглалтай байх нь ч дээр юм гэсэн яриаг гаргаж байна. Хэрэлдсэн, маргасан, биенээ хэмлэсэн нам, нам доторх олон фракц, улс төрийн хүчин байснаас нэг хүний зангараг удирдлага дор явах нь зөв гэж үзэх хүмүүс байна?

-Би энэ асуудлыг хөндөөг хүнийг нэг. Хөндөхдөө нэг бол Парламент, эсвэл Ерөнхийлөгчийн засаглалтай байх зарчмыг баримталдаг. Өнөөдрийнх шиг өөх ч биш, булчирхай ч биш байх хэрэггүй гэж. 2004 оны сонгуулийн өмнө энэ асуудлыг хөндөж гаргаж ирсэн. Шийдэх боломж байсан ч чадаагүй. Миний хувьд бол Парламентын засаглалыг илүүд үздэг. Монгол Улс сайн, муу ч ийм засаглалтай байх нь зөв. Гэхдээ сонгодог утгаар нь хөгжүүлэх ёстой гэж байнга хэлдэг. Парламентын засаглал өөрөө гал хамгаалллын механизмүүдийг агуулдаг. Өнөөдөр Үндсэн хуулийг шинэчлэх асуудал яригддаг. Нөгөө талаас бид Үндсэн хуулийнхаа потенциалийг бүрэн ашиглаж чадахгүй байгаа. Утга агуулга, үзэл санааг бүрэн мэдэхгүй мөртлөө өөрчлөөд өгье гэх. Үсчсэн байдлаар явж ирсэн нь монгол төрийг ийм хэмжээнд хүргэлээ. Тиймээс одоо асуудалд яарч сандралгүйгээр эрүүл саруул ухаанаар хандах ёстой. Үндсэн хуулийнхаа потенциалийг бүрэн шавхсаны дараа өөр зүйл рүү оръё.

-Эдийн засагч, судлаачид дэлхийн эдийн засгийг сэргэх хандлагатай байгаа талаар ярьж, бичиж байна. Харин манай төрийн түшээд одоогийн хүндрэлийг дэлхийн хямралтай холбоотой мэтээр ярьж иргэдэд ухуулж байгааг Та хэрхэн дүгнэж байна вэ?

-Наад тайлбар чинь миний инээдийг хүргээд байгаа. Учир нь дэлхийн эдийн засаг жинхэнэ хямарч байхад манайхан огт дуугараагүй. Хямралаас гараад эдийн засгийн өсөлт өөд аажим аажмаар явж буй үед дэлхийн эдийн засаг хямарсан, хямрал нь манайд нөлөөлсөн мэтээр ярихыг би ерөөсөө ойлгохгүй, гайхаад байгаа. Тэгэхээр тэд ямар ч боловсролгүй хүмүүс үү, эсвэл хэл нь хальтирчихдаг юм уу.

Динамикаар харвал дэлхийн эдийн засаг өөдлөх өнгө аяс руу орсон. Америкийн эдийн засаг сайжрах байдалтай. Японых ер нь их гайгүй өнгөтэй явна. Брикийн орнуудын эдийн засаг өсөлттэй, заримынх нь саарсан. Түгшүүртэй буй нь Евро зон. Гэхдээ улам бүр дордчихгүй болов уу гэсэн хүлээлттэй. Евро зоны санхүүгийн систем хүндхэн байгаа. Гэхдээ улс орнууд бие биенээ татаж чангаагаад хямралаас гарч буй дүр зураг харагдана. Хоёрдугаарт улс төрийн үйл явдлын өрнөл эдийн засгийн нааштай өсөлтөд саад болох вий гэсэн болгоомжлол бий. Гурав дах нь технологийн өөрчлөлт. Сүүлийн үед гарч ирж буй технологийн өөрчлөлт дэлхийн эдийн засгийн дүр төрхийг нэлээд өөрчилж байна. Тухайлбал 3 D принтинг. Өмнө нь бид өргөжилтийн

3D принтингийн гайхамшигтай шинж чанар бол нэгж бүтээгдэхүүний зардал ялгаагүй. Нэгийг, саяыг үйлдвэрлэсэн ч нэгж бүтээгдэхүүний зардал адилхан. Энэ утгаараа үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэлээ эх орон руугаа зөөж эхэллээ.

хэмнэлт гэж ярьдаг байлаа. Чи 100 төгрөгөөр үйлдвэр байгуулаад нэг ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол өртөг нь 100 төгрөг. Хоёр бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл нэгнийх нь өртөг 50, 100 төгрөг бол нэгнийх нь өртөг нэг төгрөг гээд өргөжих тусам хэмнэлт гараад явах загвар. Эдийн засгийн энэ загвар өнөөдөр дэлхийд хэрэгжиж байгаа. Хятадын эдийн засгийн гайхамшгийн гол онцлог нь энэ өргөжилтийн хэмнэлтийн хуульд тулгуурласан тогтолцоо юм. 3D принтингийн гайхамшигтай шинж чанар бол нэгж бүтээгдэхүүний зардал ялгаагүй. Нэгийг ч, саяыг ч үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүний зардал адилхан. Өндөр хөгжилтэй орнууд, үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрээ Хятад руу, хөгжиж буй орнууд руу зөөсөн шүү дээ. Тэгвэл 3D принтинг хөгжсөнөөр энэ байдал тэс өөрөөр уншигдахад хүрч байна. Энэ утгаараа үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэлээ эх орон руугаа зөөж эхэллээ.

Америкийн хэд хэдэн компани үйлдвэрээ эх орондоо шилжүүллээ. Германд ийм үзэгдэл ажиглагдах болов. Илүү өндөр технологийн үйлдвэрүүдээ эх орондоо шилжүүлж байна. Ийм процесс дэлхий дахинаа явчихлаа. Ойрын 10 жилийн хугацаанд энэ технологийн хөгжил шийдвэрлэх процесс байх уу үгүй юу гэдэг нь харагдана. Хэрвээ шийдвэрлэх процесс байж чадвал дэлхийн эдийн засгийн бүтэц өөр болно. Тэгэхээр дэлхийн хөгжлийн ирээдүйн хандлага, технологийн хөгжилтэй улс орныхоо эдийн засгийн бодлогоо уялдуулах, алсын хараатай ажиллах шаардлага манайд зүй ёсоор тулгарч байна.

-Засгийн газрын эсрэг үгүй гэж хэлж чаддаг банкийг жинхэнэ Төв банк гэж үзэх шалгуур байдаг юм билээ. Харин манай Монгол банк үгүй гэж хэлсэн түүх байдаг уу?

-Бараг байхгүй. Анх хоёр шатлалтай банкны тогтолцоо гарч ирэхэд Монгол банк Сангийн яамны харьяанд Засгийн газартаа захирагдана гэсэн асуудал гарч ирж, нэлээд маргасан. Түүнээс хойш илт маргаагүй ч Төвбанкны үйл ажиллагаа нь Засгийн газрын хавсарга байдалтай яваад байгаа шүү дээ. Монгол банкны үе үеийн удирдлагууд Төв банкны эдийн засгийн бие даасан байдал, эрх мэдлийг ухамсарлаж байсан эсэхийг мэдэхгүй. Харин сүүлийн үеийн удирдлагууд ойлгоод байх шиг байгаа юм.

-Зарим хүмүүс Төв банкны явуулж буй мөнгөний бодлогыг дэмжих, нөгөө нь буруу хэмээн шүүмжлэх. Заавал онол дагах бус улс орныхоо өөрийн онцлогт тохирсон мөнгөний бодлого хэрэгжүүлж болох уу?

-Толгой зовоох асуудал энд ерөөсөө байхгүй. Ямархуу арга хэмжээ авах талаар нь сурах бичиг дээр хүртэл онол нь байгаа шүү дээ. Тэр онолоор арга хэмжээ авч болно. Гэхдээ Монголын эдийн засгийн онцлог, бүтцийг судлах хэрэгтэй. Нэг хэсэг нь мөнгөний бодлогоор дамжуулаад зайлшгүй барьж байх нөөцийн хэмжээ, Төвбанкны хүүгээр эдийн засгийн асуудлыг тухайлбал, инфляцийг зохицуулна гэдэг. Гэтэл энэ талаас нь харвал тэр нөлөөлөл нь манайд маш бага. Ном дээр хэрвээ бодлогын хүүг нэмэгдүүлбэл эргэлтэд буй мөнгөний хэмжээ багасана, эдийн засгийг хумиж байж эдийн засгийн зарим асуудлыг шийдэж болно гэж бий. Манайд ийм бодлого арга хэмжээ авлаа гээд эцсийн дүндээ инфляци буурахгүй байгаа юм. Тэгэхээр онол гэхээс илүү прагматик бодит амьдралд дээр тулгуурласан зөв шийдвэр хэрэгтэй. Монголбанкнаас хэрэгжүүлэх бодлого,арга хэмжээ бол сурах бичгийн онол дагасан шийдвэрүүд.Төвбанк стандартын бус шийдлүүд гаргах гэж оролдсон. Тухайлбал, үнэ тогтворжуулах хөтөлбөр нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайтар мэдэрч, авсан сайн шийдвэр. Хоёрдугаарт энэ шийдвэр нь цаанаа улс төртэй холбоотой. Цаг хугацааны хувьд Ерөнхийлөгчийн сонгуультай давхцсан, өөрөөр хэлбэл, тэр их мөнгийг эдийн засаг руу цацсан нь Ерөнхийлөгчийн сонгуульд үр дүн гаргах хүсэлтэй холбоотой. Юун дээр алдсан бэ гэвэл цаг хугацааг сунжруулсан. Богино хугацаанд нэг удаа эрчимтэй хийгээд татчих ёстой шийдвэрийг хэтэрхий сунжруулсан. Болж байна, сайн байна, үр дүн гарна гэж явсаар эцэст нь барилгын салбараа унагаад авлаа. Үнэ ханшаа туугаад тавьчихлаа шүү дээ.

-Долларын ханш бууraад байгаа?

-Ханш хэдэн төгрөгөөр буурч, өсөх асуудал биш. Хамгийн гол нь сууриа харах ёстой. Ханшийн хувьд суурь нь валютын нөөц. Ямар динамик харагдаж байна вэ. Хоёрт, гадаадын хөрөнгө оруулалт. 2011 онд ДНБ-ий 52 хувьтай тэнцэж байсан гадаадын хөрөнгө оруулалт 2013 онд 14 хувьд унасан. Уйлмаар байгаа биз. 2014 онд долоон хувьд хүрсэн. Хоёр дахин буурсан. 52 хувьтай байсан хөрөнгө оруулалтыг 14, долоо хувь руу оруулсан “гавьяатай” Засгийн газар чемодоноо бариад хурдан алга болох ёстой. Валютын ханшийг харахдаа эхлээд валютын нөөц, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны балансыг хар. Сүүлийн үед гадаад худалдааны алдагдал гайгүй болсон гэж яриад байгаа. Гэтэл гадаад худалдааны эргэлт байхгүй болчихсон шүү дээ. Дараа нь хэнд ашигтай вэ гэдгийг харах. 1300-1800 хүрсэн ханшаас хэн хожиж байгааг мэдэх хэрэгтэй.

Эдгээр үзүүлэлтийг харахад ханшны өсөлт, уруудалт ойлгомжтой болно.

-Эдийн засгийн хүндрэлээс гарах нэг гарц Оюутолгой мөн үү?

-Мөн. Энэ хорвоо дээр үнэ төлбөргүй юм байхгүй. Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх. Ямар УИХ, ямар Засгийн газартай байна, ямар хууль баталж байгааг харуулж байгаа юм. Мөн манай улстөрчдийн чадавхи, ёс зүй, суртахуун, шунал, хулгай хийх байдал нь ямар билээ. Энэ бүхний нийлбэр явсаар Оюутолгойг ийм байдалд хүргэсэн. Чи өнөөдөр ямар байна, түүний чинь хариу төлбөр гэж ойлгох хэрэгтэй. Зугатах гээд хэрэггүй. Хүлээн зөвшөөрөөд дараа дараагийн алхмуудаа зөв зүйтэй хийгээд явах ёстой. Зөв зүйтэй алхам хийх нөхцөлийг бүрдүүлэх учиртай.

-Хөршүүдтэй харилцах эдийн засгийн бодлогыг та хэрхэн дүгнэх вэ?

-Эдийн засгийн асар том потенциал Хятадад бий. Үнийг бид яаж ашиглах вэ гэдэг л асуудал. Зүүн Азийн орнууд Хятадыг бүрэн хэмжээгээр ашигласан. Хятад АСЕАН+1 чөлөөт худалдааны гэрээг АСЕАН-ы орнуудтай байгуулсан. Тухайн үеийн Ерөнхий сайд нь “ Хятад улстай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан АСЕАН-ы орнуудад өрмийг нь өгнө” гэж хэлсэн байдаг. Үнэхээр ч гэрээнийхээ хамгийн амттай хэсгийг тус орнуудад хангалттай өгсөн. Хятад ч өөрөө Зүүн Азийн маш том зах зээлийг эзэлж авсан, санхүүгийн эх үүсвэрийг татлаа. Бүс нутгийн том өөрчлөлт гарангуут зарим орон сандарч эхэлсэн. Хамгийн их сандарсан нь Япон. Япон Сингапуртай очоод эдийн засгийн Иж бүрэн түншлэлийн гэрээг байгуулангуут АСЕАН-д нэгдэж АСЕАН+2 болсон. Дараа нь Өмнөд Солонгос орсноор АСЕАН+3 болов. Үүний цаана бүс нутгийн эдийн засгийн боломж, харилцан ашигтай механизмуудыг бүрэн ашиглах хэрэгтэй гэсэн санаа байгаа юм.

Харин манайх хоёр талын л худалдааны механизмуудыг ашиглаад байгаа болохоос бус олон талт худалдааны механизмаар дамжуулаад Хятадын зах зээлийг ашиглах боломцоог олж хараагүй байна. Одоо дөнгөж эхлээд буй Номхон далайн эдийн засгийн түншлэлийн гэрээнд Монгол Улс нэгдэж орох нь чухал байна.

Хойд хөршийг аваад үзэхээр гунигтай л даа. Хэрвээ би андуураагүй бол Монголын нийт гаргаж буй экспортын 1,4 хувийг ОХУ эзэлж байна. Монголын хувийн салбар, бизнесийнхэн Оросгүйгээр амьдарч болох нь гэсэн үг. Энэ нь ОХУ-аас явуулсан тарифын бодлоготой холбоотой. Энэхүү тарифын бодлого бол монголчуудаа бидэнтэй арилжаа наймаа бүү хийгээрэй гэсэн утгатай агаар нэг. Үндэсний бүтээгдэхүүн, тухайлбал, Оросын зах зээлд хивсээ зарахаар очихоор өндөр тариф урдаас тавина. Тэгэхээр монгол бизнесмэнүүд хивсээ зарах өөр зах зээл хайна шүү дээ. Өнгөрсөн хугацаанд ОХУ-аас авч буй зүйлд бараг л өөрчлөлт ороогүй байна. Нөгөө талаас хойд хөршийн энэхүү харилцааг асар том бололцоо гэж харах хэрэгтэй. Харилцан бие биедээ ашигтай байх зарчмаар худалдааны эргэлтийг эрчимжүүлэх сайжруулах шаардлагатай. Улс төрийн байр сууринаас энэ асуудлыг зөв илэрхийлэх нь чухал байна.

-Манай иргэд засаг төрд асуудал тавих, хэлж ярих, жагсахыг мэдэхгүй, их тайван хүмүүс. Гадаадад бол аль дээр асуудлыг гаргаж, жагсаад тэмцсэн байгаа даа. Энэ нь монголчуудын зан чанартай холбоотой юу?

-Монгол хүн хүлээцтэй тэвчээртэй байна гэдэг нэг ондоо асуудал. Ер нь монгол хүн дуугаа хураахаараа нэг л өөр болчихдог. Би энэ талаас нь хардаг. Болж байна, бүтэж байна, эсвэл гарч ирж шүүмжилж, орилж хашгираад явбал болж байгаа юм байна гэж дотроо боддог. Ярихаас дөлөөд, зугатаад бүлх залгисан юм шиг л байвал хэцүү байгаа юм байна гэсэн үг. Шинжлэх ухааны үндэстэй шалгуур биш л байх л даа. Гэхдээ би 20-иод жил улстөрд нухлагдаж байна. Хөдөө орон нутгаар явахад ийм зүйл ажиглагддаг.

Ер нь ард иргэдийн ам эргэчихсэн байна лээ. Тэдний итгэл найдварыг сэргээх хэрэгтэй. Энэ нь хувь хүний бус эдийн засгийн, Засгийн газар цаашлаад улс төрийн намын эрх ашиг хөндөгдөнө. Намын үүднээс авч үзвэл иргэдийн итгэл сэтгэлийг сэргээх асуудал чухал байна. Би 2012 оны сонгуулийн өмнө ярьж байсан. Монголд улс төрийн хоёр том хүчин байгаа. Гэрийн хоёр багана гэсэн үг. Нэг багана нь салж бутраад дотроо асуудал үүсч байна. Тэр тохиолдолд хүнд ачаа нөгөө намд ирэх ёстой. Ардчилсан нам илүү их ачаа үүрч, тэр хэмжээгээр хариуцлагатай байх шаардлагатай. Алдаа байхгүй, дутагдалгүй юм шиг царайлж, эх орны эрх ашиг, эв нэгдэл гэх гоё нэр томъёо ашиглаад халхавч хийгээд өөрийн хариуцлагагүй, замбараагүй, мэдлэггүй, чадахгүй буйгаа нуух хаах байдлаар ажиллах хэрэггүй гэж үздэг учраас би намынхаа төлөө намаа үе үе хатуу шүүмжилдэг. ■

Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх. Ямар УИХ, Засгийн газартай байна, ямар хууль баталж байгааг харуулж байгаа юм. Мөн улстөрчдийн чадавхи, ёс зүй, суртахуун, шунал, хулгай хийх байдал нь ямар билээ. Энэ бүхний нийлбэр явсаар Оюутолгойг ийм байдалд хүргэсэн.

ЗАСГИЙН ГАЗАР

	ЯАМД	САЙД	ДЭД САЙД
1	Сангийн яам	**Нэр:** Ч.Улаан **Мэргэжил:** Инженер- эдийн засагч	**Нэр:** С.Пүрэв **Мэргэжил:** Политехникийн дээд сургууль төгссөн
2	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	**Нэр:** Л.Болд **Мэргэжил:** Нийгэм, улстөр судлаач	**Нэр:** Д.Ганхуяг **Мэргэжил:** Олон улсын эдийн засагч
3	Гадаад харилцааны яам	**Нэр:** С.Оюун **Мэргэжил:** Геохимич	**Нэр:** Б.Тулга **Мэргэжил:** Хэрэглээний математикч, улс төр судлаач
4	Хууль зүйн яам	**Нэр:** Х.Тэмүүжин **Мэргэжил:** Хуульч	**Нэр:** Э.Эрдэнэжамъян **Мэргэжил:** Хуульч, эдийн засагч
5	Барилга, хот байгуулалтын яам	**Нэр:** Ц.Баярсайхан **Мэргэжил:** Инженер, эдийн засагч	**Нэр:** Г.Байгальмаа **Мэргэжил:** Олон улсын эрх зүйч
6	Боловсрол, шинжлэх ухааны яам	**Нэр:** Л.Гантөмөр **Мэргэжил:** Инженер (харилцаа холбооны, электроникийн)	**Нэр:** Б.Ургамалцэцэг **Мэргэжил:** Арга зүйч багш
7	Батлан хамгаалах яам	**Нэр:** Д.Бат-Эрдэнэ **Мэргэжил:** Улстөр судлаач, философич	**Нэр:** А.Баттөр **Мэргэжил:** Эдийн засагч,статистикч
8	Зам, тээврийн яам	**Нэр:** А.Гансүх **Мэргэжил:** Хуульч	**Нэр:** Х.Ержан **Мэргэжил:** Инженер
9	Соёл, спорт, аялал жуулчлалын яам	**Нэр:** Ц.Оюунгэрэл **Мэргэжил:** Эдийн засагч	**Нэр:** М.Түмэнжаргал **Мэргэжил:** Эдийн засагч
10	Уул уурхайн яам	**Нэр:** Д.Ганхуяг **Мэргэжил:** Хими технологийн инженер, физикч, эдийн засагч	**Нэр:** О.Эрдэнэбулган **Мэргэжил:** Инженер
11	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	**Нэр:** Ш.Түвдэндорж **Мэргэжил:** Хуульч	**Нэр:** Б.Цогтгэрэл **Мэргэжил:** Инженер, эдийн засагч, хуульч **Нэр:** Ц.Туваан **Мэргэжил:** Эмч
12	Хөдөлмөрийн яам	**Нэр:** Я.Санжмятав **Мэргэжил:** Малзүйч, эдийн засагч	**Нэр:** Ж.Батхуяг **Мэргэжил:** Эдийн засагч
13	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	**Нэр:** С.Эрдэнэ **Мэргэжил:** Цэргийн команд, эрх зүйч, өмгөөлөгч	**Нэр:** Э.Тамир **Мэргэжил:** Төрийн удирдлагын менежер, багш
14	Эдийн засгийн хөгжлийн яам	**Нэр:** Н.Батбаяр **Мэргэжил:** Эдийн засагч, статистикч	**Нэр:** О.Чулуунбат **Мэргэжил:** Валют-санхүүгийн эдийн засагч
15	Эрчим хүчний яам	**Нэр:** М.Сономпил **Мэргэжил:** Ерөнхий цэргийн командын хуягт машины ашиглалтын инженер	**Нэр:** Д.Доржпүрэв **Мэргэжил:** Банк санхүүгийн эдийн засагч
16	Эрүүл мэндийн яам	**Нэр:** Н.Удвал **Мэргэжил:** Хүүхдийн эмч	**Нэр:** Ж.Амарсанаа **Мэргэжил:** Хүний их эмч

ТӨРИЙН НБД	ГАЗАР
Нэр: Х.Ганцогт **Мэргэжил:** Бизнесийн удирдлага	1. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар 2. Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар 3. Төрийн сангийн газар 4. Төрийн захиргааны удирдлагын газар 5. Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар
Нэр: Б.Болдбаатар **Мэргэжил:** физикч, физикийн багш	1.Төрийн захиргааны удирдлагын газар 2. Бодлого, төлөвлөлт, судалгааны газар 3. Ази, номхон далайн орнуудын газар 4. Дипломат ёслолын алба 5. Европ, ойрхи дорнодын газар 6. Гэрээ, эрх зүйн газар 7. Олон улсын байгууллагын газар 8. Хөрш орнуудын газар 9. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 10. Америк, Африкийн газар 11. Консулын газар
Нэр: Ж.Батболд **Мэргэжил:** Биологич	1. Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар 4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5. Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар 6. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Нэр: Ж.Баярцэцэг **Мэргэжил:** Хуульч	1. Эрхзүй шинэчлэлийн бодлогын газар 2. Хуульзүйн нэгдсэн бодлогын газар 3. Төрийн захиргааны удирдлагын газар 4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
Нэр: Р.Эрдэнэбүрэн **Мэргэжил:** Хуульч	1. Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 2. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3. Орон сууц нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, 5. Хуулийн хэлтэс
Нэр: Ш.Булга-Эрдэнэ **Мэргэжил:** Инженер, физикч	1. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар 2. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3.Төрийн захиргааны удирдлагын газар 4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээ 5. Дотоод-аудитийн газар 6. Барилга захиалагчийн ажлын алба
Нэр: З.Болдбаатар **Мэргэжил:** Цэргийн шинжлэх ухааны доктор	1. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 5. Гадаад хамтын ажиллагааны газар
Ажлаас чөлөөлөгдсөн	1. Төрийн захиргааны удирдлагын газар 2. Стратеги бодлого төлөвлөлтийн газар 3. Авто замын бодлогыг хэрэгжилтийг зохицуулах газар 4. Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5. Төмөр зам далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 6. Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар 7. Зам тээврийн хяналт бүртгэлийн газар
Нэр: П.Алтангэрэл **Мэргэжил:** Түүх	1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 5. Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Нэр: Р.Жигжид **Мэргэжил:** Физикч	1. Стратеги бодлого төлөвлөлтийн газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Бодлого хэрэгжилтийн зохицуулах газар 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Нэр: Х.Золжаргал **Мэргэжил:** Математикч	1. Стратеги бодлого төлөвлөлтийн газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 6. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 7. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
Нэр: П.Гантулга **Мэргэжил:** Аялал жуучлалын менежер	1. Төрийн захиргааны удирдлагын газар 2. Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газар 3. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар 5. Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн газар, 6. Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 7. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Нэр: Б.Отгонжаргал **Мэргэжил:** Эмч	1. Төрийн захиргаа удирдлагын газар 2. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар 3. Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
Нэр: Б.Шинэбаатар **Мэргэжил:** Хуульч	1. Эдийн засаг хамтын ажиллагаа, зээл, тусламжийн бодлогын газар 2. Төрийн захиргааны удирдлагын газар 3. Хөрөнгө оруулалтын газар 4. Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газар 5. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 6. Инновaци,төр-хувийн хэвшлийн түншлэлийн газар
Нэр: Д.Дэлгэрцогт **Мэргэжил:** Эдийн засагч	1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар 2. Санхүү, хөрөнгө оруулалтын газар 3. Гадаад хамтын ажиллагааны хэлтэс 4. Төрийн захиргааны удирдлагын газар 5. Хуулийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Нэр: А.Эрдэнэтуяа **Мэргэжил:** Хүний их эмч, эрхзүйч	1. Төрийн захиргааны удирдлагын газар 2. Бодлого төлөвлөлтийн газар 3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

“MONGOLIANECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

Улс төрийн том намууд Монголын хөгжилд саад болж байна гэдэгтэй санал нийлэх үү?



Н.ЖАНЦАННОРОВ
/Ардын жүжигчин, Төрийн хошой соёрхолт хөгжмийн зохиолч/:

-Манай орны хувьд Парламентын засаглалтай. Тэр утгаараа намууд өрсөлдөж Засгийн эрх барих ёстой. Өнгөн талаас нь харахад буюу хэлбэр талаасаа манай улс энэ зарчмаар явж байгаа. Харин агуулга талаасаа бол нам гэдэг ухагдахуун өнөөдөр гажчихаад байна. Уг нь нам гэдэг нь өөрийн гэсэн үзэл баримтлалтай. Түүнийхээ хүрээнд ажилладаг байх учиртай юм. Сонгогчид тухайн намын үзэл баримтлал, бодлогыг нь харж саналаа өгөх ёстой. Гэтэл өнөөдөр гишүүд намынхаа үзэл баримтлалын хүрээнд биш хэсэг бүлгийн ашиг сонирхлын хүрээнд ажиллаж, нам гэдэг нэрийн дор бүлэглэл бий болгочихоод байна. Сонгогчид сонгуулиар намд саналаа өгөх ёстой байтал хэсэг бүлэг этгээдэд санал өгөөд байна гэсэн үг. Ингээд ирэхээр улс орны эрх ашиг хөндөгдөж байгаа юм. Тиймээс намуудыг нийгмийн баримжаатай болгож, хуулиа дагаж мөрддөг, үзэл баримтлалынхаа хүрээнд ажилладаг болгох хэрэгтэй.



Д.ЦЭРЭНДОРЖ
/Монголын менежментийн холбооны ерөнхийлөгч/:

-Намууд ард түмэнд таалагдахын тулд л ажиллаж байгаа болохоос биш, улс орны хэтийн хөгжлийн төлөө ажиллахгүй байна. Адаглаад улс орны хэтийн хөгжлийн бодлого манайд өнөөдөр алга байна шүү дээ. Ийм бодлого гаргаж тэр хүрээндээ ажиллахын тулд биш, нам болон намын гишүүд ард иргэдийн саналыг л авахын тулд хэтэрхий үрэлгэн амлалтууд өгч, ямар ч үр ашиггүй бодлого явуулж байна. Намууд зөвхөн эрх барихын төлөө буюу хэт явцуу эрх ашгийн төлөө явмааргүй байна. Хийж байгаа ажилдаа илүү улс төрийн үүднээс үнэлэлт дүгнэлт хийдэг болмоор. Мөн хийж байгаа ажилдаа олон түмний үнэлэлт дүгнэлтийг авдаг, олон нийтээр хэлэлцүүлдэг болох нь чухал. Сонгууль дөхөөр л худлаа амлалт өгдөг биш хэдэн жилийн өмнөөс хийсэн ажлаа ард иргэддээ тайлагнадаг. Үнэн зөв мэдээллээр олон нийтийг хангасаны үндсэн дээр сонгогчид үнэлэлт дүгнэлт өгч дараагийн сонгуульд аль нам, улс төрийн хүчинд саналаа өгөхөө шийддэг байх нь чухал.



Д.МӨНХӨӨ
/УИХ-ын гишүүн асан/:

-Бидэнд өнөөдрийг хүртэл үндэсний зөвшилцлийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн Монгол орныг хөгжүүлэх үндэсний хөгжлийн дунд болон урт хугацааны бодлого алга. Миний мэдэхээр гурван удаа Үндэсний хөгжлийн бодлого гарсан. Эхнийх нь намайг УИХ-ын гишүүн байхад баталсан “Үндэсний хөгжлийн бодлого” гэж бий. Дараагийнх нь “Тогтвортой хөгжлийн бодлого” гэж гарсан. Сүүлийнх нь Н.Энхбаяр Ерөнхийлөгчийн санаачилгаар “Мянганы хөгжлийн бодлого” батлагдаж байсан удаатай. Гэтэл эдгээр бодлогын аль нь ч үндэсний зөвшилцлийн хэлбэрээр буюу эрдэмтэн мэргэд, ард иргэд, улстөрийн намуудын хүрээнд хэлэлцүүлж, бүгдэд нь хүлээн зөвшөөрөгдсөн үү гэвэл үгүй. Тиймээс бид яаралтай үндэсний зөвшилцлийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн Хөгжлийн дунд болон урт хугацааны бодлоготой болох хэрэгтэй. Ингэж чадвал ямар ч нам, улс төрийн хүчин Засгийн эрхэнд гарсан тэр бодлогын хүрээнд ажиллах болно.



Ө.ГАНЗОРИГ
/Санхүүгийн зах зээлийн холбооны Ерөнхийлөгч/:

-Манай улстөрийн намуудад филсофийн үзэл баримтлал алга. Аливаа нам улстөрийн эрх барихын тулд филсофийн үзэл баримтлалаа олон нийтэд танилцуулж сонгодог болохоос биш мах, талх амалснаараа сонгуульд ялдаг юм биш. Гэтэл өнөөгийн манай Засгийн эрхэнд гарсан намууд философийн үзэл баримтлал, алсын хараа, урт хугацааны хөгжлийн бодлого ярьсангүй. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд анхаарсангүй. Харин ч эсэргээрээ манай намыг сонговол мах өгнө, нөгөөхийг сонговол талх өгнө гэж ард түмний тархийг угаах үүргийг сайн гүйцэтгэж ирлээ. Энэ утгаараа томоохон намууд улс орны хөгжлийг хойш татаж байна. Тиймээс намын удирдлагууд философийн үзэл баримтлалаа бий болгох хэрэгтэй. Намын гишүүд нь тэр үзэл баримтлалыг хүлээж авсан гэдгээ нотолсон байх учиртай. Гэтэл өнөөдөр либераль үзэл баримтлалтай намд консерватив үзэл баримтлалтай хүн гишүүн гээд явж байх жишээтэй. Ийм байж болохгүй шүү дээ.

УЛС ТӨР

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА



С.ЗҮЛЬФИКАР
/Удирдлагын академийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор/

Улс төрийн намын төлөвшил Монголд ямар байна вэ? Улсын хөгжлийг урагшлуулахад намуудын үүрэг оролцоо юу байх вэ? Эрх баригч улс төрийн хүчнүүдийн үзэл бариmтлал хоорондоо ялгарч байна уу? Нэг талаас эдгээр асуултад хариулт хайх, нөгөө талаас өнөөдрийн манай нийгэм эдийн засгийн олон асуудлыг үндсээр нь зөв шийдэх гарц гаргалгаа намуудын хөгжилтэй холбоотой байгаа учраас манай сэтгүүл энэ удаа улстөрөөр амьсгаллаа. Товчхондоо, монголчуудын амьдрал сайжрах эсэх нь уул уурхайгаас бус улс төрийн намаас шууд хамааралтай хувь заяа болчихоод байна.Тиймээс улс төрийн нам, намуудын хөгжлийн чиг хандлагын талаар системтэй ойлголт өгөхөөр Удирдлагын академийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор С.Зүльфикарын бичсэн “Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн хандлага” нийтлэлийг цувралаар хүргэхээр эхлүүлээд байна. Түүний нийтлэл зөвхөн үүгээр дуусахгүй улс төрийн намын хүний нөөцийн асуудал, намуудын нийгэм эдийн засаг дахь үүрэг оролцоо гээд чухал сэдвүүдээр үргэлжилнэ.

Нам (party) гэсэн ойлголтыг XYIII зуунаас хэрэглэж эхэлсэн байдаг. Үүний зэрэгцээ нам гэсэн ойлголттой ойролцоо утгаар фракц “faction” гэсэн үг хэрэглэгдэж байжээ. Гагцхүү нам “party” болон фракци “faction” гэсэн үг яг ижил утга илэрхийлдэггүй. Фракц нь улс төрийн сэтгэлгээний түүхэнд удаан хэрэглэгдэж ирсэн нэр томьёо бөгөөд латины “facere (to do, to act- хийх, үйлдэх)” гэсэн үгнээс гаралтай юм. Хожим энэ үг латин хэлнээ “factio” хэмээн бичигдэх болж улс төрийн бүлгийн эмх журамгүй байдал, зохион байгуулалтыг сулруулах үйлдэл, нийгмийг хагаралд хүргэх гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Энэ үгний ерөнхий утга нь латин хэлээр бие даасан байх, сэхүүн зан, харгис, хэрцгий гэсэн утгыг илэрхийлдэг байна.

“Party” хэмээх үг нь латин гаралтай (pars) гэсэн үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект “sect” (латины secare - таслах, цавчих, хайчлах, хуваах “to sever, to cut, to divide”) гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирсэнээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэхийн тулд ”party” гэдэг үг улс төрийн хэрэглээнд нэвтэрсэн байна. Харин сект “sect” гэсэн үгээр улс төрийн хүрээн дэх биш шашны тодорхой зан үйл бүхий бүлгийг нэрлэх болжээ. Фракц гэсэн ойлголт нь улс төрийн үйл явцад одоо ч амь бөхтэй байгаа бөгөөд улс төрийн нам доторх тодорхой сонирхлын бүлгийг тодорхойлох нэршил болсон байна.

Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг” гэж тодорхойлсон байна. Монгол улсын Улс төрийн

намын тухай хуульд үүнтэй ижил агуулгаар намыг тодорхойлжээ. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн нэгдүгээрт, “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дурааараа эвлэлдсэн Монголын иргэдийн нэгдэл мөн” гэжээ. Р.Михельс “Улс төрийн байгууллага болох нам нь засгийн эрх мэдэл рүү тэмүүлдэг” гэсэн байна. Францын улс төрийн философич Реймон Арон “Ардчилал ба тоталитаризм” хэмээх сонгодог бүтээлдээ“...намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал юм” гэжээ. Ямартай ч улс төрийн нам нь ардчилсан тогтолцооны онцгой субьект болох нь эндээс тодорхой байна.

Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг” гэж тодорхойлсон байна. Монгол улсын Улс төрийн намын тухай хуульд үүнтэй ижил агуулгаар намыг тодорхойлжээ.

Орчин үеийн хэв шинж бүхий улс төрийн нам анхлан Европт үүссэн гэж үздэг. Учир нь Европт нам үүсэх үйл явц хөрөнгөтний ардчилсан хувьсгал, нийгэм дэх сонирхлын ялгарал, заагшралын үйл явц цаашлаад ардчиллын үр дүн болох парламентат ёс, бүх нийтийн сонгуулийн эрхтэй холбоотой байв. Төрийн эрх мэдлийн легитимт шинжийг баталгаажуулдаг ардчилсан тогтолцоо төлөвшихийн хэрээр улс төрийн бодлогод олон түмнийг өргөнөөр татан оролцуулах суваг нь нам байж, засгийн эрх авсан нам бодлогоо нийгэмд хэрэгжүүлэх боломжтой болсон нь намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, түүнийг улс төрийн бодлогын гол субьект болгоход хүргэжээ.

Гэхдээ улс төрийн намыг нийгэм тэр бүр эерэгээр хүлээн авч байгаагүй. АНУ-ын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон “Нам бол нийгмийн эв нэгдлийг эвдэн, сөрөг үр дагавар дагуулж болзошгүй бүлэглэл” гэж тодорхойлж байв. Хэдий тийм боловч нам нь ардчилсан улс төрийн тогтолцооны цаашлаад засаглалын салшгүй хэсэг болж чадсан. Тэр битгий хэл улс төрийн үйл явцыг тодорхойлогч болж, нам болон намын тогтолцоо судлал нь харьцуулсан улс төр судлалын салбар судлал болтлоо хөгжөөд байна.

Орчин үеийн улс төрийн тогтолцоонд улс төрийн намуудын үүргийг тодорхой хүрээнд хязгаарлаж болох хэдий ч зарим тохиолдолд нийгмийн харилцааны бүхий л хүрээнд улс төрийн намын оролцоотой хэрэгжсэн үйл ажиллагаа, түүний шууд үр дүн, үр дагавар гардаг. Иймд судлаачид улс төрийн намыг ашиг сонирхлын агергацийг хэрэгжүүлэх суваг гэдэгтэй санал нэгддэг. Улс төрийн тотголцооны тухай онолын гол төлөөлөгч Давид Истон улс төрийн үйл явцад талуудын ашиг сонирхлыг нэгтгэн, системчлэх үүргийг улс төрийн нам хэрэгжүүлж байгааг шинжилж, тодорхойлсон. Үүний зэрэгцээ ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлдэг нь улс төрийн практик нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байна. Цаашлаад улс төрийн манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх үүргийг нам хэрэгжүүлнэ. Өнөө цагт улс орны бодлогыг тодорхойлж, хүмүүсийг араасаа дагуулах авъяас чадвартай манлайлагчид (удирдагчид)





улс төрийн нам дотор бэлтгэгдэж, сонгогдож, шилэгддэг улс төрийн соёл төлөвшиж байна.

Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүлэг, үзэл санаанаы бүлэг, нийгмийн бүлэг гэж үзэж болно. Нөгөө талаар улс төрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий бүлэг ч гэж үзэх нь бий. Иймд улс төрийн намуудыг түүхэн, зохион байгуулалт (намын байгуулалт), чиг үүргийн хувьд ангилах, бүлэглэх боломжтой юм. Судлаачид олон талт ангиллыг санал болгосон байх хэдий ч намуудыг нийтлэг шинж чанараар нь дараах гурван бүлэг болгон ангилсан байна.

Эхнийх нь элит нам (elite political party) юм. Намын бодлого, үйл ажиллагааг намын элитүүд хөтөлж, чиглүүлдэг, үзэл суртал нь тодорхой бус, нийгмийн дээд хэсэгт суурилдаг, гишүүнчлэл нь итгэл үнэмшил гэхээсээ элит дагасан шинжтэй байдаг. Улс төрийн аливаа сонирхол нийгмийн элит хэсгийн дунд илүү илэрдэг бөгөөд энэ нь яваандаа улс төрийн нам болон зохион байгуулагдах үндэс болжээ. Европын улс төрийн намуудын эх үндсийг язгууртан, хөрөнгөтөн ангийн төлөөлөл тавьсан байх бөгөөд намууд нь элит намын хэв шинжийг түлхүү илэрхийлдэг байв.

Нийгмийн бүлгийн ялгарал, давхраажилт хүчтэй явагдахын хэрээр нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, улс төрийн намууд бий болсон. Үүнийг олон түмний нам (mass political party) гэж нэрлэсэн байна. Нөгөө талаар бүх нийтийн сонгуулийн эрх нь олон түмний нам өргөжих хүчин зүйл болсон. XX зууны эхэн үеийн Европын намууд олон түмний намын хэв шинжийг илэрхийлдэг.

XX зууны хоёрдугаар хагаст олон намын тогтолцоо, түүнтэй уялдсан сонгуулийн тогтолцоо төлөвшиж, улмаар улс төрийн нөхцөл байдалд нийцүүлэн хүн амын бүхий л хэсгийн дэмжлэгийг авах шаардлага улс төрийн намуудад тавигдсан. Учир нь нийгмийн тодорхой нэг хэсэг бүлгийн ашиг сонирхолд тулгуурласан улс төрийн намууд засгийн эрхийг авах боломж зарим талаар хязгаарлагдах болжээ. Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцааны шинэ дэвшилтэт технологи нь улс төрийн намын лидерүүдэд нийгмийн бүхий л хүрээнд хүрч ажиллах бололцоо олгож, нам - олон нийтийн харилцааг хялбаршуулсан. Отто Крихамер үүнийг өргөн хүрээний (бүхнийг шүүрэгч гэж ч орчуулж болох) нам (catch all party) гэж үзсэн. Энэ төрлийн нам нь нийгмийн тодорхой бүлгийг төлөөлөх бус үндэсний эрх ашиг, сонирхлыг бүхэлд нь удирдлага болгох учиртай.

Эдгээрийн зэрэгцээ зохион байгуулалт, сонгуульд оролцож байгаа технологи, засгийн эрх барих үйл явцад оролцох хэлбэрийн шалгуур болгон намуудыг сонгогчдын таашаалд нийцэх зорилготой (client), хөтөлбөрийг гол болгосон (programist), засгийн эрхийг хамтран барих замаар улс төрийн зорилгоо гүйцэлдүүлэх картел (cartel) нам гэж бүлэглэж болно. Гэхдээ эдгээрийн аль альны шинж чанарыг өөртөө шингээсэн улс төрийн намууд ч байна. Тухайлбал, олон түмний нам нь сонгуулийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтийн дэмжлэг авах зорилт тавих нь бий.

Дээрх ангиллуудын зэрэгцээ улс төрийн намуудыг хэв шинжээр нь “Эх газрын болон Америкийн” загвар гэж ангилдаг. Эх газрын загварт улс төрийн нам дээрээс доош чиглэсэн хатуу тогтсон бүтэц, зохион байгуулалттай байж, гишүүнчлэлд тусгайлан ач холбогдол өгдөг.
Эх газрын загварт баруун, зүүн Европ, төв Ази, Ойрхи Дорнодын улс төрийн намуудыг хамааруулж болно. Харин Америкийн загварт улс төрийн намуудад гишүүнчлэл чухал биш боловч лидерүүдээр дамжсан үндэсний болон орон нутгийн түвшний зохион байгуулалт бий болсон байдаг. Өөрөөр хэлбэл тодорхой лидерүүд тухайн орон нутагт намын үзэл санаа, үнэт зүйлийг олон нийтэд ойлгуулах, тэднийг араасаа дагуулах хэлбэрийн чөлөөт зохион байгуулалт төлөвшсөн байна.

Францын улс төр судлаач М.Дюверже намуудыг зохион байгуулалт, үйл ажиллагааны хэв шинжээс нь гадна сонгуулийн тогтолцооны үр дүнд улс төрийн хэдэн нам голлох, тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгааг шалгуур болгон улс төрийн намын тогтолцоог тодорхойлсон. Үүнийг Дювержегийн хууль гэж нэрлэдэг. Мажоритар сонгуулийн тогтолцоо нь хоёр намын тогтолцоо төлөвших нөхцөл болдог бол хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоо (холимогч байж болно) нь олон намын тогтолцоо төлөвших нөхцөл болдог гэж үзсэн байна.
Энэ хууль олон талаар батлагддаг. Тухайлбал, Их Британи мажоритар сонгуулийн тогтолцоог хэрэглэдэг бөгөөд дэлхийн II дайнаас хойш үндсэндээ улс төрийн хоёр нам голлох үүрэгтэй байж, сонгуульд ээлжлэн ялалт байгуулж ирсэн. Харин Итали, Израйл зэрэг улсууд хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоотой учраас сонгуулийн үр дүн байнга эвслийн Засгийн газар байгуулах нөхцөл болдог байна. Үндсэндээ олон намын тогтолцоо бүрэлдсэн байна.

Одоо улс төрийн намууд хэрхэн төлөвшиж, хөгжиж байгааг авч үзье. Баруун Европын улс төрийн намуудад уламжлалт хэв шинж алдагдаж байна гэж судлаачид үзэх болжээ. Учир нь намууд дан ганц тодорхой бүлгийн ашиг сонирхол, зарим тохиолдолд зөвхөн язгууртан, элитүүдийн хүсэл сонирхлын үр дүнд бий болж, түүнтэй уялдсан улс төрийн манлайлал хэрэгжүүлдэг байсан зохион байгуулалт, чиг үүрэгт зарчмын өөрчлөлт бий болсон.
Гэхдээ улс төрийн намд элитүүд зарим тохиолдолд лидерүүд гэж үздэг хэсгийн манлайлал ач холбогдолтой хэвээр байна. Гагцхүү тэд өөрсдийн сонирхлыг олон нийтийн сонирхолтой зайлшгүй уялдуулах шаардлагатай болжээ. Нөгөө талаар дан ганц нийгмийн тодорхой анги, нийтлэг бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөх бус нийгмийг бүхэлд нь хамарсан улс төрийн бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна. Нюман үүнийг “Ардчилалтай интеграцчилагдах” үйл явц гэж тодорхойлжээ. Улс төрийн намууд баруун Европын улс төрийн үйл явцад нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдөж, төлөвшсөн улс төрийн үйл явцтай интеграцчилагдаж чадсан нөхцөлд оршин тогтнох боломжтой болж байгаа юм. Иймд өргөн хүрээний намын хэв шинж улс төрийн намуудын үзэл баримтлал, зохион байгуулалт, үйл ажиллагаанд эрчтэй нэвтэрч байгаа юм. ■

Үргэлжлэл бий

“MONGOLIAN ECONOMY” ИШЛЭЛ

“Mongolian Economy” сэтгүүл дотоод, гадаадын улс төрийн болон бизнесийн, төрийн албаны нэр хүндтэй хүмүүстэй улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийн асуудлаар ярилцдаг билээ. Бид энэ удаа өнгөрсөн хугацаанд манай сэтгүүлд “Зочилсон” хүндтэй хүмүүсийн үнэтэй ярианууудаас ишлэн хүргэж байна.



ДАШИЙН БЯМБАСҮРЭН
/Ерөнхий сайд асан/

“...Монголын эдийн засгийг дүгнэн харахад, Хятадад үйлдвэрлэсэн том тракторын хойноос зүүгдэж байгаа мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл, өмнөд хөршийн эдийн засаг өсөөд байгаа. Хүний тракторын чиргүүл болж зүүгдэлгүй Монгол гэдэг айл өөрийн гэсэн хөдөлгүүртэй болох ёстой...”

Mongolian Economy 2014 оны нэгдүгээр сар.



ДУМААГИЙН СОДНОМ
/Ерөнхий сайд асан/

“...Гадаад харилцаанд бизнесмэнүүдтэй харьцахдаа маш хянуур байх ёстой. Манайх гадаадын хөрөнгө оруулалтыг их шүтэж байгаа өнөө үед эдийн засгийн алуурчид ороод ирж магадгүй шүү. Зарим нь хөлөө тавьсан байхыг ч үгүйсгэхгүй...”

Mongolian Economy 2014 оны нэгдүгээр сар.



ШАРАВЫН ГУНГААДОРЖ
/Ерөнхий сайд асан/

“...Парламентыг сонгодог тогтолцоо руу оруулах цаг болсон. Дээд, доод хоёр танхимтай болох ёстой. Хоёр том гүрний дунд орших газар нутаг томтой, хүн ам цөөтэй манайх шиг орны хувьд ийм Парламентын тогтолцоо хэрэгтэй. Үндэсний эв нэгдлийг хангахад энэ байдал маш чухал үүрэг гүйцэтгэнэ...”

Mongolian Economy 2014 оны нэгдүгээр сар.



КРИСТЕЛ ВАНДЕР ЕЛИСТ
/Дэлхийн эдийн засгийн форумын Стратеги хариуцсан ахлах дарга/

“...Монголд яг одоо сайн анхаарч авч үзэж, хариу үйлдэл үзүүлэх ёстой гурван хөгжлийн хувилбар байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн баялаг, дагалдах боломжуудаа хэрхэн удирдах, уул уурхайг эдийн засгийн төрөлжилтийн суурь болгох. Мөн худалдаа болон хөрөнгө оруулалтын ямар харилцааг бид ирээдүйд хүсч байна вэ гэдгээ тодорхойлж, замаа сонгох чухал мөчид ирээд байна...”

Mongolian Economy 2014 оны дөрөвдүгээр сар.



ЖОРДАН БЕЛФОРТ /Уран илтгэгч/

“...Дундаж монгол хүний амжилтын талаарх ойлголтод философийн суурь өөрчлөлт, шилжилт хийх хэрэгтэй байна. Та бүхэн өөрийн хөрөнгийн зах зээлдээ, улмаар эдийн засагтаа итгэл үзүүлдэг байх нь чухал. Тийм биш бол амжилтад хүрнэ гэдэг юу л бол...”

Mongolian Economy 2014 оны зургадугаар сар.



АН САН СУ ЧИ/Мьянмарын Парламентын гишүүн, Нобелийн шагналт, ардчиллын цогтой тэмцэгч/:

"...Бид өнгөрснийг ирээдүйн хичээл болгон ашиглах ёстой болохоос дөнгө болгож болохгүй. Хэрвээ бид өнгөрснөөр хөлөө тушиж, юу үзэж өдийг хүрсэндээ шаналсаар байвал өнгөрсөн үе рүүгээ буцсаар л байх болно.."

Mongolian Economy 2013 оны тавдугаар сар.



Б.ГАНБОЛД
/ГХЯ-ны газрын дарга/

"...Монголчуудад удам угсаа, төр улсаа авч явах ухаан эрт дээр үеэс төлөвшсөн. Нэгдүгээрт, тав, арван жилийн ашгийг бус ирээдүйг, тэрний цаадахыг харж сэтгэдэг холч ухаан. Хоёрдугаарт, ахмад настнаа хүндэл, эцэг эх, өвгөдийнхөө сүнс сүлдэнд залбирч явдаг хүндлэлийн ухаан. Гуравдугаарт, Байгаль эх дэлхийгээ хайрлаж хамгаалах ухаанд үр хүүхдээ сургаж, байгальтайгаа ойрхон амьдардаг үндэстэн. Ийм гурван сэтгэлгээ нэг хүнд төлөвшсөн үндэстэн бол зөвхөн Монгол..."

Mogolian Economy 2012 оны долдугаар сар.



Б.БОЛД
/Рио Тинто"-гийн Зэсийн салбарын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхийлөгч/

"...Төрөөс төрсөн тэрбумтанг үргэлжлүүлэх нь бодлого биш. Энэ буруу байсныг бүгд хүлээн зөвшөөрөөд, ард түмэн сонголтоо хийсэн учраас зах зээлийн лебирал эдийн засгийн бодлогоо үргэлжлүүлэн хөгжүүлээсэй..."

Mongolian Economy 2012 оны хоёрдугаар сар.



ПЕТЕР БРАБЕК ЛЕТМАТЕ/
Nestle компанийн ТУЗ-ын дарга/

"...Бид одоо их эгзэгтэй, эмзэг үед байна. Бидний урьдчилж хараагүй олон өөрчлөлт болсоор байна. Нөгөө талаас эерэгээр харвал асар хүчирхэг ардчилсан хөгжил байна. Дэлхий дээрх хүн бүрт хүртээмжтэй шинэ боломж, шинэ үүрэг хариуцлага гарч ирж байна гэсэн үг..."

Mongolian Economy 2012 оны дөрөвдүгээр сар.



Ч. ГАНХУЯГ

"...Би Монгол Улсын иргэн. Энэ бол миний хамгийн түрүүнд өмсч яваа малгай. Дараа нь нам, бизнес яригдана. Тиймээс би Монголын эрх ашгийн төлөө иргэн хүнийхээ үүргээр нэн тэргүүнд дуугарах ёстой...".

Mongolian Economy 2014 оны долоодугаар сар.



РОЗА ОТУНБАЕВА
/Киргизстан улсын анхны эмэгтэй ерөнхийлөгч/

"...Бид бүх зүйлийг хүн бүрт эн тэнцүү хуваадаг эрх тэгш нийгэмд амьдардаг байсан шүү дээ. Иймээс ч би хүн болгон авлигыг нугачин дарах маш чухал зэвсэг гэдэгт итгэдэг. Улс төр өөрийн эрх мэдлийн хүрээнд авлигатай тэмцэхэд бүх аргыг хэрэглэх нь зүйтэй..."

Mongolian Economy 2012 оны аравдугаар сар

АСУУДАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН “ХЯЗГААР”

Б.ЭНХЦЭЦЭГ

Одоогийн нөхцөл байдал Монгол Улсад нүүрлэсэн эдийн засгийн хамгийн хүнд хэцүү үе биш. Монголын эдийн засаг 2009 онд нэмэх бус хасах дүнтэй гарсан. Энэ бол хямрал. Харин өнөөдөр Монголын эдийн засгийн өсөлт хоёр оронтой тооноос “бууж” нэг оронтой тоогоор илэрхийлэгдэж буй. Гэхдээ хасах биш нэмэх утгаар.

Өнөөгийн нөхцөл байдал гэж товчхондоо 5.3 хувийн ДНБ-ий өсөлт, 14.9 хувийн өндөр инфляци, 32.4 хувийн чанаргүй зээлийн өсөлт, ДНБ-ий 227 хувьтай тэнцэх нийт өр, 1800 төгрөг даваад талийсан ам.долларын ханш, гадаадын хөрөнгө оруулалтын 70 хувийн уналт юм.

Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Роберт Шоэлхаммер “Хямрал бол асуултгүй мэдэгддэг илэрхий нөхцөл байдал. Хямрал гэдэг банкинд хадгалуулсан өөрийнхөө мөнгөө авч чадахгүйд хүрэх тэр нөхцөл байдлыг хэлдэг. Санаа зовоохоор эдийн засгийн олон үзүүлэлтүүд байна. Гэвч эдийн засгийн хүндрэл, хямралыг ялгах хэрэгтэй” гэж хэлсэн юм.

Дэлхийн банкнаас гаргасан өнгөрсөн долдугаар сарын тайланд “Уул уурхайн бус салбарын үйл ажиллагаа суларсантай холбоотойгоор эдийн засгийн өсөлт удааширч байна. Уул уурхайн салбар эерэг хэвээр байгаа ч дотоодын аж үйлдвэрлэл суларсаар байна” хэмээн бичсэн байгаа юм. Тэдний үзэж байгаагаар Эдийн засгийн ихээхэн тэнцвэргүй байдлын улмаас 2014 онд эдийн засгийн өсөлт зөөлрөх хандлагатай байгаа аж.

Гэвч “Өмнө нь 2009 онд хасах дүнтэй гарч хямарсан нөхцөл байдал 2015 онд давтагдах магадлалтай” гэж



Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг хэлсэн юм.

Хамгийн их хямраад байгаа гэх эдийн засгийг бүрдүүлэгч хэсэг болох дотоодын компаниудын хувьд дийлэнх нь ам.долларын зээлтэй учир энэ байдалд хүрсэн гэж үзэж байна. Харин банкууд гадаад эх үүсвэрээс зээлийн хөрөнгийнхөө дийлэнхийг бүрдүүлдэг гэх шалтгаанаар ам.долларын зээл санал болгодог.

Ам.долларын зээлтэй компаниудын зээлийн эргэн төлөлтийн хугацааг банкууд сунгахад хүрсэн ч, дараагийн удаад сунгах эрх байхгүй ба нэмэлтээр өгсөн хугацаанд төлөхгүй аваас чанаргүй зээлд шилжих учиртай.

Үндэсний Статистикийн хорооны гаргасан энэ жилийн эхний долоон сарын үзүүлэлтээр өмнөх оны мөн үетэй нь харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 32.4 хувиар өсөөд байгаа бол нийт зээлийн хэмжээнд эзлэх чанаргүй зээл 4.9 хувьтай байна. Үүнийг оны эцэс гэхэд зургаан хувьд хүрнэ гэж “UMC Holding” компанийн шинжээчид таамаглаад байна. Үүний зэрэгцээ орон сууцны моргейж зээлийн өсөлтийн улмаас өрхийн зээлийн хэмжээ 50 гаруй хувиар нэмэгджээ. Өрхийн жилийн орлого дахь дундаж өр 2013 онд 60 орчим хувь болж өссөн байгаа юм. Нийт зээлийн өсөлт таван сарын сүүлийг харвал 63 хувь хүртэл өсчээ. Өнгөрсөн хямралын өмнөх үе буюу 2007 оны 78 хувийн өсөлт рүү дөхөж байна гэсэн үг.

“MICC” хөрөнгө оруулалтын банкны ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ “Банкны салбар доргивол эдийн засаг тэр чигээрээ хямардаг. Энэ бол 2009 оны хямралаас тод харагдсан сургамж. Одоогийн нөхцөл байдал банкны салбар луу орчихгүй бол гайгүй. Банкууд үл хөдлөх хөрөнгийн салбарт өгч байгаа зээлээ багасгаж байгаа нь зөв. Учир нь нэг салбарт хэт их мөнгө

төвлөрүүлж болохгүй” гэсэн юм.

Монголбанк бодлогын хүүг өсгөхийн зэрэгцээ одоогийн нөхцөл байдлаас үүдэн банкуудын хөрвөх чадварыг муутгахгүй, хангаж байх үүднээс зарим нэг зохистой харьцаан дээр арга хэмжээ аваад буй. “Мөнгөний бодлогын хүүг өсгөсөн даруйд инфляци буураад, зээл зогсоод эхлэхгүй. Бодит эдийн засаг дахь нөлөөлөл гурван сарын дараагаас мэдрэгдэнэ. Гэхдээ манай байгууллагын зүгээс мөнгөний бодлогоос гадна төсөв сангийн бодлогоо давхар чангатгаж, шаардлагагүй зардлаа танахыг сануулж байгаа. Ингэж төсөв, мөнгөний бодлого хамтдаа чангарч байж богино хугацаанд үр дүн гарна” хэмээн Дэлхийн банкны эдийн засагч Ш.Алтанцэцэг хэлсэн юм. Өнгөрсөн жилүүдэд бодлогын хүүг өсгөхөд ам.долларын ханшийн хариу үйлдэл ямар байсныг эргээд харахад ерөнхийдөө тогтоон барихад нөлөө үзүүлдэг юм байна гэж дүгнэхэд хүргэж байгааг мэргэжилтнүүд хэлж буй.

Өнөөдөр өрхийн худалдан авах чадвар болон дотоодын эрэлтэд хүнд тусч байгаа гол хүчин зүйл нь өндөр инфляци гэж Дэлхийн банкны мэргэжилтнүүд сануулаад байгаа. Азийн хөгжлийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч Роберт Шоэлхаммер энэ тал дээр “ДНБ-ий өндөр өсөлтийг бий болгоход хэт анхааралд байна. Энэ нь инфляцийг бий болгож байдаг. Хэрвээ өсөлтийн дийлэнх нь инфляци болж хувираад байвал өндөр өсөлттэй байхын хэрэг юу байна. Инфляци бол алуурчин. Инфляциасаа дээгүүр хүүг тогтоо. Үгүй аваас аажимдаа идэгдэж дуусна” хэмээн хэлсэн юм.

Ханшийн дарамт дахь он жилүүд хэзээ төгсгөл болох вэ?

Урсгал дансны алдагдал ихэсч ДНБ-ий 30 хувьд хүрч, гадаадын хөрөнгө оруулалт буурч байгаагаас гадаад санхүүжилтийн цоорхойг ихэсгэж байна. Улмаар дотоодын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ суларч гадаад валютын нөөц буурсан гэдгийг Дэлхийн банкны тайланд дурьджээ.

> Өнөөгийн нөхцөл байдал гэж товчхондоо 5.3 хувийн ДНБ-ий өсөлт, 14.9 хувийн өндөр инфляци, 32.4 хувийн чанаргүй зээлийн өсөлт, ДНБ-ий 227 хувьтай тэнцэх нийт өр, 1800 төгрөг даваад талийсан ам.долларын ханш, гадаадын хөрөнгө оруулалтын 70 хувийн уналт юм.

Монгол Улс 1990 оноос хойш байнгын валютын ханшийн дарамтад орж ирсэн байдаг. Үүний шууд тусгал нь бизнес эрхлэгчид. Тэдний үйл ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж, валютын ханшийн эрсдэлд өртөмтгий болгож байгааг учирлах хувийн хэвшлийнхэн олон. Хамгийн том уршиг тарьж байгаа хүчин зүйл нь тодорхойгүй байдал. Хөрөнгө оруулагч Монголд хөрөнгө оруулахдаа орлого нь төгрөгөөр орж ирнэ гэж тооцоод, мөнгөн тэмдэгтийн валюттай харьцах ханшийн савалгааг харна. Гэтэл хэт их хэмжээгээр савлаад байх нь тодорхойгүй байдлыг бий болгодог.

Валютын ханш өсөх нь гаднын улсуудад бараа бүтээгдэхүүнээ экспортолдог үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлж, валютаа бариад манайд ирэх жуулчдын тоог өсгөх сайн тал буюу зоосны нөгөө тал бий. Бид бараг бүх зүйлээ импортоор авдаг улс. Гэвч манай улсын экспорт импортоос даваагүй цагт одоохондоо ханш өсөх нь ямар ч ашиггүйг мэргэжилтнүүд хэлж буй.

Өнгөрсөн жилээс хойш чангарсан ам.долларын төгрөгтэй харьцах хамгийн дээд ханш нь 1905 хүрсэн бол сүүлийн өдрүүдэд бууж байна. Цаашид Хятадтай байгуулсан хоёр улсын Төвбанкуудын хоорон дахь 2.44 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний юанийн своп хэлцлийн нөлөөгөөр оны эцэс гэхэд ам.доллар 1800 дээр тогтох төсөөллийг мэргэжилтнүүд хийсэн байна. Дээрх своп хэлцэл нь гурван жилийн хугацаатай. Гэвч энэ хэлцэл, мөн Монголбанкны мөнгөний бодлого, интервенцийн аль нь ч Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн өрсөлдөх чадварыг урт хугацаанд тодорхойлж мөн тогтоож чадахгүй.

“Ханшийг тогтоон барих үндсэн гаргалгаа нь эдийн засгийн зөв суурь бий болгох. Импортын бүх бүтээгдэхүүнийг орлуулна гэж эдийн засгийн боломжгүй зүйл ярих хэрэггүй. Жишээ нь, Монгол хэзээ ч машин, хүнд тоног төхөөрөмж үйлдвэрлэхгүй. Гэтэл хүнсний бүтээгдэхүүн жимс ногоо, хувцас гэсэн ойр зуурын бараа бүтээгдэхүүний зарим хэсгийг үйлдвэрлэх боломжтой. Харин эдгээр бүтээгдэхүүний эдийн засгийн үр ашиг, стратегийн түвшинд судлах хэрэгтэй” хэмээн Ө.Ганзориг хэлж байна.

Өнөөдрийн байдлаар манай улс импортыг орлож, экспортыг нэмэгдүүлнэ гэсэн зорилгынхоо хүрээнд хэдэн зуун төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэхээр эхнээс нь мөнгийг нь өгч эхлээд буй. Тэгвэл импортыг тэр чигт нь орлоно гэдэг манайх шиг гуравхан сая худалдан авагчтай зах зээлд учир дутагдалтай бөгөөд амьдрах чадваргүй мөрөөдөл. Энэ бол олон улс баталсан “факт”.

Таваарын зах зээл гэх мэт ханш нь огцом, байнга хэлбэлздэг зах зээлээс хамааралгүй экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж манай улсад өндөр бий. Тухайлбал, Хүнс тэр дундаа мах. Манайх 50 сая малтай. Тэгснээ огт малгүй газрын махны үнэтэй адилхан түвшний шахуу үнээр махаа дотооддоо худалдан авч хэрэглэдэг доголдол үүсчихсэн. Харин саяхнаас Япон улсад манай улс мах, ноос, ноолуур тэргүүтэй цөөнгүй төрлийн бүтээгдэхүүнийг татваргүйгээр шахуу нийлүүлэхээр болсон таатай мэдээ сонсогдоод буй.

Гэвч экспортын үйлдвэрүүд

байгуулахад зах зээлийн багтаамжаа хардаг. Манайх шиг гурван сая хүнтэй улсад зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд зарах өртөг нь бусад орныхоос өндөр байх магадлал бий. Харин бүгдийг гэхээсээ илүүтэй хүнсний үйлдвэрүүд болон бусад зөвхөн Монголын брэнд болж чадах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, дэлхийд өрсөлдөх чадвартай болгох нь зүйтэйг эдийн засагчид хэлж байгаа. Урт хугацаанд бид зөв зүйлд мөнгөө зарцуулбал экспорт импортоо давах ёстой. Тэгэхгүй бол эдийн засгийн өсөлтгүй болно.

Зохистой хэмжээнд үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь уул уурхайн хэт хамаарлаас ангижруулж, эдийн засгаа төрөлжүүлэх зорилготой нийцэх төдийгүй экспорт импортоос давж, үндэсний мөнгөн тэмдэгт валютын ханшид шахуулаад байхгүй болно. Өөрөөр хэлбэл, одоогийн нөхцөл байдалд амархан ороод байхааргүй бяр чадал эдийн засагт сууж, эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалах үндэс бүрдэнэ

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангана гэдэг нь эдийн засгийн оновчтой бодлогоор үнийг тогтворжуулж, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахад чиглэгдэх ёстой болохоос хоёр оронтой тоон өсөлтийн араас хөөцөлдөхөд хүчээ төвлөрүүлэхийг хэлдэггүй.

“Одоогийн нөхцөл байдлыг Эдийн засгийн хямрал бус Нийгмийн хямрал” хэмээн Ө.Ганзориг тодорхойлж байгаа бол Д.Ачит-эрдэнэ “Хямрал, хямрал гэж ярьсаар одоогийн сэтгэл зүйн хямралаа эдийн засгийнх болгочихож болохгүй” хэмээн сануулсан юм. Харин Дэлхийн банкны мэргэжилтнүүд “Эдийн засаг ба санхүүгийн тогтвортой байдлыг сэргээх нь яаралтай чухал байна” гэсэн билээ. ■

ГАДНЫН ХЭВЛЭЛД



Ханс-Вернер Зинн /ХБНГУ-ын эдийн засгийн судалгаа, шинжилгээний “Ifo” институтын ерөнхийлөгч, Мюньхен хотын их сургуулийн профессор/

БУХИМДУУЛСАН ПАРАЛЛЕЛЬ

Герман хэлнээс орчуулсан Х.ХУЛАН

Грек, Монгол улсууд юугаараа нийтлэг вэ? Эдгээр нь хоёулаа хөгжиж буй улс орон, Голланд өвчинд нэрвэгдсэн бөгөөд дотоодын эдийн засаг нь сул аж. Түүнчлэн эдгээр орнуудын нийгмийн дээд давхарга нь ард түмнийхээ эрх ашгийг хохироож баяжсан байна.

Монгол Улсад айлчилсныхаа дараа тус орныг Гректэй харьцуулмаар санагдлаа. Эдгээр нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтын дагуу дэлхийн хөгжилтэй орнуудын тоонд багтаагүй хөгжиж буй улс орнууд юм. Аль алинд нь эмх замбараагүй байдал ноёрхдог. Хотод хувийн орон сууцнууд ар араасаа цувран сүндэрлэх нь хот төлөвлөлт хэрэгждэггүйн улмаас засаг захиргааны тогтолцоо авлигад автсаныг илтгэх аж. Амьдралын стандартыг ихээхэн анхаардаг ч түүнийгээ гажуудуулан гуйвуулсан. Тухайлбал, орчин үеийн хийц загвар бүхий автомашин, iPad (айПэд), хавтгай дэлгэц, хиймэл дагуулын таваг болон Луи-Уитоны дэлгүүрээр дутаагүй. Харин зам харгуй болон нийтийн тээврийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд хэрэгцээтэй байна. Хөдөө аж ахуйг эс тооцвоос зөвхөн төр, худалдаа арилжаа ба олон улсын байгууллагууд л ажлын байр санал болгох аж.

Өвдсөн эдийн засаг

Үйлдвэрлэлийн салбар гэж алга. Газар тариалангаас гаралтай бүтээгдэхүүнд суурилсан нэмүү өртөг шингээсэн сүлжээ ч хөгжиж амжаагүй байна. Асар их хэмжээний буюу 40 сая мал сүрэгтэй, 2.9-хөн сая хүн амтай Монгол Улс нь Шинэ Зеландаас хөлдөөсөн сүү импортлох юм. Тэгвэл Грек нь Голландаас улаан лооль, Германаас оливийн тос оруулдаг. Үзэсгэлэнтэй байгаль, нээлттэй агаад нөхөрсөг ард түмэнтэй. Харьцуулж буй хоёр орон хоёулаа гайхамшигтай сайхан нутаг, зочломтгой хүмүүстэй ч аялал жуулчлал бүрэн утгаараа зөвхөн Грект л хөгжсөн. Түүнчлэн хоёр орны дотоодын эдийн засаг сул. Тиймээс импортын »

Амьдралын стандартыг ихээхэн анхаардаг ч түүнийгээ гажуудуулан гуйвуулсан. Тухайлбал, орчин үеийн хийц загвар бүхий автомашин, iPad (айПэд), хавтгай дэлгэц, хиймэл дагуулын таваг болон луи-уитоны дэлгүүрээр дутаагүй. Харин зам харгуй болон нийтийн тээврийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд хэрэгцээтэй байна. Хөдөө аж ахуйг эс тооцвоос зөвхөн төр, худалдаа арилжаа ба олон улсын байгууллагууд л ажлын байр санал болгох аж.

дийлэнх хэсгийг үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ экспортолж олсноос ангид мөнгөөр санхүүжүүлдэг. Монгол нь газар доорх байгалийн баялгаа, Грек харин өрийн бичгээ экспортлон амьжиргаагаа залгуулж байна. Үүнээс олж буй орлого амьдралын баталгааг бэхжүүлж байгаа ч өрсөлдөх чадвар бүхий аж үйлдвэр бий болгох хэмжээнд хүрэхгүй цалин хөлсийг үүсгэсэн.

Монгол Улсад айлчилсныхаа дараа тус орныг Гректэй харьцуулмаар санагдлаа. Эдгээр нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтын дагуу дэлхийн хөгжилтэй орнуудын тоонд багтаагүй хөгжиж буй улс орнууд юм. Аль алинд нь эмх замбараагүй байдал ноёрхдог.

Хоёр орон хоёулаа Голланд өвчинд нэрвэгдсэн. Эл үзэгдлийг анх Голланд улсад байгалийн хий олдсон 1960-аад оны үед ажигласан байдаг. Байгалийн хийн борлуулалтаас олсон ашиг орлого нь Голланд улсад ихээхэн хэмжээний мөнгө оруулсан. Үүнийгээ хувийн хэвшил болон төрийн албаны цалинг өсгөхөд ашигласан аж. Улмаар улс орны эдийн засгийн өрсөлдөх чадвар доройтсон. Вассенаарын гэрээ хэлэлцээрийг 1982 онд байгуулснаас хойш л балаг тарьсан цалингийн чиг хандлагыг зогсоож, эдийн засгаа аварсан гэдэг. Мөнгөний урсгалын хор уршигтай үр дагавар юунаас үүдэж тохиох нь ямар ч ялгаагүй аж. Үүнд, Монгол Улс ашигт малтмалаа борлуулах, Грек гадаадаас зээл авах, Европын Холбоонд шилжүүлэх, мөнгө хэвлэгч машины шуурхай үйл ажиллагаа, евро тогтолцооны бусад Төвбанкууд өрийн үнэт цаастай болохыг дурдаж болно. Ийм аргаар урсан орж ирэх мөнгө нь цалингийн хэм хэмжээг нэмэгдүүлдэг. Энэ нь боловсруулах аж үйлдвэрийн салбарыг сүйрэлд эсхүл бууруулахад хүргэнэ.

Грекийн Эдийн засгийн сайд Михалис Хрусохойдис “FAZ” сонинд өгсөн ярилцлагдаа ЕХ-ны эдгээр арга барил түүний улсынх нь өрсөлдөх чадварыг аль хэдийнээс дордуулсан гэж оновчтой тэмдэглэжээ. Тэрхүү санхүүгийн тусламжийн мөнгийг авсны эцэст “үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд хаалга барьж, оронд нь харин импортын компаниуд байгуулах болсон. Учир нь илүү их орлого олох боломж нээгдсэн. Эл явдал тус улсад жинхэнэ гамшгийн уршиг тарьсан билээ” хэмээв. Сайдыг залуу байхад экспортоос ашиг олохын тулд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж ажилладаг байжээ. Гэтэл ЕХ-ны санхүүгийн тэтгэлгийн нөлөөгөөр хөлсөө урсгаж хөдөлмөрлөх шаардлагагүй болсон аж.

Улс төрийн хүчнүүд, нөлөө бүхий эдийн засгийн сонирхлын улмаас тус улсыг ЕХ-нд хөдөлгөхгүй бариад байгаа нь Грект гамшиг үргэлжилсээр байгааг илтэнэ. ЕХ-ноос гарч, мөнгөнийхөө ханшийг бууруулж, өрсөлдөхүйц цалингаар эдийн засгаа сэргээн босгохын оронд хиймэл шалтгааны улмаас евро хэмээх мөнгөн тэмдэгтээс зуурсаар л байна.

Хямдхан зээл

Грекийн банкууд дампуурлаа зарлаваас тус улсын Төвбанк мөнгөний үнэлэмж бууруулснаас гарах алдагдлыг бүх ЕХ-ны гишүүн орнуудын нуруун дээр үүрүүлэх бодлоготой. Өөрөөр хэлбэл, эл дампуурлаас урьдчилан сэргийлж еврог аврах боломжийг гаргасаар л байна. Үүний үр дүнд Грекийн төр зөвшөөрөгдөх хэмжээний зээлийн хүүний өрөнд орсоор байх нөхцөл бүрдүүлжээ. Учир нь Европын Төвбанк нь Грек улсын бондыг эргүүлэн худалдаж авахад шаардлагатай мөнгөн тэтгэлгээр банкуудыг санхүүжүүлдэг. Цаашилбал, евро нь Грекийн болон гадаадын зээлдүүлэгчдэд Грекээс ул мөргүй арилж, мөнгөө гадаадад гаргах боломжтой хямдхан зээлийг үүсгэж байна. Баян грекчүүд хамгийн багадаа 100 тэрбум еврог Швейцарь дахь дансандаа хав дарсан гэж таамаглах аж.

Энэ ч гэсэн Монголтой жишиж үзэх түгшээсэн параллель мөн. Монголын хөрөнгө мөнгөтэй чинээлэг гэр бүлүүд хуулийн дагуу болон хууль бусаар газрын баялгаас олсон орлогын дийлэнх хувийг гадаад руу гаргах болжээ. Тэд оршин суух газраа гадаад руу шилжүүлж, өмнө нь хураасан хөрөнгөөрөө амьдрах тэрхүү Х өдөртөө зэхэж сууна. ■

ЗОЧИН

“БҮҮ ЗЭЭЛ, ХАРИН ХАДГАЛ”

Германы Олон улсын хөгжлийн агентлаг (GIZ)-ийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” (IMRI) хөтөлбөрөөс зохион байгуулсан “UB Impulse-2013” арга хэмжээнд Мюнхений их сургуулийн харъяа Германы “Ifo” эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгч Ханс-Вернер Зинн урилгаар оролцсон юм. Түүний 2013 оны аравдугаар сард манай сэтгүүлд гарсан ярилцлагыг нь Германы сэтгүүлд бичсэн нийтлэлтэй нь холбоотой дахин толилуулж байна.



Фотог Э.Зорилт

-Та Европын эдийн засгийн өнөөгийн хямралын талаар юу гэж бодож байна вэ?

-Европын хямрал хоёр талтай. Нэг нь санхүүгийн хямрал, нөгөө нь бодитоор нүүрлэсэн хямрал. Шаардлагатай тохиолдолд Засгийн газар бонд гаргаж, Европын Төвбанк амлалт өгснөөр санхүүгийн хямрал намжих тийшээ хандсан. Харин бодитоор нүүрлээд буй хямралын асуудлыг шийдвэрлэхэд амаргүй. Өмнөд Европын орнууд өрсөлдөх чадвараа алдсан бөгөөд ажилгүйдэл, ялангуяа залуусын дунд маш их газар авсан.

-Хөгжиж буй орнуудын эдийн засагт тулгараад буй сорилт хэр удаан үргэлжилнэ гэж Та бодож байна вэ?

-БНХАУ, ОХУ болон Бразил зэрэг орнуудын эдийн засгийн өсөлт удаашралтай байгаагаас дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн мөчлөг буурах болсон. Дээрх орнуудын эдийн засгийн өсөлтийн удаашрал удаан үргэлжлэхгүй гэж бодож байна. Монголын хувьд гол зах зээл болох БНХАУ-ын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний худалдан авалт буурсан нь сайны шинж биш гэдэг нь ойлгомжтой. Тус улсын хэрэгцээ дахин сэргэнэ гэж бодож байна.

-11 хувийн өсөлттэй байгаа Монголын эдийн засгийн өсөлтийн талаар таны бодол.

-Энэ бол тун сайн өсөлт. Гэхдээ БНХАУ-ын өсөлтийг дагадаг. Эдийн засгийн нөхцөлөөр аваад үзвэл Монгол Улсын нийт экспортын 90 хувь нь урд хөршөөсөө хамааралтай. Энэхүү үйл явц хүндэн байгаа боловч илүү сайн зохион байгуулах боломжтой. Нэг талаас хувийн хэвшлийнхний өсөлт ширүүн байгаа, нөгөө талаас Засгийн газрын зохицуулалт, төрийн дэд бүтэц учир дутагдалтай байгаа нь хоорондын харьцааг тодорхой хэмжээгээр алдагдуулсан гэж бодож байна.

Монгол Улсын импорт хэтэрхий их байна. Бусад орноос бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээний дотогш чиглэсэн урсгалаас хэтэрхий хамааралтай гэж болно. Гадаад худалдааны алдагдал ДНБ-ий 30 хувьтай тэнцэж, хэвийн байдлаа алдсан. Энэ алдагдлыг зайлшгүй зогсоох ёстой юм. Зарж борлуулах бэлэхэн байгалийн нөөцтэй байж Засгийн газрын бонд гаргах ямар ч шаардлагагүй юм. Хөрөнгө болон бараа, бүтээгдэхүүний импортыг ▸▸

дэмжсэн Чингис бондыг гаргах нь аюултай. Учир нь ам.долларааp зээл авч буй хэрэг бөгөөд үүний дүнд дотоодын мөнгөн тэмдэгт инфляцид өртөж, үнэгүйдэхэд хүрдэг. Өрөө төлөхөд маш их хэмжээний хүндрэлтэй тулгарах болно.

-Энэ нөхцөл байдлаас гарах ямар нэг шийдлийг Та олж харж байна уу. Засгийн газар юу хийж чадах вэ?

-Зардлаа хэмнэх шаардлагатай. Олж буй орлогоосоо хэтэрсэн зардалтай байж болохгүй. Засгийн газрын зүгээс Монголбанкны бодлогод хөндлөнгөөс оролцох ёсгүй. Төвбанк бодлогын хүүгийн ханшаа өсгөж, харин Засгийн газар Чингис бондоос хүүгийн татаас үзүүлдэг. Энэ хоёр хоорондоо харшиж байна.

Эдийн засгийн өсөлтийн үйл явц удаашрах нь зүйн хэрэг. Учир нь эдийн засаг хиймлээр өсч, хэт халсан байгаа. Энэ бол хөөс юм.

-Тэгвэл энэ хөөсийг хэрхэн арилгах вэ?

-Хэт их зардал гаргахгүй байх, ард иргэдэд бэлэн мөнгө тараахаа болих. Үүний оронд Тэтгэврийн сан байгуулах нь ирээдүйдээ зориулсан ямар нэг барьцтай зүйл хийж буй хэрэг.

-Эдийн засгийн өнөөгийн байдалтай холбоотойгоор таны зүгээс манай сэтгүүлийн уншигчдад санал болгох зүйл юу байна вэ?

-Хүмүүс мөнгөө хадгалах ёстой. Зардал хэтэрхий өндөр байгаа нь ойлгомжтой. Европт хөөс нэг л өдөр хагарсныг бид харсан шиг энд тийм зүйл тохиолдохыг үгүйсгэхгүй. Бүү зээл, харин хадгал. Хадгална гэхээр банкинд мөнгөө хийгээд хав дараад байх албагүй. Харин ч компаниудын хувьцааг худалдаж авч болох юм.

-Аливаа оронд эдийн засагчид ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

-Эдийн засагчид харилцан адилгүй төлөв байдал дахь макро эдийн засгийн харилцан үйлчлэл болон нөлөөллийг авч үздэг. Хувийн хэвшлийг бүрдүүлдэг эдийн засгийн дүрэм, журам тогтоож, бүтцийг бий болгох үүргийг тэд гүйцэтгэдэг. Энэ нь замын бөглөрөл үүсэхээс сэргийлэхийн тулд замын цагдаа ажилладагтай яг адил. Хувийн хэвшлүүд бол автомашины жолооч нар. Харин эдийн засагчдыг замын цагдаатай зүйрлэж болно.

-Таны эрдмийн ажлын сэдэв “Тодорхойгүй нөхцөлд гаргах эдийн засгийн шийдвэр” гэсэн байсан. Өнөөдөр бид үүнээс юу суралцаж, хэрэглэж болох вэ?

-Миний эрдмийн ажлын гол сэдвүүдийн нэг нь бага хөрөнгөтэй, хязгаарлагдмал хариуцлагатай үед хэтэрсэн эрсдэл үүрэх тухай. Монголын зарим банкууд дампуурч Засгийн газраас нь үзүүлсэн тусламжийн талаар тухайн үед би сонсож байсан. Энэ бол зайлсхийх ёстой асуудал мөнөөс мөн бөгөөд банкууд өдгөө эзэмшиж буй олон төрлийн хөрөнгөө эргэлтэд оруулан ашиглахаас өөр аргагүй байдалд оруулж буй. Хэрэв ингэхгүй юм бол банкууд татвар төлөгчдийг барьцаалан мөрийцөж буй хэрэг.

-Таны чухам ямар ажил Германы Засгийн газрыг улс төрийн реформ хийхэд хүргэж, нөлөөлсөн бэ?

-Нийгмийн тусламжийг идэвхжүүлэх зорилгоор хийсэн ажил маань “Agenda 2010” сэдэвт Шредерийн реформд нөлөө үзүүлсэн. Энэ нь амьжиргааны түвшинг бууруулалгүйгээр ажлын байр шинээр бий болгохын тулд мэргэжил, ур чадвар тааруухан хүмүүсийг тохирсон цалинтай ажилтай болгох зорилготой байв. Үүний тулд ажилгүйдлийн тэтгэмжийг бууруулж, ажилтай холбоотой татаас төлөх хэрэгтэй болсон. Энэ бодлого ажлын байрыг ихээр бий болгож, ялангуяа ур чадвар тааруухан хүмүүсийг ажлаар хангаж чадсан. Ажилтай болсноор тэд дунд зэргийн орлоготой болохын зэрэгцээ Засгийн газраас татаас өгч байв. Энэ нь ур чадвар муутай ажилтнууд болон нийгмийн бусад давхаргад илүү сайн зүйл болсон юм. Ажилгүй байсных нь төлөө хүмүүст мөнгө өгч, нийгмийн халамж үзүүлэх нь ямар ч утгагүй зүйл.

-“Ifo” эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн талаар танилцуулахгүй юу?

-“Ifo” хүрээлэн нь Германы төрийн санхүүжилттэй таван хүрээлэнгийн нэг. Эдийн засгийн чухал ач холбогдолтой судалгаа явуулдаг. Бид сар болгон 7000 компаниас тэдгээрийн бизнесийн нөхцөл байдал болон туршлагын талаар мэдээлэл авдаг. Бид дэлхий дахинд олон судлаачтай хамтран ажилладаг бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс 1000 гаруй эдийн засгийн профессорыг хамруулсан судалгааны сүлжээтэй.

-Таны бодлоор Монгол Улсад улс төрийн ямар реформ хэрэгтэй вэ?

-Миний бодлоор боловсролын хосолсон тогтолцоо хэрэгтэй юм шиг санагддаг. Монголд 100 гаруй их, дээд сургууль байгаа нь 2.9 сая хүний хувьд дэндүү ахадсан тоо. Хоёроос гурван их сургууль байхад хангалттай. Ийм олон сургуулийн оронд техник, мэргэжлийн сургуулиуд хэрэгтэй. Ажил, мэргэжил болгон өөрийн гэсэн “know-how” болон нарийвчилсан мэдлэгийг шаарддаг. Компаниудтай хамтран боловсролын хосолсон тогтолцоог бүрдүүлэх боломжтой юм.


Хууль тогтоомж, эмх замбараатай тогтолцоог мөн бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Энэ бол зайлшгүй чухал асуудал. Аливаа хотыг төлөвлөлт, тухайн бүсэд зориулсан хатуу чанд дүрэм, журамгүйгээр барьж байгуулах боломжгүй. Жишээ болгох үүднээс хууль бусаар баригдсан ганц, хоёр байшинг Засгийн газар нураах ёстой. Үүний дараа хүмүүс дүрэм, журмыг дагаж мөрдөх болно.

Улаанбаатар хот төдийгүй Монгол Улсын хэмжээнд дэд бүтцийг яаралтай сайжруулах хэрэгтэй. Төрийн зүгээс хувийн хэрэглээтэй холбоотой дэд бүтцийн хөрөнгө оруулалт хэтэрхий бага байна.

Улаанбаатар хотын хүн болгон л гар утастай, бараг айл өрх бүр хавтгай дэлгэцтэй зурагттай байх. Электрон бараа, төхөөрөмж хэрэглэхэд үнэхээр сайхан байдаг. Японоос автомашин худалдан авахаа багасгаж, улмаар гудамж, автомашины зогсоол болон байшин, барилгуудын дундах цэцэрлэгт хүрээлэн, амралт, зугаалгын талбай зэрэг олон нийтийн газрууд олноор байгуулахыг миний зүгээс санал болгомоор байна. Мөн эмнэлэг шинээр байгуулах хэрэгтэй. Миний бодлоор амьд дэд бүтэц энд дутагдаж байна. ■

ХӨМСӨГ

МОДООБАРЬСАН ЗУУН ЖИЛ




Б.ҮҮРИЙНТУЯА

Нобелийн энхтайвны шагналт эдийн засагч Саймон Кузнетс “Дэлхийд дөрвөн төрлийн улс байдаг; Хөгжсөн, хөгжөөгүй, Япон тэгээд Аргентин”.

Өмнөд Америкийн гурав дахь том эдийн засаг дампуурлаа зарлахад тун ойр иржээ. Нэгэн цагт эдийн засгаараа тэргүүлэгч топ 10-т нэгдэж байгалийн баялаг, газар тариалан, төрөлжсөн аж үйлдвэрийн салбараараа “гайхуулж” байсан тус улс өдгөө алтан дээр суусан гуйлгачин болж хувирав. Найм дахь удаагаа дампуурлын ирмэгт ирээд буй аргентинчууд алдаанаасаа суралцдаггүй учир нэрт эдийн засагч Кузнетс дээрхийг хэлсэн буйз аа.

Бондын өрөө эргэн төлөх чадваргүй болж байсан ТОП 10 орон /давтамж/



Эх сурвалж: The economist

XX зууны эхний 10 жилд Аргентин улс өсөлт, хөгжлийн үлгэр жишээ болж байв. Тухайлбал, 1903-1913 онд тус улсын ДНБ жилийн 7.7 хувийн өсөлт үзүүлэхийн зэрэгцээ дэлхийн эдийн засгийн чадавхын 1.2 хувийг бүрдүүлж байлаа. Тус улс Бразил, Чили, Их Британи болон колони орнуудыг үхрийн мах, сайн чанарын буудай болон бусад газар тариалангийн бүтээгдэхүүнээр хангаж гадаад худалдаагаа чамгүй хөгжүүлжсэний ачаар 1890 онд тохиосон өрийн хямралаас бүрэн гарахын зэрэгцээ дэлхийн хөрөнгийн зах зээлд эргэн ирсэн юм. Гэвч Дэлхийн I дайн эхэлснээр дэлхийн төдийгүй Аргентинийн эдийн засгийн уналт эрчимжсэн. Бизнесийн хамгийн том түншүүд болох Бразил, Их Британи импортоо танаж, хөрөнгө оруулалтаа бүрэн зогсоосон нь Аргентин улсад хүнд цохилт болсон. Төд удалгүй АНУ, Европын санхүүгийн их хямрал нүүрэлснээр Аргентиний модоо барих зуун жил эхэлсэн гэж болох.

Өөрийн биш өрөөлийн хэтэвчээс хэт хамааралтай байхын горыг амсаж эхэлсэн нь ийм учиртай аж.

Хэвлээд хүрэхгүй бол зээлээд хүргэнэ

Олон жил үргэлжилсэн санхүүгийн хүнд цохилтууд Аргентиний эдийн засгийг нам дарсан хэвээр байлаа. Зууны сүүлийн хагаст цэргийн дарангуйллаас ардчилсан чөлөөт зах зээл рүү шилжих үйл явц өрнөж, улмаар 1976 онд импортын бодлогоо зөөлрүүлж гадаад хөрөнгө оруулалтын хоригийг чөлөөлсөн. Зах зээлээ ийнхүү нээх нь эдийн засгийн өсөлт авчирна хэмээн тус улсын эрх баригчид найдаж байв. Харамсалтай нь импорттой өрсөлдөх чадамж, туршлага хийгээд хөрөнгө дутмаг байсан дотоодын компаниуд шат дараалан үүдээ барьж байлаа. Ингээд зогсохгүй Аргентин улс нэгэнтээ түнш гэгдэж байсан Их Британи улстай Фалкландын арлын төлөөх дайн эхлүүлсэн юм. Үүнийг шинжээчид газар нутгийн гэхээс илүүтэй эдийн засгийн уналтаа улс төрийн үймээнээр халхлах оролдлого байсан гэж үздэг. Гэвч тулаанд ялагдснаар Аргентиний улс төр хийгээд эдийн засгийн байдал улам дордсон. Үр дүн ийн гарахыг тооцоолоогүй тус улсын Засгийн газар мөнгө хэвлэх замаар алдаагаа засах гэсэн ч инфляциас өөр “өгөөж” байсангүй.

Зөв зарцуулваас зээл авах тийм ч муу зүйл биш. Харин зарлага нь орлогоосоо даваад ирвэл ямар үр дагавар авчирдагийг хэдэнтэй үзсэн аргетинчууд зээлсээр бас үрсээр байв. Өрийн дарамтыг хэтэрхий сайн мэдэх тус улсын удирдагчид төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл, хүний хөгжил гэх зэргээр буруу бодлого, болчимгүй үйлдлээ үргэлжлүүлсээр байсныг “улсаа хорлосон үйлдэл” хэмээн эдийн засагчид тодорхойлдог аж.

Хэтэвчээ хуурсан аргентинчууд

1990-ээд онд гадаадын хөрөнгө оруулалт татах ажилд Карлос Мэнэмээр ахлуулсан тус улсын эрх баригчид анхаарлаа хандуулаад байлаа.

Олон жил алдагдалтай ажиллаж байсан төрийн өмчит компаниудыг хувьлчах замаар хөрөнгө босгосноор нийт өрийнхөө нэлээдийг дараад байсан юм. Инфляци нэг оронтой тоо руу орж эдийн засаг нь ч сайжирч байсныг Олон улсын валютын сан тэргүүтэй байгууллагууд дуу нэгтэй магтаж байв. 1999 онд Аргентинийн Ерөнхийлөгч Карлос Мэнэм үүрэгт ажлаа хүлээлгэн өгсөн нь тус улсын эдийн засгийн түүхэн дэх хамгийн гүн уналтыг дагуулсан юм. Учир нь Мэнэмийн явуулж байсан песог (Аргентиний мөнгөн тэмдэгт) ам.доллартай тэнцүүлэх бодлого урагшгүй болж мөнгө үнэгүйдэж ам.доллар тэнгэрт хадаж эхэлсэн. Улмаар 1997 онд эхэлсэн Азийн санхүүгийн хямралаас үүдэн валютын урсгал хумигдсан нь Аргентинийн эдийн засгийн уналтыг улам хурдасгасан. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин нийт хүн амын 50 хувьд хүрсэн нь 10 хүүхэд тутмын долоо нь засгийнхаа тарьсан балгийг бүх насаараа үүрч амьдрана гэсэн статистик гарч байв. Түүнчлэн тус улсын өрийн хэмжээ ДНБ-ий 45.8 хувийг эзлэхийн зэрэгцээ инфляци 20.8 хувьд хүрсэн юм. Авлигын түвшин хэрээс хэтэрч хөрөнгө оруулагчид ч дайжиж эхлэв. Улмаар валютын нөөцгүй болсон Аргентинийн засгийн газрын өр 100 тэрбум ам.долларыг давж төлөх чадваргүйгээ зарласнаар дэлхийн эдийн засгийн түүхэн дэх хамгийн том уналт болсон юм.

“Өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалдана” гэдэгчлэн энэ явдалд аргентинчууд гадаадын хөрөнгө оруулагчдыг буруутгаж байлаа. Тогтворгүй эдийн засгийн уршигаар улс төрийн байдал ч сайнгүй байв. Мэнэмийн ажлыг хүлээн авсан Фернандэ де ла Руа мөн ерөнхийлөгчийн суудлаас огцров. Ийн дээрээ суудлаа олохгүй тэвдэх улс төрчдийн үл ойлголцол тус улсыг элгээр нь хэвтүүлж орхисон.


Өрийг өрөөр

Их хямралын дараахан буюу 2003 онд Нестор Кишнер ерөнхийлөгчөөр сонгогдон эдийн засгаа эрчимжүүлэх хэцүүхэн ажлыг хүлээн авсан юм. Тэрбээр 2005 онд өмнөх засгийн газрын өрийг дарах үүднээс ахин бонд гаргах санал хөрөнгө оруулагчдад тавьсан. Энэ нь өмнөх өрийн бичгээс 65 хувиар бага үнэлэгдэх бөгөөд өрийг өрөөр солих бодлого байсан гэж болно. Эл “солилцоо”-г нийт бонд эзэмшигчдийн дөрөвний гурав нь хүлээн зөвшөөрсөн юм. Ийнхүү Аргентин нийт өрийн дийлэнхийг барагдуулж чадсан билээ. Эл бодлого үр дүнгээ өгч 2010 он гэхэд тус улсын Засгийн газар нийт өрийнхөө 93 хувийг барагдуулсан байв. Харин үлдсэн хөрөнгө оруулагчид хуучин бондын өрийг бүрэн төлөхийг шаардсаар байгаа нь 2014 оны дампуурлыг дуудаж байгаа юм. Олон улсын валютын сангаас гаргасан 2014 оны “Олон улсын өрийн тайлан”-д тус улс өдгөө 111.5 тэрбум ам.долларын нийт өртэй байгаа аж.

1998-2002 оны хямралаас хойш Аргентин улс гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд “шоовдорлогдсон” гэж болно. Одоо тэдэнд хөрөнгө татаж болох бүхнээ дэлхийн зах зээл дээр нийлүүлэх боломж бий хэмээн дэлхийн эдийн засагчид үзэж байна. Тухайлбал, Хятадын шар буурцаг болон бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлттэй холбоотойгоор Аргентин улс тус бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой гэжээ. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээхүйц бодлого явуулах нь нэн тэргүүний ажил юм. Ингэснээр мөнгөний урсгал нэмэгдэхийн зэрэгцээ олон улсын хөрөнгийн бирж дээр өрсөлдөх боломж нээгдэх аж. Гэвч олон улсын шинжээчдийн аминчлан захиж буй зүйл ч Аргентинийн засгийн газар зардлаа танаж хүний хөгжил зэрэг өгөөжгүй салбарыг өрийн мөнгөөр санхүүжүүлэхээ зогсоох хэрэгтэй гэнэ. Хавтгайрсан халамжийн уршигаар 2014 оны байдлаар тус улсын ажилгүйдлийн түвшин нийт хүн амын 20 хувьтай тэнцэж байна. Мөн албан тоогоор 13 хувьтай байгаа гэх инфляци хэдийнэ 25 хувьд хүрсэн хэмээн судалгааны байгууллагууд мэдээлж байгаа ажээ. ■

Мифляцийн түвшин /жилээр

2



Эх сурвалж: INDEC

Гарчиг

3

1992 Инфляцийн өсөлтийг хазаарлах зорилгоор засгийн газар песо-ам. долларын ханшийг тэнцүүлэх бодлого хэрэгжүүлж эхлэв.

1998 Азийн санхүүгийн хямралаас улбаалан Аргентиний эдийн засаг унаж эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалт зогсож долоо дахь өрийн хямралд орсноо зарлав .

2001 Эдийн засгийн хатуу бодлого шаардан иргэд бослого гаргав. Аргентиний зээлжих зэрэглэлийг бууруулсан нь эдийн засагт хүнд цохилт болж олон улсын хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны ханш түүхэнд байгаагүйгээр буурсан.

2002 Эдуардо Дуалдэ Аргентиний ерөнхийлөгчөөр сонгогдов. Тэрбээр песогийн ханшийг бууруулснаар ам.доллартай тэнцүүлэх бодлого зогссон. Түүнчлэн эдийн засгаа сүйрэхээс сэргийлэх үүднэс валютын болон банкны гадаад арилжааг бүрэн зогсоосон.

2003 Аргентин улс Олон улсын валютын сантай зөвшилцөлд хүрснээр зээлийнхээ зөвхөн хүүг төлөхөөр болов.

ӨР

ӨЧИГДӨР ГРЕК, ӨНӨӨДӨР АРГЕНТИН, МАРГААШ МОНГОЛ


Б.ТУЯА

Саяхан болж өнгөрсөн БНХАУ-ын даргын айлчлалд зориулсан хүндэтгэлийн чуулганаар алхаа хайж сошиал медиагаар “онигоо” болсон УИХ-ын дарга маань өөрөө ч хошигнох дуртай нэгэн бололтой. Тэрбээр өнгөрсөн дөрөвдүгээр сард “Бид өргүй юм байна” хэмээн жиргэжээ. Түүний жиргээг наргиа байсан гэж найдъя. Учир нь мөнгө цаас болж инфляцид дарлуулах Монгол Улсын хоёр сая гаруй иргэний амьдрал “өргүй” Монгол өөдлөхгүй байгааг гэрчлэх.


УИХ-ын даргын жиргээний зурагт ДНБ-д эзлэх өрийн хэмжээ нь хамгийн их байгаа орнуудыг жагсаажээ. Монгол эл жагсаалтад бичигдээгүй нь аз. Гэвч үнэн хэрэгтээ Хятад, Тайландын дунд цохиж явах учиртай аж.

Нийт өр гэдэг нь тухайн улсын гадаад, дотоод, Засгийн газрын, хувийн хэвшлийн гээд бүхий л өрийг багтаан авч үздэг. Энэхүү жагсаалтад хөгжингүй, хөгжиж буй орноор ангилан, харьцуулан нийт өрийн дунджийг тогтоосон байна.

Ийн хөгжингүй орнуудын нийт өрийн дундаж ДНБ-ийнх нь 347 хувьтай тэнцэж буй бол хөгжиж буй орнуудынх 157 хувьтай байх аж. Тэгвэл манай улсын нийт өрийн дундаж хэдийнээ хөгжиж буй эдийн засагтай орны дунджийг даваад зогсохгүй өнгөрсөн онд 227 хувиар “цойлсон” байгаа юм.




1



Эх сурвалж: Монголбанк/Дэлхийн банк

2



Эх сурвалж: Монголбанк/Дэлхийн банк

Тэгэхээр бид өртэй нь гарцаагүй. Тэр бүүхэл, өдгөө 19.88 тэрбум ам.долларт хүрээд буй гадаад өр Монгол Улсын иргэн бүрт 12 сая орчим ам.долларын өрийн дарамт үүрүүлж байна.

Өр нь орлогоо давсан орнуудыг Грек, Аргентин тэргүүлдэг. Тэгвэл Монгол тус орнуудын эгнээнд шилжих нь цаг хугацааны асуудал болж. Хоёрхон жилийн өмнө манай улсын гадаад өр таван тэрбум ам.доллар орчим байж. Алдарт “ногоон”-ы ханш ч харьцангуй бага буюу 1400 төгрөгөөс хэтэрч байсангүй. Гэтэл өнөөдөр төгрөг гээч нь шалдаа бууж жил хүрэхгүй хугацаанд 36 хувиар суларсан гэх статистик бий. Төгрөг зурагтай цаас болохын хэрээр өрөндөө өгөх мөнгөн дүн үржсээр байхыг сануулахад илүүдэхгүй биз. Тухайлбал, Чингис бондын нийт төлбөрт л гэхэд (хүүгийн төлбөрийг багтаасан) 2,114,474,699,430.0 төгрөг төлөхөөр тооцоолсон байдаг. Үүнийг гаргахдаа нэг ам.доллар 1398 төгрөг байна хэмээн тооцжээ. Гэтэл өдгөө ам.долларын ханш 1800 төгрөг давсан байгаа нь дээрх уншиж үл барам тоо нэмэгдэх нөхцөл болж байна. Өрийн дарамт нэмэгдсээр.

Засгийн газрын бондын эргэн төлөлт /ам.доллараар/

3


2017 он	Хөгжлийн банк	580 сая
2018 он	Чингис бонд	500 сая
2022 он	Чингис бонд	1 тэрбум

Өдөр ирэх тусам доройтож буй иргэдийнхээ амьдралыг өөд нь татах зорилгоор ДНБ-ий 76 орчим хувьтай тэнцэх мөнгийг төрөөс зарцуулаад байгаа гэх. Дэлхийн банкнаас энэ оны долдугаар сард гаргасан “Эдийн засгийн өөрчлөлт болон тулгамдсан асуудлууд” тайланд “Өрхийн өрийн хэмжээ нэмэгдэж байгаад маш нягт нарийн мониторинг хийх шаардлагатай. Орон сууцны моргейж зээлийн өсөлтийн улмаас өрхийн зээлийн хэмжээ 50 гаруй хувиар нэмэгджээ. Өрхийн жилийн орлого дахь өрхийн дундаж өр 2013 онд 60 орчим хувь болж өсчээ” гэснийг онцолж байна.

Инфляци гаарсан, Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 3.1 тэрбум ам.долларааp зузаарсныг “Өргүй Монгол” ТББ-аас мэдэгдсэн. Үүгээр ч зогсохгүй 2015-2017 оны төсвийн хүрээний мэдэгдэлд гадаад өрийн хэмжээг 2017 онд 21.3 их наяд, Засгийн газрын баталгааг 6.1 их наяд төгрөг хүртэл тус тус нэмэгдүүлэхээр зэхэж буйг тус байгууллага эрс бууруушааж байгаа юм.

Зах зээлийн үүднээс аваад үзвэл Засгийн газрын гаргасан бонд нэртэй өрүүд тун ашигтай бас амжилттай алхам болсон. Харин нэр төр, үр өгөөж талаас нь яривал төрийн тарьсан хэргийн төлөөсийг иргэд үүрч амьдрах болов. Үнийн хөөрөгдөлийг хүчрэхээ байсан ард түмэн ажилгүйчүүдийн эгнээнд элсэж байна. Яг л грек, аргентинчууд шиг. “Өглөгч” төрийнхөө буянаар үр хойчдоо өрөөс өөр үлдээх өвгүй болж буй нь төрийн түшээдийн нүдэнд ил, чихэнд тод байлтай. Өнгөрсөн онд таван тэрбум орчим ам.доллар байсан манай улсын гадаад өр ганц жилийн дотор 14 тэрбумаар нэмэгджээ.

4 Гадаад өрийн өсөлт




Хөгжиж буй гэх ч хөгжил буурай орнуудтай эн тэнцэж яваа манай улсын эдийн засгийн “зүрх” нь уул уурхай. Дэлхийн банкны тайланд дурдсанаар уул уурхайн салбарын өсөлт дунд хугацаанд (2013-2018 он) бууралттай байх бөгөөд өсөлт жилд дунджаар 12 хувьтай байх гэнэ. “Тэжээдэг” салбар нь өсөлт үзүүлэхээ болчихвол өнөөх зангаараа зээл тавихаар зэхэх үү. Инфляциас өөр өсөлтгүй болоход гадаадын баячуудын түрийвчний хачиг болж улсынхаа нэрээр дэнчин тавин өгсөн хэдийг нь үрсээр байх уу зэрэг асуултыг хүн бүр асууж байгаа. Харамсалтай нь өөрийн мэт санаж ухаан жолоогүй үрсэн, үрдэг, үрсээр ч байх төр засгийн түшээд насан эцэслэхийн цагт үр хүүхэд чинь үлдэнэ гэдгийг санахад илүүдэхгүй болов уу.


5 Сүүлд гаргасан бондын жагсаалт

Issue	ISIN	Coupon	Volume	End of placement	Maturity date
Trade and Development Bank of Mongolia, 2017, CNY - International bonds	XS1013890220	10%	CNY700 000 000	01/15/2014	01/21/2017
Mongolia, 2018 - International bonds	US60937GAA40	4.125%	USD500 000 000	11/28/2012	01/05/2018
Mongolia, 2022 - International bonds	US60937GAB23	5.125%	USD1 000 000 000	11/28/2012	12/05/2022
Trade and Development Bank of Mongolia, 2015 - International bonds	XS0831336192	8.50%	USD300 000 000	09/13/2012	09/20/2015
Mongolian Mining Corp, 2017 - International bonds	USG6264VAA01	8.875%	USD600 000 000	03/21/2012	03/29/2017
Development Bank of Mongolia, 2017 - International bonds	XS0755567301	5.750%	USD580 000 000	03/14/2012	03/21/2017
Trade and Development Bank of Mongolia, 2015 (conv.) - International bonds	XS0559513493	12.50%	USD25 000 000	11/10/2010	11/17/2015

Эх сурвалж: www.cbondn.com wikimedia.org

6 Өрийн нарийвчилсан статистик болон инфографик







O: Нийт өр
A: Урт хугацааны гадаад өр
A3: Арилжааны банк болон бусад зээлдэгч
A4: Хувийн хэвшил /батлан даагаагүй
A5: Бонд
A6: Засгийн газрын болон Засгийн газрын батлан даалттай хувийн хэвшлийн гадаад өр
A7: Албан ёсны зээлдэгчид
A8: Олон талт
A9: Хоёр талт
A10: Хувийн хэвшлийн зээлдэгчид
A11: Бусад хувийн хэвшлийн зээлдэгч
A13:
B: Олон улсын валютын сангаас авсан зээлийн ашиглалт
C: Богино хугацааны гадаад өр

Өрийн тойргийг тоймлон унших нь
O=A+B+C
A=A3+A6
A3=A4+A5
A6=A7+A10
A7=A8+A9
A10=A11+A12+A13

7 Гадаад өрийн нийт хэмжээ /Буурай хөгжилтэй орнуудтай харьцуулах нь



8 Гадаад өр (дэлхийд)



An Initiative of
THE FORUM OF YOUNG GLOBAL LEADERS

MONGOLIA
YGL LEARNING JOURNEY
2014

9-р сарын 12-14нд

Mongolia
YGL Learning Journey 2014

Дэлхийн 50 гаруй YGL-үүд болон
Монголын Залуу Манлайлагчид нэг дор цуглаж байна.

YGL (Young Global Leader) гэж хэн бэ?

Дэлхийн Эдийн Засгийн Форумын дэргэд Профессор Клаус Швабын санаачлагаар 2004 онд байгуулагдсан 900 гаруй гишүүдтэй энэ нийгэмлэг нь бидний өмнө тулгарч буй бүхий л асуудлаар цогц шийдэл гаргах дэлхийн түвшний удирдагч залуусыг бэлдэж, хооронд нь харилцан хамтран ажиллах боломж бүрдүүлдэг глобал платформ юм.

Зарим YGL-ийг дурдвал:

MaBeo Renzi - Итали улсын төдийгүй Европын Холбооны улсуудын хамгийн залуу ерөнхий сайдаар сонгогдсон;
Larry Page - Google компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал
Marissa Mayer - Yahoo компаний Гүйцэтгэх захирал...

Монгол YGL-уудаас дурдвал:

С. Оюун - Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайд
Д. Зоригт - УИХ-ын Гишүүн асан, Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Сайд асан
Ч. Ганхуяг - Ард Санхүүгийн Нэгдэлийн Гүйцэтгэх Захирал
Ж. Баярцэцэг - Хууль Зүйн Яамны Төрийн Нарийн Бичгийн Дарга
Б. Бямбасайхан - Монголын Бизнесийн Зөвлөлийн ТУЗ-ийн Дарга, “NOVA TERRA” ХХК-ийн Захирал
В. Ганзориг - Медиа Группын Захирал



Дэмжигч Байгууллагууд

BISHRELT · ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ · HYUNDAI Truck & Bus · GEREGE Ultra Premium Vodka · APU COMPANY Absolute. Pure. Unique. · Black pearl Restaurant

WILD · VLVT MEMBERS CLUB · MONGOLTV · MEDIA GROUP · MONGOLIAN ECONOMY · SOUND OF MONGOLIA

www.younggloballeaders.org · fb.com/groups/YGLLJ · www.weforum.org

АЙЛЧЛАЛ

ХӨГЖИЛ ӨӨД ХҮЧИРХЭГ ХӨРШИЙН ХАМТ

И.ОТГОНЖАРГАЛ

Орос, Хятадын төрийн тэргүүнүүд хагас сар ч хүрэхгүйн хугацаанд Монголд айлчилж байгаа нь түүхэнд байгаагүй үйл явдал юм. Тийм ч учраас олон улсын анхаарлыг ихэд татаж байна. БНХАУ-ын дарга Си Зиньпиний айлчлалын талаарх мэдээлэл хуучирч амжаагүй байхад ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халх голын ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад энэ сарын 3-нд айлчлах нь тодорхой болж байна. Хятадын даргын дараахан бууж буй В.Путин Монголд хагас өдөр саатах бололтой.Тэрбээр өмнө 2009 оны тавдугаар сард ОХУ-ын Засгийн газрын тэргүүн байхдаа манайд айлчилж байсан удаатай. Харин энэ удаа ОХУ-ын Ерөнхийлөгчийн хувиар анхны айлчлалаа хийх гэж байна. Түүний айлчлалын үр дүнгийн талаар бид дараагийнхаа сэтгүүлд тоймлон бичих учраас энэ удаа ингээд зогсоё. Харин бидний түлхүү хөндөх сэдэв бол БНХАУ-ын дарга Си Зиньпиний айчлалын үр дүнгийн тухай юм.



Энэ онд Монгол-Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жил, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг шинэчилсэний 20 жилийн ой, мөн Хоёр улсын найрсаг солилцооны жил болж байгаа зэрэг түүхэн тэмдэглэлт үйл явдлууд давхцаж байгаа нь урд хөршийн төрийн тэргүүний айлчлалыг улам бүр утга төгөлдөр болгосон билээ.

Монгол Улс нь шинэ Хятад улстай дипломат харилцаа тогтоосон анхны орнуудын нэг. Түүнчлэн Хятад нь Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгийн анх хүлээн зөвшөөрсөн орон төдийгүй, Монголд Элчин сайдын ▸▸

яамаа нээсэн /1950 онд/ хоёр дахь улс юм. Дэлхийн хамгийн олон хөрш оронтой /14-18 улстай/ гэгддэг Хятад улстай хамааралтай газар нутаг хилийн маргаан тасардаггүй. Тэгвэл Монгол Улс нь урд, хойд хөрштэйгээ газар нутгийн хувьд нэг мм-ын ч хилийн маргаангүйгээр хилээ тогтоож, НҮБ-д бүртгүүлж чадсан орон юм. 1962 онд Монгол Хятад хоёр улс хилээ тогтоосон. Хил тогтоох шалтгаан нь 1962 онд Энэтхэг Хятад хоёр улс нь хилийн маргаанаас болж хоорондоо муудсан. Харин энэ үед Хятад улс нь бусад хөрштэйгээ бүгдтэй нь хилийн маргаантай байж байлддаг улс биш гэдгээ харуулахын тулд Вьетнам, Лаос, Тайланд, Монгол гэсэн улстай хилээ тогтоосон гэдэг. Хоёр том гүрний дунд орших цөөхөн хүн амтай, өргөн уудам нутагтай Монгол орны хувьд урд, хойд хоёр хөрштэйгээ хилийн маргаангүй байдаг нь геополитикийн болоод эдийн засгийн хувьд том давуу тал юм. Үүнийг ч Хятадын дарга айлчлалынхаа үеэр сайшаан тэмдэглэсэн.

Хятадын даргын айлчлал хоёр орны эдийн засаг, улс төр, гадаад бодлогын хамтын ажиллагааны чиглэлээр шинэ боломжийг нээсэн, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргасан, хамтдаа хөгжихийг эрмэлзсэн гээд ач холбогдол өндөртэй боллоо.

Улс төрийн харилцаа, Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа, Боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа, Олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа, Бусад гэсэн таван хэсэгтэй Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тухаглалд хоёр орон найрсаг, харилцан ашигтай хамтран хөгжих тухай олон асуудлыг тунхаглажээ.

Айлчлалын үеэр үзэглэсэн 24 гэрээний наймыг нь манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж байгуулсан бол эдийн засгийн ач холбогдол өндөртэй түүхэн гэрээг зам тээвэр, дэд бүтцийн салбарт зурлаа. Тодруулбал, талууд 1991 оны “Монгол Улс БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай хэлэлцээр”-ийг шинэчилж буйн ач холбогдлыг өндрөөр үнэлж, тууштай хэрэгжүүлэхээ илэрхийлсэн явдал юм. Үүнд: “Хятадын тал өөрийн улсын Хойд болон Зүүн Хойд бүс нутгийн гадаад худалдааны нээлттэй боомтуудыг Монгол Улсын далайн гарц болгон ашиглуулна” гэж тусгажээ. Энэ нь Монголын ашигт малтмал тэргүүтэй экспортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэх сайн талтай. Өмнө нь манай улс Хятадын нутгаар тээвэр хийх албан ёсны зөвшөөрөлгүй байсан бөгөөд Монголын нүүрс Эрээн, Ганцмодны боомтоос цааш явдаггүй байлаа. Одоо бол Хятадаас гадна Япон, Солонгос гэсэн гуравдагч зах зээлд гарах боломжтой болох юм.

Үүнээс гадна төмөр замын боомтын тоог нэмэгдүүлэх Ази-Европыг холбох хамгийн ойр, боломжит коридоруудыг нээх нь манай улсын эдийн засгийн тэлэлт, бүс нутгийн хөгжилд онцгой хувь нэмэртэй. Манайх өдгөө нийт экспортын 90.4 хувь, импортын 30 хувийг БНХАУ-тай хийж байна. Монгол Улсад хөрөнгө оруулагч орнуудыг Хятад улс сүүлийн 14 жил тэргүүлж буй.

“Монголд үйлдвэрлэсэн ямар ч бараа бүтээгдэхүүнийг Хятад улс худалдан авахад бэлэн гэж Си Зиньпин дарга мэдэгдсэн нь Монголын цаашдын ирээдүйд асар их болоцоо олгож байна” гэж нийтлэлч Баабар хэлжээ. Мөн түүний айчлал Монгол улс Хятад хэмээх дэлхийн тэргүүлэгч эдийн засагтай олон талаар хамтарч ажиллаж болохыг санууллаа. Үнэхээр ч Си Зиньпин даргын хэлсэн үг бүхэнд Хятад улс нь Монголыг том түншээ гэж үздэг нь илт байсан юм.


Айлчлалын бас нэгэн чухал шийдвэр нь Хятадын Төвбанктай Монголбанк своп хэлцлийн хэмжээг таван тэрбум юаниар нэмлээ. Манай улсын гадаад худалдааны 60-70 орчим хувь нь юань дээр суурилж хийгддэг учраас юань нь манай хувьд ам.долларааас дутахгүй валют. Сүүлийн хоёр жилд уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний үнэ унасантай холбоотойгоор Монголын эдийн засагт өнөөдөр валютын орлого муу, эдийн засаг уналтын байдалтай байгаа. Тиймээс Хятадын даргын айлчлалтай холбоотой дотоод, гадаадын хэвлэлд Монголд их мөнгө өгнө байх гэсэн таамаг дэвшүүлээд байсан. Харин айлчлалын үеэр хэвлэлд урьдчилан бичиж байсан шиг их мөнгө өгөөгүй ч гэлээ таван тэрбум юанийн своп хэлцэл гэдэг бол бараг нэг тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгө гэдгийг эдийн засагчид тэмдэглэж буй юм. Тэгэхээр энэ нь огцом дундраад байсан Төвбанкны нөөцийг зузаатгаж өгч байгаа гэсэн үг. Үүнийг дагаад 1900 төгрөгтэй харьцаж байсан ам.долларын ханш буурах хандлагатай болж өнгөрсөн сарын 30-ны байдлаар 1790 төгрөг рүү ороод байна.

Манай хоёр орны гадаад худалдааны хэмжээ 2002 онд 324 сая ам.доллар байсан бол 2013 онд зургаан тэрбум ам.долларт хүрээд байгаа билээ. Си Зиньпин үүнийг 2020 он гэхэд 10 тэрбумд хүргэх санал тавив.

Түүнчлэн Тунхаг бичигт туссанаар талууд өөрийн улсын эрчим хүчний хөгжлийн стратеги болон бодит хэрэгцээ шаардлагатай уялдуулан эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлж, Монголд нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц хамтран байгуулах, Хятадад эрчим хүч экспортлохтой холбогдох хэлэлцээрийг байгуулах зэрэг асуудлыг эрчимтэй судлахаар болсон.

Хятадын тал ирэх таван жилд Монголын нийт 1000 хүнийг давтан сургалтад хамруулж, Засгийн газрын тэтгэлгээр мөн тооны оюутныг сургах, 500 цэргийн албан хаагчийн мэргэжил дээшлүүлэхээс гадна иргэдийн солилцоог идэвхжүүлэх, харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх бодлого баримтлан, 500 залуу, 250 сэтгүүлчийг Хятадад айлчлахыг урилаа.

Хятад Монгол хоёр улс өнө эртний түүхэн харилцаатай улс ч гэлээ өдгөө хүртэл нэг нэгнийхээ түүх соёл, зан заншил, ахуй амьдралыг төдийлэн таньж мэдээгүй ирсэн. Тиймээс иргэдийн солилцоог идэвхжүүлэх нь хоёр орны ард түмний бодол сэтгэхүйн ан цавыг ойртуулах, нэгнээ таньж мэдэхэд том дэмжлэг болох нь дамжиггүй. Айлчлалын үеэр Хятад Монгол хоёр уул усаараа холбогдсон хөршийн хувьд найрсаг хамтын ажиллагаатай ч гэлээ ард түмнийх



нь дунд найрсаг харилцаа байгаа юу гэвэл эргэлзээтэй. Хятад судлаач, монгол эрдэмтэд энэ нь ерөөсөө нэгнээ сайн таньж мэдээгүйтэй л холбоотой хэмээн тэмдэглэж байна. Энэ үнэн. Бид АНУ, Европ, ОХУ-ын иргэдийн зан заншил, түүх, соёлыг нь мэддэг шигээ Хятадыг сайн мэдэхгүй. Хятадууд ч мөн ялгаагүй бусдыг сайн мэддэг шигээ монголчуудыг сайн мэдэхгүй. Тиймээс нэгнээ таньж мэдэх эхлэл энэ айлчлалын үеэр тавигдав. “Хүний сайныг ханилан байж мэднэ, Хүлгийн сайныг унан байж мэднэ” гэсэн Монгол ардын зүйр цэцэн үгийг Си Зиньпин дарга манай Парламентад хэлсэн үгэндээ ишилсэн нь үүнийг гэрчлэх биз ээ.

Хятадын хамгийн орчин үеийн улс, дэлхийн эдийн засгийн хоёр дахь том гүрэн шинэчлэлт өөрчлөлтийн төлөөх эцэж цуцашгүй хөгжлийн галт тэргэндээ хөрш Монгол орноо хамтдаа суухыг урилаа. Си дарга “Хятад хүн хэлсэнээ хийдэг, хийснээ дуусгадаг. Хятад улсын хэлсэн үг, амласан амлалт заавал биелэх, хэрэгжих ёстой” гэлээ. Монгол Улс ч сайны ерөөлөөр хөгжил өөд хүчирхэг хөршийнхөө тусламжтайгаар хүчин зүтгэх нь мэдээж.

Монгол-Хятадын сайн хөршийн, найрсаг хамтын ажиллагаа, хамтын хөгжилд амжилт хүсье.

Зээлийн хэлэлцээр:

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 500 сая ам.долларын экспортын зээлийг ашиглах тухай Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 45,65 сая ам.долларын “Шинэ зууны боловсрол” төслийг хэрэгжүүлнэ. Энэхүү төслийг 1.5 жилийн хугацаанд зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. Зээл нь жилийн 2% хүүтэй, 20 жилийн хугацаатай, үндсэн зээлээс эхний долоон жил чөлөөлнө.

Төсөл хэрэгжсэнээр нийслэлийн 97, аймгийн төвийн 55, сумын 473, нийт 625 сургууль шилэн кабель бүхий интернетийн үйлчилгээг хүртэх боломжтой болно.

Засгийн газар хоорондын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр:

Монгол, Хятад хоёр улсын найрсаг харилцаа, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг улам хөгжүүлэх зорилготой.

Өндөр дээд хэмжээний айлчлалаар Хятадын засгийн газраас тогтсон уламжлалын дагуу аливаа улсад буцалтгүй тусламж үзүүлдэг байна. Энэ жишгийн дагуу Хятадын талаас дээд хэмжээний айлчлалын үеэр Монголын Засгийн газарт 300 сая юанийн буцалтгүй тусламж олгож буй. Хоёр талын харилцан тохирсон төслүүдийг энэхүү хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлнэ. Буцалтгүй тусламжийн хөрөнгийг нийгмийн салбар, ард иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэхийг тэргүүлэх чиглэл болгож байгаа болно.

“ Цахим эрүүл мэнд төсөл”

БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих 500 сая ам.долларын хүрээнд хэрэгжих “Цахим эрүүл мэнд” төсөл нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн 48 байгууллагад эмнэлгийн мэдээллийн технологийн системийг бий болгох зорилготой.

Төслийн хүрээнд 14,9 сая ам.долларын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон бусад дагалдах бараа, бүтээгдэхүүн, эмнэлгийн мэдээллийн програм хангамж болон бусад үйлчилгээ нийлүүлэгдэнэ. ■

СУДАЛГАА

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ 2014 ОНЫ ЭЦЭСТ (шинэчилсэн таамаг)

Санхүүгийн зах зээлийн холбоо, "Мандал Ассет менежмент" компани хамтран жилд хоёр удаа Монголын эдийн засгийн төлөвийг гаргадаг билээ.

Дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2014 оны эцэст өөдрөг төсөөлөлтэй буюу өсөх хандлагатай байна. Энэ нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтөд илүү хүчтэй түлхэц болохоор байгаа юм. АНУ-ын Холбооны банк эдийн засгаа дэмжихэд чиглэсэн 85 тэрбум ам.долларын бонд худалдан авалтаа хумьж эхэлсэн нь сэргэлтийн хурдыг бага зэрэг сааруулж болзошгүй байна.

2014 онд дэлхийн ДНБ-ий өсөлт дунджаар 3.2 хувь, АНУ 2.7 хувь, Евро бүсийн 1.1 хувь, Хятадын эдийн засгийн өсөлт 7.3 хувь хувь байхаар таамаглагдаж байна. Энэ нь оны эхэнд хийж байсан таамгуудтай харьцуулахад Евро бүсийн өсөлтийг нэмэгдүүлсэн, харин Хятадын өсөлтийг бууруулсан байдалтай байна.

	Дэлхий		АНУ		Евро бүс		Хятад	
	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015
Fitch	2.7	3.1	2.7	3.1	1.1	1.5	7.3	7
ЭЗХХАБ	3.4	3.9	2.6	3.5	1.2	1.7	7.4	7.3
CitiBank	3.1	3.4	2.8	3.1	1.1	1.3	7.3	7
Дэлхийн банк	3.4	3.5	2.7	3.2	1.1	1.2	7.4	7.1
ОУВС	3.7	3.9	2.8	3	1	1.4	7.5	7.3

Эх сурвалж: дурдсан байгууллагуудын эдийн засгийн тайлан


Монголын эдийн засаг 2014 оны эхний хагаст

2014 оны эхний хагаст эдийн засгийн өсөлттэй байсан хэдий ч эдийн засгийн бүтэц хэврэг байгаа тул бусад чухал үзүүлэлтүүд муудаж, уналтын дохиог өгч эхэлсэн.

Бодлогын дэмжлэгтэй өсөлт нь төлбөрийн тэнцэл, валютын ханш болон инфляцийн тухайд дарамт учруулсан.

2013 оны төгсгөлд 12.3 хувиас энэ оны эхний улиралд 7.4 хувь болж саарсан бөгөөд эхний зургаан сарын байдлаар 5.3 хувийн өсөлттэй байна.

Голлох зургаан үзүүлэлтээр эдийн засгийн байдлыг дүгнэдэг графикаас харахад эрүүл мэнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ялимгүй буурч дөрвөн оноо болсон байна.



Эх сурвалж: Санхүүгийн зах зээлийн холбоо

2014 оныг дуустал эдийн засгийн чиг хандлагад болон төлөв байдалд нөлөөлөх хүчин зүйлс:

• улс төрийн тогтворгүй байдал

• Оюу Толгойн далд уурхайн санхүүжилтийн асуудал

• хоёр хөрш орнуудын төрийн тэргүүнүүдийн айлчлал зэрэг нь гол нөлөө үзүүлэхээр байна.

Юуны өмнө, улс төрийн тогтворгүй байдал үүсч Засгийн газрын гишүүдийн зарим нэг эсвэл бүгдээрээ солигдвол эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь богино хугацаанд сөрөг байхаар байна. Зах зээлд үүсээд байгаа тодорхойгүй байдал даамжирч хугацаа алдах, зах зээлийн итгэл улам сулрах үр дагаврыг авчирч болзошгүй.

Оюу Толгойн далд уурхайн санхүүжилт шийдэгдэхгүй байгаа нь бодит эдийн засагт үзүүлэх нөлөөлөл шууд утгаар бус, харин гадаад хөрөнгө оруулагч нарын итгэл сэргэхэд гол саад болж байгаа учир сөрөг нөлөө үзүүлэх гол хүчин

зүйл хэвээр байна. Хууль эрх зүйн орчин, татварын дэглэм зэрэг олон наашгай өөрчлөлт гарч байгаа хэдий ч гадаадын хөрөнгө оруулагчид Оюу Толгойн шийдвэрийг хүлээж хөрөнгө оруулахаар яарахгүй байна.

Хөрш орнуудын төрийн тэргүүнүүдтэй Монголын эдийн засагт чухал нөлөө үзүүлэх хэлцлүүдийг хийж чадвал энэ он дуустал эерэг нөлөө авчрах боломжтой. Үүнд зам барилга, нүүрс, эрчим хүч, шатахуун зэрэг голлох чиглэлээр хамтын ажиллагааны тохиролцоонд хүрэх, мөн төгрөг-юаны своп зэргийг дурдаж болох байна.

Мөн мөнгөний бодлогыг чангаруулах шийдвэрийг өнгөрсөн долдугаар сарын сүүлээр гаргасаны нөлөө эдийн засагт, тодруулбал инфляци, валютын ханшны тухайд тодорхой хугацааны хоцролттой буюу энэ оны сүүл рүү мэдрэгдэх төлөвтэй байна.

2014 оны гүйцэтгэлийн таамаг

2014 онд хамгийн их нөлөө үзүүлэх байсан Оюу Толгойн далд уурхайн санхүүжилтийн хэлцэл өнгөрсөн зургадугаар сард хийгдэх байсан боловч дахин хойшилсон нь Монголын эдийн засаг дахь эмзэг байдлыг даамжруулж макро эдийн засгийн үзүүлэлтүүд оны сүүл гэхэд төдийлөн сайн гарч чадахгүйд хүргэх боллоо.

2014 оны ДНБ өсөлт нь бидний 2013 оны сүүлээр таамаглаж байснаас бага буюу 6.3 хувь руу бууж ирэх төлөвтэй байна.


Экспортын бүтээгдэхүүний эргэлт сайжраагүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхгүй байгаа тул ам.долларын дотогш чиглэсэн урсгал тоймтой байдлаар нэмэгдэж өсч чадахгүй байгаагаас долларын ханш үргэлжлүүлэн чангарах төлөвтэй байна. Гэхдээ БНХАУ-ын Төвбанктай своп хэлцэл амжилттай хийгдвэл тренд өөрчлөгдөх боломжтой болно.

Инфляцийн өсөлтийг тогтоох, ханшийг тогтворжуулах зорилгоор Монголбанкнаас мөнгөний хатуу бодлого хоёрдугаар хагаст явуулж эхэлсэн. Гэхдээ инфляцийн бүтцээс харахад нийлүүлэлт талын буюу долларын чангаралтаас үүдсэн инфляци давамгайлж байгаа тул төдийлөн хүчтэй үр нөлөө үзүүлж чадахгүй байх магадлалтай.

Ам. долларын ханшийг барихын тулд төгрөгийн нийлүүлэлтийг хумих, үүний тулд Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй үнэ тогтворжуулах хөтөлбөрүүд болон хөгжлийн банкны зээл олголтыг царцаах нь өмнөх жилүүдэд бодлогоор дэмжиж ирсэн секторуудын өсөлтийг үгүй хийх сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Үүн дээр төсвийн хэмнэлт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц саарахаас гадна зах зээлд төлбөрийн чадварын асуудал нэмж үүсгэхээр байна.


Эдийн засгийн эрчимжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нэлээд олон арга хэмжээ авагдаж, татвар, хуулийн орчинд өөрчлөлтүүд орж байгаа хэдий ч тэдгээрийн нөлөөлөл 2014 оын хоёрдугаар хагаст бодит бизнесийн секторт мэдрэгдэж амжихааргүй байна. ■

ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын жилийн инфляци



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2014 онд голлох үзүүлэлтүүд ямар байх талаар "Мандал"-аас гаргасан төсөөлөл

Үзүүлэлт	2013 оны таамаг	2013 оны урьдчилсан гүйцэтгэл	2014 оны таамаг (2013 оны эцсээр хийсэн)	2014 оны таамаг (хагас жилээр шинэчилсэн)
ДНБ-н өсөлт, хувь	10%	11%	10%	6.3%
Инфляци, хувь	10%	11%	12%	17.5%
Зээлийн хүү, хувь	18%	18.6%	18%	18.5%
USDMNT, оны эцэст	1,700	1,716	1,900	1,800*
Чанаргүй зээлийн хэмжээ, хувь	8%	5.3%	6%	6%

**- БНХАУ-ын Төвбанктай төгрөг-юаны своп хэлцэл хийгдсэн нөхцөлд*
Эх сурвалж: "Мандал Ассет Менежмент"

Сөрөг үр дагавар		Бага зэрэг	Дунд зэрэг	Өндөр
	Өндөр	Гадаад хөрөнгө оруулалтын гадагш чиглэсэн урсгал	• Оффис барилгын сегмент зэрэг барилгын салбарын зарим сегментийн талаарх санаа зовоосон асуудал	• Хувийн хэвшилд Засгийн газрын оролцоо асах их • Төсвийн томоохон алдагдал • Улсын өр өсөн нэмэгдэж буй • Валютын ханшийн тогтворгүй байдал Өсөн нэмэгдэж буй инфляци
	Дунд зэрэг	• БНХАУ-ын Засгийн газрын бодлого Монголд тааламжгүй байх	• Банкнуудын хөрвөх чадвар муудах • Зээл авах боломж ховордох, эдийн засгийн эргэлт буурах • Чанаргүй зээл нэмэгдэх, банкны салбар тогтворгүй болох	• Дэлхийн зах зээл дээр таваарын ханш унах • Гадаад худалдааны алдагдал нэмэгдэх ОХУ-аас импортолдог түлшний үнэ нэмэгдэх
	Бага зэрэг	• Хөрш орнуудын халдварт өвчний тархалт Байгалийн гамшиг		Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаа
		Бага зэрэг	Дунд зэрэг	Өндөр
		Болох магадлал		



АМЕРИК ДАХЬ МОНГОЛЧУУДЫН

ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ-2014

2014.10.11-12-НД

АНУ. ЧИКАГО ХОТ

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

АМЕРИК ДАХЬ МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБОО

МЭДЭЭЛЛИЙН ТҮНШ:

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛ

ХОЛБОО БАРИХ: 94092904

WWW. HTTP://CAREERFAIR.OYUTAN.ORG/

БОНД

“ЧИНГИС БОНД”-ЫН ЗАРЦУУЛАЛТ

С.АЗ

Манай улс 1.5 тэрбум “Чингис” өрийн бичгийг олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалсан. Энэ мөнгөнийхөө ихэнхийг бүтээн байгуулалт болоод хөдөө аж ахуйн салбарт зарцуулж буй. Тэгвэл бондын хөрөнгийг ямар компаниудад өгсөн нь олон нийтэд тодийлэн ил бус байгаа. Тиймээс манай сэтгүүл “Чингис” бондоос ямар аж ахуйн нэгж хэдэн төгрөгийн зээл авсныг цувралаар хүргэх юм. Энэ удаа бид хөдөө аж ахуйн салбар болоод нийслэлд хэрэгжүүлсэн “Гудамж” төслийн хүрээнд хэчнээн компанид хэдэн төгрөг өгснийг дэлгэрэнгүй нийтэллээ.

Нийт эх үүсвэрээс олгосон зээл/салбараар /тэрбум төгрөг/

Хэрэгжүүлэгч	Батлагдсан дүн			Олгосон зээлийн дүн			Эргэн төлөгдсөн дүн	
	Чингис бонд	ХБ-ны эх үүсвэр	Нийт	Чингис бонд	ХБ-ны эх үүсвэр	Нийт	Чингис бонд	ХБ-ны эх үүсвэр
ЗТЯ	1,055.9	406.3	1462.2	745.9	253.5	999.4	131.9	17.5
НЗДТГ	399.1	90.8	489.9	57.5	76.2	133.7	-	
БХБЯ	279.4	119.2	398.7	131.8	111.3	243.1	-	1.5
УУЯ	44.7	296.5	341.2	0	296.2	296.2	-	1.8
ЭХЯ	153.7	169.2	322.9	86.0	110.3	196.3	-	
ҮХААЯ	270.7	14.2	284.9	270.7	6.3	277.0	-	
Эрдэнэс МГЛ		170.6	170.6	0	170.6	170.6	-	
СЯ		80.0	80.0	0	80	80.0	-	
ХЯ		50.0	50.0	0	48.5	00	-	1.6
НИИТ ДҮН	2,203.50	1,396.70	3,600.20	1,292.10	1,152.90	2,444.90	131.9	22.4

“Гудамж” төсөл-Уулзварын шинэчлэлт /тэрбум төгрөг/

№	Уулзварууд	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
1	Өргөө кино театрын урд уулзвар	Пабликроуд ХХК	1.6	1.6
2	НТВ ТВ-ийн арын уулзвар	Пауэр ложистикс ХХК	1.0	1.0
3	Дарь эхийн уулзвар	Экспресс зам ХХК	1.4	1.4
4	Ажилчны гудамжны уулзвар	Цүүрдэн ХХК	0.9	0.9
5	Халдвартын уулзвар	Готик голд ХХК	1.1	1.0
6	10-р хороололын уулзвар	Скай стар ХХК	1.2	1.2
7	Дамбадаржаагийн уулзвар	Арц суврага ХХК	0.3	0.3
8	ТЗ-ындээд сургуулийн урд уулзвар	Дагшин харгуй ХХК	0.4	0.3
9	3,4-р хорооллын эцсийн уулзвар	Пабликроуд ХХК	1.4	1.3
10	Саппорогийн уулзвар	Наранбулагхан ХХК	2.4	2.4
11	Тасганы уулзвар	Төгс зам ХХК	1.5	1.4
12	Бөхийн өргөөний уулзвар	Төгс үржих зам ХХК	1.0	0.9
13	25-р эмийн сангийн уулзвар	Би Ти Өү ХХК	1.1	0.9
14	Циркийн хойд уулзвар	Велдедлайне Монголиа ХХК	0.8	0.8
15	ТЭЦ-3 уулзвар	Рок Пэйнт ХХК	1.2	1.1
16	Гэмтлийн эмнэлгийн уулзвар	Экспресс зам ХХК	4.1	4.0
17	Уулзварын зурагтөсөл		0.7	0.5
НИЙТ ДҮН			22.0	20.9

“Гудамж” төсөл/Гэр хорооллын гудамж, зам

тэрбум төгрөгөөр

	Ажлын нэр	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
1	ДЦС 3-Атар өргөө ХХК 1.3 км зам	Наранбулагхан ХХК	4.2	3.7
2	ДЦС 3-Яармагийн гүүр 1 км зам	Монроуд ХХК	1.9	1.7
3	ДЦС 3-Яармагийн гүүр 1.5 км зам	Эрдэнэ зам ХХК	0.1	0.1
4	Монос-Просолиуд ХХК 2.5 км зам	Бадрах ойл ХХК	0.3	0.3
5	Просолиуд ХХК- Нисэх 3 км зам	Арц суврага ХХК	1.0	1.0
6	Гандан- гэр хорооллын зураг	Нью-Урбанизм ХХК	1.5	0.5
7	Авто замын зураг төсөл		0.3	0.2
8	Хүй 7 худаг цогцолбор		14.0	13.2
	НИЙТ ДҮН		23.4	20.6

Гудамж төсөл/Хурдны зам ба төслийн үйл ажиллагаа

тэрбум төгрөгөөр, сая ам.доллар

Ажлын нэр	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
Сэлбийн хурдны замын ТЭЗҮ	Ар Си Эс Си ХХК	Т0.7	Т0.5
Сэлбийн хурдны замын БОНҮ	Нью Ларус ХХК	?0.1	Т0.0
Туулын хурдны замын ТЭЗҮ	Эм Си Пи Жи ар ХХК	Т0.3	Т0.3
Туулын хурдны замын зураг төсөл	Эм Си Пи Жи ар ХХК	Т6.6	Т2.5
Туулын хурдны замын БОНҮ	Нью Ларус ХХК	?0.1	Т0.1
НИЙТ ДҮН		?7.8	?3.4
Үйл ажиллагааны зардал	Төслийн нэгж	Т2.7	Т2.7
Хяналтын зөвлөх	Си Ти Ай	$7.9	$1.9

Ноолуурын салбар

№	Зээлдэгчийн нэр	Банкны баталсан зээлийн дүн		Олгосон зээлийн дүн	
		Тоо	Дүн (тэрбум Т)	Тоо	Дүн (тэрбум Т)
1	Говь ХХК	33 төсөл	7.0	28 төсөл	7.0
2	Гоёо ХХК		6.3		6.3
3	Пи Си Вай ХХК		2.5		2.5
4	Мөнх бумууд ХХК		0.2		0.2
5	ТГ-ТГ ХХК		0.1		0.1
6	Лакс кашмер ХХК		1.6		1.6
7	Анарганган ХХК		0.1		0.1
8	Говь Айгар ХХК		0.2		0.2
9	Гоёл Кашмер ХХК		0.5		0.5
10	National Cashmer LLC		0.5		0.5
11	Жаргал Кашмер ХХК		0.4		0.4
12	Нинжбадрах ХХК		0.1		0.1
13	Түмэн Сүлжээ ХХК		0.2		0.2
14	Их Шанью ХХК		0.1		0.1
15	Мелина Майлд ХХК		0.2		0.2
16	Говь Эрдэнэ Кашмер ХХК		0.3		0.3
17	Цаст согоот ХХК		0.1		0.1
18	Аяаны Хатан ХХК		0.2		0.2
19	Блю Скай Кашмер ХХК		5.6		3.8
20	Баялаг Өлзий ХХК		0.9		0.9
21	Монгол Микрон Кашмер ХХК		1.3		1.3
22	Мөнгөн Пирамид ХХК		0.1		0.1
23	Гурван Сор ХХК		0.4		0.4
24	Хур тогтох ХХК		0.5		0.5
25	Натурал Альфа		0.2		0.2
26	Эрдэнэт Хивс ХХК		13.4		
27	Сувд Кашмер ХХК		0.3		0.1
28	Говь газар ХХК		0.4		0.4
29	Түмний дунд ХХК		0.1		0.1
30	Гэр Оймс ХХК		0.2		
31	Буян ХХК		5.0		
32	ПоносХХК		0.2		
33	Мандал Омо ХХК		0.1		
Нийт		49.0		28.1 ,	

ХАА, Хөнгөн үйлдвэрийн таван салбарт хуваарилсан эх үүсвэр ба олгосон зээл

Салбар	Тогтоолоор батлагдсан дүн	Хөгжлийн банкнаас байршуулсан эх үүсвэр	Голомт банкнаас баталсан зээлийн дүн	Голомт банкнаас олгосон зээлийн дүн
Ноолуурын салбар	$ 68,8	Ж 106,3	Ж 49,0	Ж 28,1
Сүүний салбар	$ 27,7	Ж 43,5	Ж 12,9	Ж 9,5
Ноосны салбар	$ 45,0	Ж 70,7	Ж 34,3	Ж 16,7
Оёдолын салбар	$ 13,5	Ж 21,2	Ж 1,5	Ж 1,4
Хүлэмжийн аж ахуйн салбар	$ 17,4	Ж 27,3	Ж 5,0	Ж 4,5
НИЙТ ДҮН	$ 172,4	Т 269,0	Т 102,7	Т 60,2

Сүүний салбар

№	Зээлдэгчийн нэр	Банкны баталсан зээлийн дүн		Олгосон зээлийн дүн	
		Тоо	Дүн (тэрбум Т)	Тоо	Дүн (тэрбум Т)
1	Хөх Ташуу ХХК	14 төсөл	0.1	13 төсөл	
2	Монтаримал ХХК		2.0		1.2
3	Ундармал Милк ХХК		0.5		0.5
4	Зуун дээж ХХК		0.2		0.2
5	Сүү ХХК		2.8		0.8
6	Хаан Сүү ХХК		0.5		0.5
7	Иттэлт Дайч ХХК		0.5		
8	ТЭСО ХХК		5.0		5.0
	ЦЕХИЙН ТӨСЛҮҮД				
9	Сүүн билэгдэл ХХК		0.1		0.1
10	Зүүн Тэрмэс Хоршоо		0.2		0.2
11	Сум Шиг Ирээдүй ХХК		0.2		0.1
12	Батширээт Сүү ХХК		0.1		0.1
13	ТОМАГТ ЗГБХ		0.1		0.1
14	Милко ХХК		0.8		0.8
Нийт			12.9		9.5

Ноос, Оёдол, хүлэмжийн салбар

№	Салбар	Зээлдэгчийн нэр	Банкны баталсан зээлийн дүн		Олгосон зээлийн дүн	
			Тоо	Дүн (тэрбум.т)	Тоо	Дүн (тэрбум.т)
1	Ноос	Аватекс Кайнар Ноос ХХК	11төсөл	2.1	9 төсөл	
2		Чойр Хайрхан ХХК		1.3		1.3
3		Эко Ноос ХХК		6.4		6.4
4		Хонгор Ноос Экспорт ХХК		3.8		2.0
5		Завхан Сартуул Ноос ХХК		0.3		0.3
6		Ноос Ирээдүй ХХК		1.0		1.0
7		Акс Херо ХХК		0.3		0.3
8		Монгол Нью Айбекс		0.4		0.2
9		Нэхээсгүй Эдлэл ХХК		8.3		4.0
10		Эрдэнэт Хивс ХХК		9.1		
11		Сор Кашмер ХХК		1.2		1.2
		Нийт		34.3		16.7
1	Оёдол	Эксклюсив ХХК	7 төсөл	0.8	5 төсөл	0.8
2		Зорбиом ХХК		0.1		0.1
3		Аминарайсин ХХК		0.4		0.4
4		Цагояа ХХК		0.1		0.1
5		Мөнх мандаг ХХК		0.1		0.1
6		Түшигтэйн зэд хоршоо		0.0		
7		Мөнхийн зүү ХХК		0.1		
		Нийт	1.5		1.4	
1	Хүлэмж	Түмэн Сүйх ХХК	4 төсөл	0.9	2 төсөл	0.8
2		Гринь Вижитал ХХК		3.7		3.7
3		Сэнжит Оюу ХХК		0.2		
4		Арвай илч ХХК		0.2		
Нийт			5.0		4.5	

УУЛ УУРХАЙ

ГЭРЭЛ АСНА, ГЭХДЭЭ...

С.ЗАЯА

Уул уурхай сэргэх үү. Ингэхийн тулд үргэсэсэн хөрөнгө оруулагчдадаа итгэл төрүүлэх ёстойг төр засгийн удирдлагууд ухамсарлаж, энэ чиглэлийн хууль эрх зүйн орчноо таатай болгож эхэлсэн. Нэгэнт унтарсан итгэл сэргэхэд дор хаяж 2-3 жил хэрэгтэй гэдгийг салбарын мэргэжилтнүүд дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрч буй. Өөрөөр хэлбэл, хууль батлагдсанаар асуудал шийдэгдэхгүй. Баталсан хуулиа хэр мөрдөж буйгаас их зүйл хамаарах аж. Дэлхийн зах зээл дээр нүүрс, зэсийн үнэ уналаа. Үүний нөлөө манайд хүнд тусаад байгаа юм. Яагаад гэвэл, Монголын эдийн засаг уул уурхайгаас хамаарч байна. Гэхдээ уул уурхайн салбар ойрын жилүүдэд өсөх хандлага бий хэмээн Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа хэлсэн.

Энэ салбарын шинжээчид уул уурхайн өсөлт бууралтыг ийн тайлбарлаж байна. Ашигт малтмалын салбарт хайгуулаас эхлээд борлуулалт хүртэлх бүх шат эрсдэлтэй гэж үздэг байна. Энэ нь тааж болохгүй үнийн өсөлт бууралтын мөчлөгтөө холбоотой юм. Бусад бизнесийг бодвол хөрөнгө оруулалт өндөртэй ч алслагдсан, дэд бүтэцгүй газар байх нь бий аж. Ийм эрсдэлийг тооцож, хувийн бизнес үйл ажиллагаагаа явуулах ёстой болдог. Уул уурхай хөгжсөн орнууд энэ онцлогт тааруулж бодлогоо уян хатан гаргадаг байна. Харин Монгол ингэж хараахан чадаагүй аж. Учир нь, үүний өмнөх уул уурхайн бүтээгдэхүүний уналтын мөчлөгийг манайх анзаараагүй өнгөрөөсөн гэх. Энэ талаар Н.Алгаа “Манайх дэлхийн зах зээлээс 30 хувь хамаарч байгаа бол үлдсэн хэсэг нь дотоод нөхцөл байдлаас болж байна. Бодлого тогтвортой, бизнесийг дэмжсэн чиглэлд явж байсан бол хөрөнгө оруулалт дайжихгүй, царцах байсан. Гэтэл бид ийм мөчлөг тохиолдох хүртэл бодлогодоо маш их өөрчлөлт оруулсан. Үүнд хөрөнгө оруулагчид эргэлзэж эхэлсэн юм. Гэхдээ гадаад нөхцөл байдал аажимдаа сайжирна. Уул уурхайн мөчлөг 7-10 жилийн дотор яваад байгаа” гэв.

Хөрөнгө оруулагч татахын тулд төрөөс хийж буй бас нэг томоохон ажил нь хууль бусаар олгосон 106 лицензийн асуудлыг түрүүчээс нь цэгцлэх шийдвэр байв. Ашигт малтмалын газрын холбогдох удирдлагуудын 2009, 2010 онд олгосон 106 лицензийг хүчингүй болгож, төр мэдэлдээ авсан нь хөрөнгө оруулагчдыг хүлээлтийн байдалд оруулаад байсан. Дээрх талбайнуудад сонгон шалгаруулалт хийж, компаниудад тусгай зөвшөөрөл олгохоор болжээ.

Энэ талаар Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүгээс тодруулахад “2009 оны Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан, буцаагдсан болон эрдсийн хуримтлалтай талбайд эргэж тусгай »



зөвшөөрөл олгохдоо заавал сонгон шалгаруулалт зарлана гэж заасан. Гэтэл компаниуд тусгай зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа явуулахдаа хуулийн энэ заалтыг зөрчсөн. Үүнийг гурван шатны шүүхээр тогтоож, “Сонгон шалгаруулалтаар олго” гэсэн шийдвэр гаргалаа. Гэхдээ тухайн тусгай зөвшөөрөлтэй талбай дээр ажиллаж байсан компаниуд эд хөрөнгөөрөө тодорхой хэмжээнд хохирсон. Тиймээс энэ асуудлаар тусгайлсан журам гарч байгаа” гэв.

Журамд тухайн тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байсан ажлын зардлаа компаниуд санхүүгийн баримтаараа баталгаажуулан Ашигт малтмалын газраас байгуулагдсан ажлын хэсэгт өгөхөөр заажээ. Ингэж баталгаажуулсаны дараа босго үнийг тогтоох аж. Үүний дараа нийтийн дунд сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөөд буй гэсэн. Гэхдээ өмнө нь ажиллаж байсан компаниуд давуу эрхтэй оролцох юм. Тиймээс тэд босго үнэ төлөхгүй. Харин бусад компани босго үнийн 30-аас доошгүй хувийг төлж байж шалгаруулалтад оролцох эрхтэй болох юм. Босго үнийн хэмжээ талбай бүрт харилцан адилгүй байх аж. Тодруулбал, хамгийн багаар тогтсон босго үнэ 20 гаруй сая төгрөг бол өндөр нь 410 сая төгрөг юм байна.

Үүнээс гадна хөрөнгө оруулагчдыг гацаанд оруулаад буй нэг зүйл нь шинээр хайгуулын лиценз хэзээ олгох бол гэсэн хүлээлт. Засгийн газраас “Урт нэртэй” хуулийг хэрэгжүүлэхийн тулд 200 гаруй шороон ордын лицензийн үйл ажиллагааг хоёр жилээр зогсоогоод байгаа. Энэ хүрээнд зөвхөн нөхөн сэргээлт хийх үүрэг өгсөн. Гэтэл хоёр жил нь дууссан ч үйл ажиллагааг нь явуулахгүй байсаар буй. Тухайн компаниуд олборлолт явуулж мөнгө олж байж, нөхөн сэргээлт хийнэ. Мөн Засгийн газар нөхөн сэргээлт хийлгэхийн тулд компаниудад хохирлыг нь өгөх ёстой. Тэгж чадахгүй байгаагаас аль аль талдаа байдал гацчихаад байгаа аж.

УИХ хаврын чуулганыхаа төгсгөлд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуульд хувийн хэвшлийг боомилоод байгаа заалт тэр бүр алга байгааг салбарын төлөөлөл хэлсэн. Бас илэрхий сайн болгосон заалт ч төдийлэн их биш аж. Бодлого, хуулийг хэрэгжүүлэхэд яамны дэргэд орон тооны бус бодлогын зөвлөлтэй байхаар хуульчилсан. Зөвлөл төр, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн төлөөлөлтэй байх аж. Энэ нь төрөөс гарах бодлого, шийдвэрт хувийн хэвшлийн санал бодлыг тусгахад ойртуулах алхам болсон гэж судлаачид үзэж байна. Өмнөх хуульд тусгай зөвшөөрлийн төлбөрөө төлөөгүй бол лицензийг цуцалдаг байсан. Энэ заалт хатуу хэрэгждэг, Захиргааны хэргийн шүүхэд ханддаг гээд үл ойлголцох байдал их гардаг байжээ. Харин шинэ хуулиар уг заалт уян хатан болсон байна. Өөрөөр хэлбэл, 30 хоногийн хугацаа өгч, энэ хооронд тухайн лиценз эзэмшигч алданги тооцуулан төлбөрөө төлөх боломж бүрдсэн аж.

Уул уурхайн өсөлт уруудсан сүүлийн хоёр жилд манайх хөрөнгө татах гэж олон арга хэмжээ авч байна. Гэхдээ ийм мөчлөг дагасан эдийн засаг бус баялаг бүтээдэг салбаруудаа хамтад нь хөгжүүлбэл болзошгүй хүндрэлүүдээс сэргийлж чадах гарц болох юм. ■



Фотог С.Заяа

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ

ЭРЭЭНИЙ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЖИШИГ

Д.БАЯР

Булганы Сайхан суманд сайхан намар болж байна. Анхдагчдыг төрүүлсэн сум гэдгээр хүмүүс андахгүй. Дэлхийн олимпийн аварга Н.Түвшинбаяр уугуул иргэн нь. Х.Эрдэнэт-Од мөн энэ сумынх гэх мэтчилэн соёл, урлаг, спортын олон анхдагчууд Сайханаас төржээ. Тэгвэл тус сум уул уурхайн салбарт Монголдоо анхдагч гэж хэлж болохуйц ажлыг эхлүүлэн хийгээд буй аж. Булган аймгийн ИХТ-ийн дарга Д.Батсайхан “Манай аймаг анхдагч гэдэг нэрээ дахин баталлаа. Энэ бол Монголд анх удаа нүүрсний уурхайн нөхөн сэргээлтийг цогцоор нь Эрээний уурхайд хэрэгжүүлсэн явдал юм” хэмээн тодотгон хэлсэн юм.



Эрээний уурхайн 18 га талбайд нөхөн сэргээлт хийснээр хадлан авч эхэлжээ

Хар тарвага ба Эрээний уурхай

Булган аймгийн Сайхан сумын нутагт Эрээний уурхай бий. Нутгийн малчид Эрээн уулынхаа баялгийг анхлан олж мэдсэн гэдэг. Сайхан сумын малчин Гончиг Эрээн ууланд олон үеэрээ нутаглаж ирсэн бөгөөд тарваганууд хар өнгөтэй, хар судалтай, өвс хүртэл хар судалтай байгааг анзааран харж, нүүрсний нөөц байж болохыг олж илрүүлсэн байна. Энэ бол малчдын нутгаа таньж мэддэгийн жишээ. 2003 оноос “Илчит метал” компани нүүрсний уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол дэлхийн уул уурхайн томчуудын нэг АНУ-ын Пийбоди Монголыг сонирхон орж ирсэн цагаас Эрээний уурхайн талбайд нөхөн сэргээлтийн сайн туршлагыг нэвтрүүлэхээр ажиллажээ.

Тус компани уул уурхай байгальд сөрөг нөлөөтэй ч бас сэргээдэг, байгалийн унаган төрхөнд оруулах, цаашилбал өмнөхөөс ч илүүгээр сайжруулах боломжтой гэж үздэг, эрхэм зорилгоо ч ингэж тодорхойлдог. Пийбоди Энержи 2009 оноос баялгийг нь ашигласан нүхэн цооногууд, ногоон хөрс нь улаан болсон Эрээний уурхайн 18 га талбайг нөхөн сэргээхээр олон улсын болон дотоодын 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлжээ. Хамгийн гол нь шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлаж техникийн болон биологийн нөхөн сэргээх ажлыг явуулахад гол анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал, талбайн хөрс, ургамалан бүрхэвчийг бүрэн нөхөн сэргээх, ургамал амьтны өсч үржих нөхцөлийг хангах, байгалийн нөөц, ундны усны эх үүсвэрийг хадгалах, сургалт судалгаа, орон нутгийн болон байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах гэх мэт чиглэлээр үе шаттай нарийн судалж, шинжлэх ухааны үндэстэй шийдвэрт тулгуурлан ажиллажээ. Таван жилийн туршид явуулсан бодлого, баримталсан чиглэл, их хөдөлмөр, сэтгэлийн үр дүнд уурхайн ашиглагдсан газар ногоон өнгөөр хучигдаж, ургамал цэцэгс ургаж, байгалийн төрхөөрөө л харагдах хэмжээнд хүрсэн байна.

Ухсан нүхээ шороогоор дүүргээд дээр нь хэдэн ургамал тарьснаа нөхөн сэргээсэн гэдэг нь монголчуудын ойлголтыг Эрээний уурхайн нөхөн сэргээлт өөрчилсөн тухай мэргэжилтнүүд ярьж байв. Өөрөөр хэлбэл, тус компани Монголд нөхөн сэргээлтийн олон улсын стандартын »

жишгийг тогтоож өгчээ.

Сайхан сумын Засаг дарга Н.Мэнд-Амар “Эрээн уул маань яг л өмнөх шигээ л болсон байна хэмээн нутгийн малчид ярьдаг. Ер нь энэхүү нөхөн сэргээлт манай нутагт сэтгэлгээний өөрчлөлт хийсэн” гэв. Дөрвөн улиралд нүүдэллэн амьдрах нутаг уурхайн саварт орж, уул толгод нь хар нүх, овоолсон шороо болон үлдэхийг хараад сэтгэл зүрх нь эмтэрдэг байснаа нутгийн малчид ярих.

Харин газар нутгийг нь ухсан ч бас сэргээж болдогийг малчид харж байна. Зөвхөн нутгийнхан бус Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжид, Хүнс, хөдөө аж ахуйн яам, мөн Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд газар дээр нь очиж харлаа. Бүр нөхөн сэргээгээд хадлан авч, ашиг тусыг нь хүртэж буй бодитой жишээг үзлээ. Өнгөрсөн жил 18 га-гаас 40 тонн, энэ жил 20 тонныг хадаад байгаа аж. Өнөө жил талбайн өвсийг бүрэн хадахгүйгээр тэнд амьдрах амьтан, малд зориулан тодорхой хувийг үлдээсэн байна. Нөхөн сэргээлтийн талбайгаас байгалийнхтай харьцуулахад дөрөв дахин их хадлан хурааж байгаа аж. Энэ нь нөхөн сэргээсэн га-д ургац илүү ургаж буйг харуулна. Пийбоди Энержи компаниас хадлангийн хэрэгцээнд зориулж, Беларус улсад үйлдвэрлэсэн 80 морины хүчин чадалтай, цагт 13 тонн өвс прэслэгч машиныг суманд бэлэглэсэн. Тус компани сумын хөгжилд хувь нэмэр оруулж, хариуцлагаа ухамсарлаж ажилладаг талаар сумын Засаг дарга Н.Мэнд-Амар онцолсон. Мөн орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдтэй хамтын ажиллагаа тогтоож, ойлголцлын дотно гинжин холбоог бий болгож ажилласан нь өнөөдрийн үр дүнг авчирсан бөгөөд энэ нь хариуцлагатай уул уурхайн хамгийн гол баримталдаг, мөрддөг зарчим аж.

БОНХ-ийн сайд С.Оюун “Бид нүүрс олборлож байгаа болон, хажууд нь нөхөн сэргээсэн талбайг харж байна. Харьцуулахад хангалттай жишээ. Мэргэжилтнүүдийн хэлснээр 40 метр ухсан гүн нүхэн талбайг олон улсын стандартын дагуу нөхөн сэргээснийг харахад баяртай байна. Монгол Улсад уул уурхайн нөхөн сэргээлтийн жишиг, үлгэр жишээг бий болгосон нь туйлын ач холбогдолтой” гэв.

Манай улс 2008 оноос өмнө уул уурхайн талбайг нөхөн сэргээхэд чиглэсэн дорвитой стандартгүй явж ирсэн гэхэд хилсдэхгүй. Харин таван жилийн өмнөөс ихэнхдээ алтны шороон ордод тулгуурлаж гаргасан нөхөн сэргээх таван стандарт баталсан байдаг.

“Манай яам сүүлийн жилүүдэд уул уурхайн нөхөн сэргээлтийг шинэ шатанд гаргах үүднээс стандартууд боловсруулж долоог нь Стандарт, хэмжил зүйн газраар батлуулаад байгаа. Монгол компаниудад сэтгэл байна. Гагцхүү мэдлэг, мэдээлэл, чадвар хэрэгтэй. Тиймээс Уул уурхайн яамтай хамтраад уул уурхайн нөхөн сэргээлтийн сургалт судалгааны төв байгуулах гэрээнд гарын үсэг зурсан. Мөн тус яамтай хамтран уурхайн олборлолт явуулаад нөхөн сэргээгээгүй хаясан талбайг судлахад 6000-10000 гарсан тоо байна. Хаана ямар газар, хэн гээч эзэнтэй компанийн орд буйг судалж хариуцлага тооцох, нөхөн сэргээх, арга хэмжээ авах дараагийн алхам руу орж байна” хэмээн С.Оюун сайд ярив.

Эрээний уурхайн нөхөн сэргээсэн талбайд өнөөдөр 40 гаруй зүйлийн байгалийн ургамал, 28 төрлийн шавьж, 31 зүйлийн шувуу, таван зүйлийн хөхтөн амьтан нутагшаад байгаа аж. Мөн нөхөн сэргээлтийн явцад цөөрөм, гүний худгийг байгуулах замаар мал, амьтны уух усны асуудлыг шийджээ. Цаашдаа тухайн бүс нутагт нэн ховордсон амьтдыг нутагшуулах, эмийн болон бусад ховор ургамлыг тарьж ургуулахад анхаарч ажиллах талаар Булган аймгийн ИХТ-ын дарга Д.Батсайхан хэлнэ лээ. Үндсэндээ 2010 онд нөхөн сэргээх үндсэн ажлуудыг хийж дууссан ч уг талбайд мониторинг судалгааг байнга хийсээр ирсэн байна. ШУА, ШУТИС, ХААИС-ийн ургамал болон амьтан судлалын багш, эрдэмтэн судлаач, оюутнууд Эрээний уурхайг нөхөн сэргээхэд тодорхой үүрэг гүйцэтгэж, идэвхтэй ажиллажээ. Энэ ч утгаараа энэхүү 18 га талбай нь эрдэм шинжилгээний, судалгааны, дадлагын томоохон бааз болж буй ач холбогдолтой.

“Энэ бол Пийбодигийн Монгол Улсын хөгжилд оруулж буй хувь нэмэр. Нөхөн сэргээх явцад алдаа оноо байсан. Монгол орны онцлогт тохирсон туршлага хуримтлуулж, бид бие биеэсээ суралцсан” хэмээн Пийбоди Энержи компанийн Монголын үйл ажиллагааг хариуцсан Ерөнхийлөгч Аршад Саиед тэмдэглэлээ.



Эрээний уурхай. Нөхөн сэргээлт хийхээс өмнөх дүр зураг

Пийбодигийн туршлага

Миний бие УИХ-ын гишүүдийн хамт 2008 онд АНУ-ын Денвер дэх Пийбодигийн Wyoming нүүрсний уурхайн нөхөн сэргээлттэй очиж танилцаж, сурвалжилж байв. Монголын уул толгодтой төстэй уул, ус, ургамалтай газрын доорх баялгийг аваад ашиглачихсан гэж хэн ч бодохооргүй нүд баясгасан үзэсгэлэнт Павдорын хөндий биднийг угтсан юм. Өнгийн цэцэг алаглаж, ховор амьтан идээшин бэлчих хөндийг хараад манай УИХ-ын гишүүд газрын доорх баялгийг нь ухаад авсан нь үнэн үү хэмээн дуу алдаж билээ. Хүмүүсийг гайхан биширтэл нөхөн сэргээлт хийх нь Пийбодигийн эрхэм зорилго. “Манай компани уул уурхайн эдэлбэр газрыг нөхөн сэргээснээр эргэж хэвэнд нь оруулж болдог юм гэдгийг харуулахын төлөө ажилладаг” хэмээн Пийбодигийн удирдлагууд ярьсан юм. Яг энэ зарчим, эрхэм зорилго, арга барил, үйл ажиллагаа Эрээний уурхайд ч хэрэгжиж, талын Монголын уурхайн ашиглалтад өртсөн газрыг хүсэл, сэтгэл байвал нөхөн сэргээж болдгийг үүгээр харууллаа.

Уул уурхай Монголын газар нутгийг сүйрүүлж байна гэсэн ойлголт, мэссэж газар авсан энэ үед бас нөхөн сэргээлтийг олон улсын стадартын дагуу хийж, үлгэр жишээ үзүүлж буй сайн мэдээг сэтгүүлч бид уншигчтайгаа хуваалцаж талархдаг байх ёстой гэж бодсоны үндсэн дээр энэхүү сурвалжлагыг хийлээ.

Пийбодигийн дэлхийн шилдэг зарчмаас дурдвал:


- -Уурхайн зөвшөөрөл, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулдаг;
- - Байгаль орчин нөхөн сэргээлтэд тэргүүн туршлага ашиглаж нэвтрүүлдэг;
- -Орон нутагт сайн хөршийн харилцаанд үндэслэн ажилладаг;
- -Тэргүүн туршлага, тэдгээрийн үр дүнг байнга түгээн дэлгэрүүлдэг.

Дэлхийн нүүрсний зах зээлд 131 гаруй жилийн түүх бүтээсэн хувийн хэвшлийн Пийбоди компани Монголд орж ирээд долоон жил болжээ. Энэ хугацаанд уурхайн нөхөн сэргээлтийг дэлхийн түвшинд хийдэг, туршлагаа харуулахын тулд Эрээний уурхайг сонгон авч, ажилласан нь энэ. Тус компанийн нэг гол зорилго бол Тавантолгойн ордыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд хамтарч ажиллах явдал. Энэ чиглэлээр хамтран ажиллах саналаа манай Засгийн газарт хэдийнэ өгсөн. Одоо Тавантолгойн асуудлыг хэрхэн шийдэхийг хүлээсэн байдалтай байгаа юм.

“Нүүрсний салбарт олон жил ажилласан баялаг туршлагадаа тулгуурлан Пийбоди нь Тавантолгойн орд газрыг үр ашигт чиглэсэн, зах зээлийн зарчимд тулгуурласан байдлаар хөгжүүлэх нь хамгийн оновчтой арга зам болохыг дэмжиж байгаа. Төслийг хамгийн үр ашигтайгаар амжилттай хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газраас сонгох Монголын болон бусад орны аж ахуйн нэгжүүдтэй үр дүнтэй, нягт хамтран ажиллахад Пийбоди бэлэн” хэмээн Аршад Саиед ярьсан юм. ■

ЕГӨӨ ҮГ

АЛТАН ХАРААЦАЙН ҮЛГЭР *(памфлет)*



А.АМАРСАЙХАН (Шог зураач, зохиолч)

Ерэн онд хэдэн хөөрхөн алтан хараацай гарч ирснээ, “Монголчууд бид дарга нэртэй мангасуудын захиргаадалтын дор, эрх чөлөөгүй, үгээгүй хоосон амьдарч байна. Хувьсгал хийцгээе!” гэж чанга хашгирсан. Хонхны дуут орон даяар хангинуулж, мангасуудын хойдохыг уншсан. “Чухам дарга нарыг л зайлуулах аваас монголчууд бид эрх чөлөөтэй, амар амгалан, баян цатгалан, эрүүл саруул амьдарна” гэсэн. Энэ үг үлгэр мэт сайхан сонсогдож, үй олон хүн үүнд автаж, татагдаж, итгэсэн. Ард түмэн хараацайн үгийг дагаж ялгуулсан их ▸▸

хувьсгал хийн, улаан мангасыг даран сөнөөсөн бөлгөө. Гэвч тэр үлгэр шиг сайхан амьдрал нь ирээгүй л...

Хараацай болгоны амнаас юмны түрүүнд унадаг байсан нэгэн үг бий. “Хэтэрхий олон дарга ард түмний хүзүүн дээр сууж байна. Ийм олон мангас бидэнд хэрэггүй! Огцорцгоо! Далдарцгаа!” гэж тэд хашгирч байсан. “Хүнд суртлын нүсэр аппарат, олон ёроолгүй гүзээг тэжээснээс Монгол улс үгүйрэн хоосорч байна” хэмээсэн. Тэр үеийн Улс төрийн товчоо гэгчид нь есөн мангас суудаг, арав хүрэхгүй яамтай байхад энэ үгийг хараацайнууд хэлж байж!

Гэтэл одоо энэ тоо хэд болсон билээ? Улсын их хурал гэгчид нь далан зургаан гүзээ сууж байна. Хориод яаманд хорин хэдэн сайд сэнтийлдэг. Түүгээр ч барахгүй дэд сайдууд гэх сайдаасаа дутахгүй том гүзээтнүүд бий. Газар, агентлагийг тоолох гэвэл сампингийн эрих хүрэлцэхгүй. Өнөөх хараацайнууд одоо өөрсдөө цондойсон хөөрхөн гүзээтэй болоод ерөнхийлөгч, их хурлын дарга, ерөнхий сайд, хотын захирагчийн сэнтийд залраад, “Олон дарга огцор!”, “Хүнд суртлын нүсэр аппаратыг устга!” хэмээсэн цогтой халуун үгээ таг мартчихсан сууна. Дарга нар байр савандаа багтахаа байж, хуучны яам тамганы дэргэд тэнгэр баганадсан өндөр шилэн барилгууд босгоцгоожээ.

“Монгол хүн эх орныхоо эзэн байж, эрх чөлөөтэй амьдарна!” гэж хараацайнууд чанга жиргэсэн. Ямар гоё вэ? хэмээн зон олон бүгдээр дуу алдсан. Гэтэл яав аа? Малчин Гомбо төрсөн довныхоо эзэн байж, хөдөөдөө амьдаръя гэхээр Дамба гишүүний уул уурхайн компани өвөлжөөг нь өрлөөд, зусланг нь зураад, хашаа хороогоор битүүлээд буутай манаа зоочихно. Аргаа барсан Гомбо хот руу нүүнэ. Түүнд 0,5 га бүү хэл гадас хатгах ч газар олдохгүй. Амьдрахын эрхэнд уулын оройд гэрээ барьтал хорооны түшмэл, “Зөвшөөрөлгүй”, “Үерийн ам”, “Өндөр хүчдэлийн шугам” гэж хөөнө. Эрхэм гишүүн Дамба харин хэдэн зуун га газрыг чөлөөтэй аваад, орон сууцны хороолол барьчихсан амандаа багтахгүй үнэ хэлэн хаахалзана. Эрх чөлөөтэй, эх орны эзэн болгох гэх үг бас л үлгэр.

“Хаад ноёд, харц ард бүгдээр эрх тэгш байна!” - энэ бас л тэдний үг. Гэвч амьдрал дээр ямар болчихоод байгаа билээ? Нийслэлийн дугаар хорооны иргэн Гомбо Улсын их хурлын сонгуульд нэрээ дэвшүүллээ гээд яах юм бэ? Ядахдаа арван ширхэг ухуулах хуудас хэвлүүлэх мөнгө түүнд бий бил үү? Эрхэм гишүүн Дамбад харин бүх зүйл нээлттэй. Мөнгө хөрөнгө, танил тал бий.

Төрийн түшээ улсын 14 тэрбумаар тоглочихсон байтал хэрэгсэхгүй. Энгийн хүн 10 мянган төгрөг авсны төлөө арван жилийн ял сонсоно. Улсын их хурлын гишүүн, хаад ноёд халдашгүй дархан эрхтэй. Гэмт хэрэг хийж байхад нь үйлдэл дээр нь, хэдэн гэрчтэйгээр баривал л эрхэм гишүүнд хэрэг үүсгэх магадлалтай. Харц ард, жирийн иргэн бол сэжигтэй харагдсаныхаа төлөө нэгжүүлж шалгуулж, өчнөөн доромжлол амсана.

Тэд “Ард иргэдээ ардчилсан нийгэмд, эрүүл саруул, амар жимэр аж төрүүлнэ” гэцгээсэн. Хувьсгал ялаад 24 жил боллоо. Хэдэн цэцэрлэг, хэдэн сургууль, хэдэн эмнэлэг барьж, ард иргэдээ амар жимэр, эрүүл саруул амьдруулав аа? Өнөөх захиргаадалтын бурангуй балар үед баригдсан сургууль эмнэлгүүд элэгдээд дуусч байна. Цаашдаа яах юм, бүү мэд. Таван залууг зүгээр л гудамжаар гүйж явсных нь төлөө төр нь өөрөө буудчихсан.

Мангасуудын үед төрийн аппаратад ажилтан авахдаа боловсрол, мэдлэг чадварыг нь шалгаж, намтар түүхийг нь судалж, өндөр шалгуур тавьдаг байсан. Хэр баргийн хүн засгийн ажилд тэнцдэггүй байж. Гэтэл одоо ямар шалгууруар төрийн түшмэдийг авдаг болсон билээ? Ерөнхий сайдын хамаатан эсвэл намдаа мөнгө хандивласан бол хар толгойтой хонийг ч албан тушаалд томилдог болсон. Сайдын суудал тэдэн тэрбум, төрийн нарийных тэдэн зуун сая гэлцэн сандал суудыг наймаалцдаг гэх жиг жуг яриа ч бий. Алдаа гаргасан даргыг хурлаар хэлэлцэж, хатуу донгодож, тушаал бууруулж, амийг нь авдаг байлаа. Одоо тэгтэл хариуцлагын тогтолцоо гэж байна уу? Хэн гэдэг дарга ямар алдаа гаргаад суудлаасаа буусан бэ? Хэлэх ганц ч жишээ байхгүй. Монголын төр дампуурчихаад байгаа.

Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх, Д.Моломжамц, Б.Дэжид гэх мэт өмнөх үеийн дарга нарыг бүгдийг нь “Муу хүмүүс”, “Мангасууд!” хэмээн хараацайнууд буруутган цоллосон. Гэтэл хэрэг дээрээ ямар хүмүүс байлаа? Тэд улсаасаа сэтэрхий тэвнэ ч хумслаагүй. Хувьдаа Аж үйлдвэрийн комбинаттай, Эрдэнэт концернтой байгаагүй. Улсын байранд амьдраад, улсынхаа төлөө бүх бодол санаа, цаг заваа зарцуулан зүтгэж байсан. Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Батмөнх өдөр улсын төлөө ажиллаад, үдэш хувийн бизнесээ амжуулдаг байсан гэвэл түүн шиг худлаа юм үгүй.

Гэтэл алтан хараацайнууд минь ямар байгаа билээ? Нэг хараацай нь хувийн амралт, чацарганы тариалантай, нөгөө нь үнээний фермтэй гээд Монголдоо толгой цохих баян корпораци, группийн эзэн болчихсон хараацай ч хэд хэд бий. Гэтэл та бүгдийн эрх чөлөөтэй, баян болгоно, амирлуулна, жаргаана гэж амласан ард түмний амьдрал ямар байгаа билээ?

Үүнийг бичигч ардчиллыг үзэн яддагтаа биш, ардчиллын төлөө санаа зовдогтоо ийнхүү харуусаж сууна. Ардчилал бидэнд ихийг өгсөн нь маргашгүй үнэн. Өөр зам бидэнд байхгүй гэдэг ч бас үнэн. Гэхдээ байдал нэг л биш. Бараг л эсрэгээрээ гэлтэй. Бид улсаа улам дордуулах гэж тэр хувьсгалыг хийсэн хэрэг үү?

Алтан хараацайнууд бараг л бүгдээрээ амьд сэрүүн байна. Ерэн онд яс арьс болсон туранхай бор залуучууд байснаа одоо подойтол махлаад, тарган цагалан, малийсан цагаан эрчүүд болжээ. Монгол орон ямар болчихоод байгааг тэд сонсож дуулж, үзэж харж, мэдэж мэдэрч байгаа.

Алтан хараацайнууд минь ээ, ичээч! Ерэн онд хэлсэн үгээ эргэж санаач! Тэр үг чинь үлгэр болчихоод байна! гэж л хэлье дээ. ■

Хямралыг ч сөхрүүлэх ухаалаг шийдэл буюу “Шнайдер Электрик”

“Шнайдер Электрик” компанийн цахилгааны технологи, тоног төхөөрөмжийг ашиглах боломж хэрэгцээ манайд үнэхээр их байна.

Б.Уганбаяр

“Эдийн засаг хямарлаа, хүндэрлээ” гэх яриа бидэнд танил болоод жил гаруй хугацааг үдэж байна. Гэхдээ хямралын нэг авуушгай тал нь улс орныг ч, иргэдийг ч хэрэглээндээ хязгаартай хандаж, бүсээ чангалдаг болоход сургаж байгаа билээ. Тэгвэл манай улсын хувьд зайлшгүй хэмнэх нэн шаардлагатай нэг зүйлбол эрчим хүч. Бид эрчим хүчээ үйлдвэрлэж бас импортоор авч байгаа үнээсээ бага үнээр түгээдэг. Жишээ татахад, манайх нэг кВт цахилгааныг дотооддоо 116 төгрөгөөр үйлдвэрлэдэг. Харин ОХУ-аас импортоор 130 төгрөгөөр авч иргэд, аж ахуй нэгжид үүнээс харьцангуй бага буюу алдагдалтай үнээр зардаг. Тухайлбал, айл өрхөд 79.80-96 төгрөгөөр худалдаалж байгаа бол уул уурхайн болон үйлдвэрлэлийн компаниудад үүнээс 20-30 хувиар нэмж эрчим хүчээ борлуулдаг жишигт саяхнаас шилжсэн. Иймдээ ч эрчим хүчний үнийг чөлөөлж, салбараа “аваръя” хэмээн удаан ярьсан ч үр дүн алга. Энэ хэрээр эрчим хүчний салбарын алдагдал өсч, өдгөө 60 тэрбум төгрөг хүрээд байгаа билээ. Нөгөө талд нь хэрэглээ, импорт ч дагаж өссөөр. Сүүлийн гурван жилийн хугацаанд ОХУ-аас авч байгаа эрчим хүчний импорт гурав дахин өссөн гэх тоо бий. 2013 онд манайх өвлийн ид ачааллын үед 878 МВт цахилгаан хэрэглэсэн бол өнгөрсөн өвлийн хувьд 960 орчим МВт цахилгаан хэрэглэхээр тооцоотой байгаа аж. Гэтэл манай улсын цахилгааны хүчин чадал ердөө 739 МВт гэдгийг Эрчим хүчний зохицуулах хорооноос мэдэгдсэн. Өөр нэг асуудал бол төр эрчим хүчний үнийг ийнхүү доогуур тогтоон хүчээр барьж, өнөөдрийг хүрсэн учир иргэдэд “эрчим хүч хямд л байх ёстой” гэсэн сэтгэлгээг суулгасан гэхэд болно. Тэгвэл өрх, улсын төсвөө танадаг шигээ эрчим хүчээ хэмнэж, үр ашиггүй зардлаа бууруулж чадвал эдийн засгийн одоогийн хүнд үеийг давах нэг алхам болох юм.

Боломж ойртсон... ашиглах эсэх нь таны сонголт

Эрчим хүчний үнийг чөлөөлнө гэж үе үеийн Засгийн газар ярьдаг ч төр энэ салбараа “халаас”-наасаа гаргаагүй өдийг хүрч байна. Тэгвэл одоо үнэ чөлөөлөх эсвэл эрчим хүчний шинэ эх үүсвэрээ яаралтай барьцгаая гэж цээжээ дэлдэхээ болъё. Эрчим хүчийг хямдаар хэрэглээд сурчихсан аж ахуйн нэгж, иргэнээ хэмнэлттэй, ухаалаг хэрэглээнд сургая. Энэ чиглэлийн хамгийн үр ашигтай бүтээгдэхүүнийг авч хэрэглэх боломж манай улсад байна. Тодруулбал, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэр, дата төв, сүлжээ, барилга угсралт, орон сууцны зах зээлд зориулан эрчим хүчийг ашуулгүй, найдвартай, үр бүтээмжтэй болгох цогц шийдлээрээ дэлхийд тэргүүлэгч “Шнайдер Электрик” компани манай улсад салбараа нээж, албан ёсны борлуулагч компаниудтай болоод багагүй хугацааг үдэж байна. Оюутолгой төсөл, Чингис хаан олон улсын нисэх буудал, “Энержи Ресурс”, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ зэрэг хувийн болон төрийн өмчит томоохон компанитай хамтран ажилласаар ирсэн.



“Шнайдер Электрик” компанийг 177 жилийн өмнө анх Францын ах, дүү Шнайдер нар гангийн үйлдвэрлэл хийж үүсгэн байгуулсан түүхтэй аж. Тухайн үедээ дэлхий дээрх хамгийн том ган давтдаг алхыг бүтээж, усан онгоц, төмөр замын зүтгүүр үйлдвэрлэж байжээ. Харин Дэлхийн II дайны дараа бизнесийн чиглэлээ өөрчилж, цахилгаан, тоног төхөөрөмж үйлдвэрлэж эхэлсэн байна. Одоогоор тус компани 150 мянган ажилтантай, 100 гаруй оронд салбартай, жилд 30 гаруй тэрбум ам.долларын борлуулалт хийдэг. Гол бүтээгдэхүүний чиглэл нь нам хүчдэлийн болон 50 КВт хүртэлх дунд хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмж, үйлдвэрийн автоматжуулалтын тоног төхөөрөмж, дата төв, үл тасалдах цахилгааны эх үүсвэр зэрэг юм. XXI зуунаас цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж мөн үр ашигтай хэрэглэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж эхэлсэн.

Эрчим хүчийг ухаалаг хэрэглэхэд шаардлагатай програм хангамж системийг мөн үйлдвэрлэж байгаа ажээ.

Таны мөнгө, цагийг хэмнэх ухаалаг шийдэл

“Шнайдер Электрик” компани нь цахилгаан станцаас эхлэн халаагуур, телевиз зэрэг иргэдийн хэрэглээнд хүрэх хүртэлх цахилгааны гүйдлийг үр ашигтай болгох бүрэн автоматжсан технологийг санал болгодгоороо онцлог. Аливаа үйлдвэр аж ахуй нэгж үйлдвэртээ төдийгүй иргэд өөрийн зуслангийн байшиндаа “Шнайдер Электрик” –ийн бүтээгдэхүүнийг хэрэглэснээр эрчим хүчээ 30-70 хувиар хэмнэх боломжтойгоороо давуу талтайг тус компанийн Үйлдвэрлэлийн автоматжуулалтын менежер Б.Чинбаатар онцолсон юм. Тэрээр “Аливаа үйлдвэрт цахилгаан моторын цахилгаан тэжээлийн давтамжийг хувьсган тохируулах төхөөрөмж тавьсанаар эрчим хүчийг 70 хүртэлх хувиар хэмнэх боломжтой. Мөн усны насост ч давтамж хувьсгуур тавьж, моторын эргэлтийг хэрэглээндээ тааруулан тохируулсанаар эрчим хүч хэмнэгддэг. Энэ мэтчилэн танай компани цаашлаад таны гэр, орон сууцны эрчим хүч, дулааны


хэрэглээг тохируулж, зардлыг бууруулдаг өндөр зэрэглэлийн чанартай төхөөрөмжүүд манайд бий" хэмээв. Мөн улайсах чийдэн хэрэглэхээ больж, LED чийдэнг хэрэглэх, гэрлээ автоматаар унтрааж асаадаг болгох, гэрийнхээ дулааны тохируулгыг тааруулах гэх мэт хэрэглээгээ хэмнэх, цаашлаад үүнд урсаж байгаа мөнгийг хэмнэх шийдлүүд "Шнайдер Электрик" компанид байгаа ажээ. Түүнчлэн зөвхөн айл өрх, аж ахуй нэгж төдийгүй улсын хэмжээнд тус компанийн ухаалаг технологиудаас ашиглах боломжтойг "Шнайдер Электрик" компанийн инженерүүд онцолж байна.Тодруулбал, энэ нь төвийн шугамаас ирж байгаа халаалтын хэмийг бидний амьдрах орчинд тааруулан бууруулдаг төвлөрсөн халаалтын систем бүхий автомат удирдлагын систем аж. Үүнийг улсын хэмжээнд ашиглах бүрэн боломжтой юм билээ. Мөн манай улсын цахилгаан түгээх сүлжээний тоног төхөөрөмж хоцрогдсон, аюулгүй ажиллагааны стандарт доогуур байдаг. Тэгвэл ухаалаг, хэмнэлттэй, үр ашигтай эрчим хүчний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гэдгээрээ дэлхийд данстай "Шнайдер Электрик" компанийн тоног төхөөрөмжүүдээс сонголт хийх боломжтой. Манай улс аюулгүй, хэмнэлттэй дээрх бүтээгдэхүүнийг хэрэглэвэл эрчим хүчний салбарын стандарт сайжирч, хэмнэлт бий болно гэдгийг тус компанийн инженерүүд тэмдэглэн хэлж байсан юм. Сингапур, Австрали, Герман зэрэг "Шнайдер Электрик" компанийн салбар байдаг улсуудын Засгийн газар хэмнэлттэй, ногоон хэрэглээг бодлогоор дэмждэг аж. Жишээлбэл, Сингапурын хувьд ногоон байшин барилга барихад хувь нэмрээ оруулсан компаниуд буюу хөрөнгө оруулагчид, барилгын компанид нь татварын хөнгөлөлт үзүүлж, "Ногоон хөгжлийг дэмжигч" хэмээн итгэмжлэл гардуулдаг байна . Манай улсын хувьд эдийн засгийн нөхцөл байдал хүнд,ОХУ –аас импортолдог цахилгааны үнэ өндөр байгаа энэ үед ухаалаг хэмнэлттэй технологийг сонгож ашиглаж хямралаас "булталх" нэг гарц байж болох юм. Хямралыг ч сөхрүүлэх ухаалаг шийдэл "Шнайдер Электрик" компанид байгааг дахин сануулъя.

"Шнайдер Электрик" компаниас саяхан зохион байгуулсан "Нам хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмж" сургалтанд оролцсон хоёр компанийн төлөөллөөс сэтгэгдлийг нь сонссон юм.

Эрчим хүчний үр ашигтай хэрэглээг бид сонгоно

"Эрчим хүч угсралт ТТК" зөвлөх А.Тэрбиш

"Шнайдер Электрик" компанийн цахилгааны технологи, тоног төхөөрөмжийг ашиглах боломж хэрэгцээ манайд үнэхээр их байна. Аюулгүй, өндөр чанар бүрэн автоматжсан гэдгээрээ давуу талтай. Манайд Европ, ОХУ-аас олон технологи орж ирж байна. Гэхдээ "Шнайдер Электрик" компанийн хувьд дэлхийд танигдсан, олон жилийн түүхтэй, чанартай бүтээгдэхүүн гэдгээр нь манай компанийн хувьд итгэж хэрэглэхээр төлөвлөж байна. Ер нь барилгын зураг төслийг сайн хийж, чанартай барилгын материал, бүтээгдэхүүн хэрэглэж байж барилга урт настай, эдэлгээ сайтай болдог. Нөгөө талаас эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай гэдэг нь үнэхээр анхаарал татаж байгаа юм. Эрчим хүчний үр ашигтай хэрэглээг бий болгож байгаа бүтээгдэхүүнийг бид сонгоно.



Ердийн холболтонд шаардагддаг хугацааг 40% хэмнэнэ

Цахилгаан тоног төхөөрөмжид чанар, аюулгүй байдал хамгаас чухал

"Электро комплект" компанийн ерөнхий менежер Б.Батсанаа

Манайх "Шнайдер Электрик" компанийн албан ёсны борлуулагч болоод багагүй хугацааг үдэж байна. Бид цахилгааны тоног төхөөрөмж, кабель, барилга угсралт, цахилгааны кабель, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн чиглэлээр ажилладаг. Цахилгаан, тоног төхөөрөмжид чанар, аюулгүй байдлыг дээд зэргээр авч үзэх ёстой байдаг. Учир нь шууд хүний эрүүл мэнд амь нас, хүрээлэн байгаа орчинтой холбоотой яригддаг асуудал юм. Сүүлийн үеийн хэрэглэгчид хэмнэлттэй, ухаалаг хэрэглээг илүүд үзэх болсон. Иргэдийн энэ хэрэгцээнд "Шнайдер Электрик" компанийн бүтээгдэхүүнүүд бүрэн тохирдог гэж хэлж болно. Учир нь тус тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнүүд аюулгүй ажиллагаатай, угсрахад хялбар, загвар сайтай, тав тухтай орчинг бүрдүүлж өгдөг юм.





Make the most of your energy

Эрчим хүчний Их Сургуульд ҮНЭГҮЙ суралцаж, эрчим хүч хамгийн сайн хэмнэгч болоорой

onomy.mn

www.SEreply.com Key Code 55093M

Schneider Electric

Mongolian Economy SEPTEMBER 2014